МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМ

From the People of Japan

THE WORLD BANK
IBRD • IDA | WORLD BANK GROUP

Save the Children

# “АЛСЛАГДСАН ХӨДӨӨГИЙН МАЛЧДЫН ХҮҮХДҮҮДИЙН БАГА БОЛОВСРОЛЫН ҮР ДҮНГ САЙЖРУУЛАХ НЬ” ТӨСЛИЙН ЭЦСИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Зөвлөх Ц.Эрдэнэчимэг

Улаанбаатар хот
2017 он

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| **ББНОХ** | Бага боловсрол нөхөн олгох хөтөлбөр |
| **БСШУСЯ** | Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам |
| **ГБОСБХ** | Гэр бүлийн орчинд сургуульд бэлтгэх хөтөлбөр |
| **ЕБС** | Ерөнхий боловсролын сургууль |
| **ЗГ** | Засгийн Газар |
| **НҮБХС** | Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сан |
| **НТБ** | Насан туршийн боловсрол |
| **ОНБЗ** | Олон нийтийн боловсролын зөвлөл |
| **СӨБ** | Сургуулийн өмнөх боловсрол |
| **ХБЦНХ** | Хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөр |
| **ТОНЗ** | Төслийн орон нутгийн зөвлөл |
| **ТУЗ** | Төслийн удирдах зөвлөл |
| **ХИС** | Японы Хүүхдийг Ивээх Сан |

# АГУУЛГА

**НЭГ. УДИРТГАЛ**

**1.1 ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ........ 9**

**1.2 ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ ........ 10**

1.2.1. Зорилт 1: Гэр бүлийн орчинд хүүхдийг сургуульд бэлтгэх хөтөлбөр (ГБОСБХ)-ийн хэрэгжилт ........ 10

1.2.2. Зорилт 2: Хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөр (ХБЦНХ)-ийн хэрэгжилт ........ 11

1.2.3. Зорилт 3: Бага боловсрол нөхөн олгох хөтөлбөр (ББНОХ)-ийн хэрэгжилт ........ 12

1.2.4. Зорилт 4: Эцэг эх, олон нийтийн оролцоог хангах ........ 12

**1.3. ТӨСЛИЙН ЭЦСИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, АРГАЧЛАЛ ........ 13**

1.3.1 Төслийн эцсийн үнэлгээний зорилго ........ 13

1.3.2. Төслийн эцсийн үнэлгээний хамрах хүрээ, аргачлал ........ 14

**ХОЁР. ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН**

**2.1. ТӨСЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ДИЗАЙН ........ 18**

2.1.1. Боловсролын салбарын бодлоготой нийцсэн байдал, оруулсан хувь нэмэр ........ 18

А. Сургуулийн өмнөх боловсролын эцэг эхийн оролцоог хангасан хувилбарт сургалтын аргазүйг боловсруулсан. ........ 19

Б. Малчин өрхийн онцлог нөхцөл байдалд нийцсэн байдал ........ 22

В. Хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөр нь дотуур байрын орчин нөхцөл, үйл ажиллагааг сайжруулсан ........ 24

Г. ХБЦНХ-ийн малчин өрхийн онцлогт нийцтэй байдал ........ 26

Д. Бага боловсролыг нөхөн олгоход дэмжлэг үзүүлэх хичээлийн хөтөлбөрийг боловсруулж нутагшуулсан ........ 28

Е. ББНОХ-ийн малчин өрхийн онцлогт нийцсэн байдал ........ 31

2.1.2. Боловсролын салбарын бодлогод оруулсан хувь нэмэр ........ 33

**2.2. ТӨСЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛГЫН БИЕЛЭЛТ, ҮР ДҮН ........ 35**

2.2.1. Гэр бүлийн орчинд хүүхдийг сургуульд бэлтгэх хөтөлбөрийн үр дүн, биелэлт ........ 35

А. ГБОСХ-өөр 4 аймгийн 30 суманд 4 жилд 3,800 хүүхэд сургуульд бэлтгэгдлээ. ....35
Б. Малчдын 5 настай хүүхдүүд СӨБ-д бүрэн хамрагдаж, сургуульд орж байна....37
В. Ном, тоглоомын багц нь хүүхдийг сонирхолтойгоор, бүтээлчээр суралцах чадварт суралцуулдаг .... 38
Г. Хүүхэд, эцэг эхчүүд, багш нарт гарсан өөрчлөлт ....39
Д. Хүүхдүүд СӨБ-ын 6 үндсэн чадварыг бүрэн эзэмшсэн. .... 40
Е. Эцэг эхчүүд хүүхдээ сургуульд бэлтгэх аргазүй, ур чадвар эзэмшсэн. ....42
Ё. Эцэг эхчүүдийн хандлага маш ихээр өөрчлөгдөж, хүүхдэдээ цаг зарцуулдаг, орчин бэлдэж өгдөг болсон .... 44
Ж. Аав нарын оролцоо эрс дээшилсэн .... 46
З. Багш нарын ур чадвар, сургууль, цэцэрлэгийн залгамж холбоо сайжирсан....47
2.2.2. Хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөрийн үр дүн, биелэлт......47
А. ХБНЦХ-т нийт 6,124 хүүхэд хамрагдаж шууд үр шимийг нь хүртсэн .... 48
Б. ХБЦНХ хэрэгжүүлэх, дотуур байрын Хүүхэд хөгжлийн танхим байгуулснаар хүүхэд сургуульдаа болон дотуур байрандаа дуртай болсон .... 49
В. Хүүхдийн сурлагын ахиц сайжирч, хоцрогдол арилснаар сургуулиас завсардах эрсдэл буурсан.... 50
Г. Дотуур байранд амьдардаг бага ангийн хүүхдийн тоо нэмэгдсэн .... 51
Д. Эцэг эхийн оролцоо, багштай хамтарч ажиллах нь нэмэгдсэн ... 52
Е. Хүүхдийн сэтгэлзүйн таатай байдлын судалгааг авч ашигладаг болсон ....53
Ё. Дотуур байрын үйл ажиллагааг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулсан.... 54
Ж. Заах аргазүйн нэгдлийн багш нарын заах аргазүйг хөгжүүлсэн ....55
2.2.3. Бага боловсрол нөхөн олгох хөтөлбөрийн үр дүн биелэлт ....55
А. ББНОХ-т 206 хүүхэд хамрагдсанаас 62 хүүхэд ЕБС, Дүйцсэн хөтөлбөрт шилжсэн. .... 56
Б. Зорилтот сумдад сургууль завсардалтыг эрс бууруулсан.... 58

В. ББНОХ-өөр хичээллэсэн хүүхэд, эцэг эх, багш нарт гарсан үр дүн ..59
Г. ББНОХ нь хүүхдийн уншиж, бичих чадварыг нэмэгдүүлж, сургуульд дуртай болгосон. ...... 59
Д. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн илрүүлэлт, эцэг эхийн боловсролд хандах хандлага өөрчлөгдсөн ...... 60
Е. Насан туршийн боловсролын танхимыг тохижуулж, багш нарыг чадваржуулсан ...... 61
**2.3. ТӨСЛИЙН НӨӨЦИЙН АШИГЛАЛТ БУЮУ ТӨСВИЙН ҮР ДҮНТЭЙ БАЙДАЛ... 61**
2.3.1. Төслийн төсөв, санхүүжилт, зарцуулалтын үр дүнтэй байдал........ 61
А. ГБОСБХ-ийн төсөв, санхүүжилтийн үр дүнтэй байдал............ 61
Б. Цэцэрлэгийн хүрэлцээ хангалтгүй байгаа одоогийн нөхцөлд ГБОСБХ нь төсөвт хэмнэлттэй хувилбарт сургалтын хэлбэр юм .... 62
В. ХБЦНХ-ийн төсөв санхүүжилтийн үр дүнтэй байдал...............63
Г. ББНОХ-ийн төсвийн үр дүнтэй байдал...... 64
**2.4. ТОГТВОРТОЙ БАЙДАЛ ...... 65**
2.4.1. Зорилт 1-ийн хүрээнд туршсан шинэ санаачилга, сайн туршлагуудын тогтвортой байдал ......65
А. СӨБ-ын хүртээмж хангалтгүй байгаа хөдөөгийн малчдын хүүхдүүдийг сургуульд бэлтгэх хувилбарт сургалтын шинэлэг хэлбэр бий болсон ......65
Б. ГБОСБХ нь эцэг эхчүүдийн оролцоотойгоор хүүхдийг гэр бүлийн орчинд нь хөгжүүлж, цаашдын боловсролд эерэгээр нөлөөлж байна ...... 64
2.4.2.Зорилт 2-ын хүрээнд туршсан шинэ санаачилга, сайн туршлагын тогтвортой байдал ...... 66
А. ХБЦНХ-ийг үндэслэн дотуур байрын үйл ажиллагаа, орчин нөхцөлийг сайжруулсан. ......67
2.4.3. Бага боловсрол нөхөн олгох хөтөлбөрийн тогтвортой байдал ... 68
2.4.4. Төслийг хэрэгжүүлэх явцад олон нийтийн оролцоо, талуудын хамтын ажиллагааг идэвхжүүлсэн...... 69
А. Төслийн үндэсний түвшний оролцогч талуудын үүрэг оролцоо..69
Б. Сумын Олон нийтийн боловсролын зөвлөл нь засаг захиргааны болон боловсролын байгууллагын уялдаа, эцэг эхийн оролцоог хангасан ......70
В. Төслийн Орон Нутгийн Зөвлөл (ТОНЗ) нь аймгийн ЗДТГ, БСУГ-ын хамтын ажиллагаа, оролцоог хангаж өгсөн .............73
2.4.5. Олон нийтийн санаачилгыг дэмжих тэтгэлэгт төсөл ......73

**2.5.ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ, СУРГАМЖ** ........ 78
2.5.1. Ерөнхий үнэлгээ ........ 78
А. ГБОСБХ-ийн ерөнхий үнэлгээ ........ 78
Б. ХБЦНХ-ийн ерөнхий үнэлгээ ........ 80
В. ББНОХ-ийн ерөнхий үнэлгээ ........ 82
Г. Төслийн шалгуур үзүүлэлтийн биелэлт ........ 83
2.5.2. Дүгнэлт ба Сургамж ........ 85
2.5.3. Зөвлөмж ........ 86
Гэр бүлийн орчинд сургуульд бэлтгэх хөтөлбөрийг СӨБ-ын хувилбарт сургалтын шинэ хэлбэр болгон баталгаажуулах ........ 86
Хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөрийг дотуур байрын үйл ажиллагааны хөтөлбөр болгон түгээн дэлгэрүүлэх ........ 86
Бага боловсрол нөхөн олгох хөтөлбөрийг бичиг үсгийн боловсролыг нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан сургахад ашиглах ........ 87
Боловсролын салбарт эцэг эх, олон нийтийн оролцоог хангахад ОНБЗ-ийн туршлагыг ашиглах ........ 87
**Хавсралт 1.** Сумдын үнэлгээний нэгтгэл. Зорилт тус бүрээр ........ 89
**Хавсралт 2.** Аймгийн ТОНЗ-ийн үнэлгээний нэгтгэл ........ 97

## ХҮСНЭГТҮҮДИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Үнэлгээний хэлэлцүүлэг тус бүрт оролцогчдын тоо, ХИС ........ 16
Хүснэгт 2. Цэцэрлэгийн насны хүүхдийн тоо, ҮСГ ........ 19
Хүснэгт 3. Хувилбарт сургалтын стандарт цаг, хэлбэр ........ 20
Хүснэгт 4. Дотуур байрын хүчин чадал ба хүүхдийн мэдээлэл, 2016-2017, БСШУСЯ ........ 24
Хүснэгт 5. ГБОСБХ-ийн өмнө ба дараах өөрчлөлт ........ 27
Хүснэгт 6. Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн хөтөлбөрөөр суралцагчид, насны бүлгээр, 2016-2017, БСШУСЯ ........ 29
Хүснэгт 7. ЕБС-д суралцдаггүй 6-14 насны хүүхдүүд, шалтгаанаар, 2012-2013 ба 2016-2017, БСШУСЯ ........ 29
Хүснэгт 8. Хүүхэд ба эцэг эхчүүд - ББНОХ-ийн өмнө ба дараа ........ 32
Хүснэгт 9. Төслийн үр дүнгийн хүрээний ГБОСБХ-тэй холбоотой шалгуур үзүүлэлтүүдийн биелэлт ........ 35
Хүснэгт 10. Сургуульд бэлтгэх хөтөлбөрийн үр шим хүртэгч хүүхдүүд, ХИС ........ 36
Хүснэгт 11. СӨБ-ын хамрагдалтын хувь зорилтот 30 суманд, 2012-2013 (Суурь судалгааны тайлан) ........ 38

Хүснэгт 12. Хүүхэд – ГБОСБХ-ийн өмнө ба дараа, 30 сумын хэлэлцүүлгээр хамгийн олон давтагдсан үр дүн ....................40
Хүснэгт 13. Эцэг эхчүүд- ГБОСБХ-ийн өмнө ба дараа, хэлэлцүүлгийн нэгтгэл ...45
Хүснэгт 14. ХБЦНХ-ийн чиглэлээр гарах үр дүнгийн үзүүлэлтүүд ................48
Хүснэгт 15. ХБЦНХ-т хамрагдсан хүүхдийн тоо, ХИС ....................48
Хүснэгт 16. 2012/2013 ба 2016/2017 оны шалгалтын дүнгийн өсөлтийн хувь ....50
Хүснэгт 17. Хүүхдийн нийгэм сэтгэлзүйн байдлын судалгааны үр дүнгээс, 2015-2016, ХИС ....................53
Хүснэгт 18. Хүүхдийн нийгэм сэтгэлзүйн байдлын судалгааны үр дүнгээс, 2015-2016, ХИС ....................54
Хүснэгт 19. ББНОХ-ийн шалгуур үзүүлэлтүүдийн өөрчлөлт ба биелэлт .......55
Хүснэгт 20. ББНОХ-оос ЕБС ба Дүйцсэн хөтөлбөрт шилжсэн хүүхдүүдийн мэдээлэл, 2014-2017, ХИС ....................56
Хүснэгт 21. ЕБС-д суралцдаггүй 6-14 насны хүүхдүүд, шалтгаанаар, 2012-2013 ба 2016-2017, БСШУСЯ ....................58
Хүснэгт 22. Боловсролын болон СӨБ-ын төсөв (2012-2016 он, сая төгрөгөөр) ....62
Хүснэгт 23. Цэцэрлэгийн бүлгийн тоо ба хамрагдаж буй хүүхдийн тоо, 2016-2017 ....................63
Хүснэгт 24. Олон нийтийн санаачилгыг дэмжих тэтгэлэгт хөтөлбөрийн жагсаалт, ХИС ....................75
Хүснэгт 25. Зорилт 1-ГБОСБХ-ийн 4 аймгийн үнэлгээний нэгдсэн дүн .........80
Хүснэгт 26. Зорилт 2-ХБЦНХ-ийн 4 аймгийн үнэлгээний нэгдсэн дүн .........80
Хүснэгт 27. Зорилт 3-ББНОХ-ийн 4 аймгийн үнэлгээний нэгдсэн дүн ..........82
Хүснэгт 28. Төслийн шалгуур үзүүлэлтийн биелэлт ....................84

## ГРАФИК

График 1. СӨБ-ын хамрагдалт 2009-2015 ....................20
График 2. СӨБ-ын хүүхдүүдэд малчдын хүүхдийн эзлэх хувь, насаар, БСШУСЯ ....................21
График 3. ГБОСБХ-ийн малчин өрхийн онцлогт нийцтэй байдал, 30 сумын үнэлгээний нэгтгэл ....................22
График 4. ХБЦНХ-ийн нийцтэй байдал, 30 сумын үнэлгээний нэгтгэл ......26
График 5. ББНОХ-ийн нийцтэй байдал, 30 сумын үнэлгээний нэгтгэл ......32
График 6. ГБОСБХ-ийн үр өгөөжтэй байдал, 30 сумын оролцооны үнэлгээний нэгтгэл ....................39

График 7. ХБЦНХ-ийн үр өгөөжтэй байдлын 30 сумын үнэлгээний нэгтгэл..52
График 8. ББНОХ-ийн үр дүнгийн үнэлгээ, 30 сумын үнэлгээний нэгтгэл...59
График 9. ГБОСБХ-ийн төсвийн үр дүнтэй байдал, 30 сумын үнэлгээний нэгтгэл ....61
График 10. ХБЦНХ-ийн төсвийн үр дүнтэй байдал, 30 сумын үнэлгээний нэгтгэл ....64
График 11. ББНОХ-ийн төсвийн үр дүнтэй байдал, 30 сумын үнэлгээний нэгтгэл ....64
График 12. ГБОСБХ-ийн 1. Тогтвортой чадавх бий болгосон, 2. Нутагшуулах боломж, 30 сумын үнэлгээний нэгтгэл ....65
График 13. ХБЦНХ-ийн 1. Тогтвортой чадавх бий болгосон, 2. Нутагшуулах боломж, 30 сумын үнэлгээний нэгтгэл .... 67
График 14. ББНОХ-ийн 1. Тогтвортой чадавх бий болгосон, 2. Нутагшуулах боломж, 30 сумын үнэлгээний нэгтгэл ....68
График 15. Олон нийтийн Боловсролын Зөвлөл (ОБНЗ)-ийн талаар ойлголт ...71
График 16. Зорилт 1-ГБОСБХ-ийн 30 сумын үнэлгээний нэгдсэн дүн ....78
График 17. Зорилт 2-ХБЦНХ-ийн 30 сумын үнэлгээний нэгдсэн дүн .... 81
График 18. Зорилт 3-ББНОХ-ийн 30 сумын үнэлгээний нэгдсэн дүн ....83

## ЗУРАГ

Зураг 1. ХБЦНХ-ийн өмнөх (дээд талын зураг) ба дараах (доод талын зураг) нөхцөлийг харьцуулсан зураг, Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын хэлэлцүүлэг ....28
Зураг 2. Хүүхдийн гарын дүйг бүтээлээр нь харьцуулсан харьцуулалт, өмнө ба дараа ....41
Зураг 3. Дорнод аймгийн Сэргэлэн сумын Хэлэлцүүлэг 1 ....42
Зураг 4. Хүүхдийн бүтээлийн булан (Архангай аймгийн Хотонт сум)......46
Зураг 5. Хэлэлцүүлгийн оролцогчид аав нарын оролцоог илэрхийлсэн байдал, Архангай аймгийн Өлзийт, Хашаат сум .... 47
Зураг 6. Сухбаатар аймгийн Мөнххаан сумын Хэлэлцүүлэг 2-ын Зураг: Хүүхэд төслийн дараа ....52
Зураг 7. ОНБЗ-ийн үйл ажиллагааны хүрээ, Архангай аймгийн Өлзийт сум ....52

# 1 УДИРТГАЛ

## 1.1 ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Японы Хүүхдийг Ивээх Сан (ХИС)-гийн Монгол дахь Хөтөлбөр нь Дэлхийн Банкны итгэлцлийн сан болох Японы Нийгмийн Хөгжлийн Сангийн нийт 2,5 сая ам.долларын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр “Алслагдсан хөдөөгийн малчдын хүүхдүүдийн бага боловсролын үр дүнг сайжруулах нь” төслийг Архангай, Өвөрхангай, Дорнод болон Сүхбаатар аймгийн алслагдсан 30[1] суманд 2012 оны 6-р сараас эхлэн 2017 оны 6-р сарын 21-ний өдрийг хүртэл 5[2] жилийн хугацаатай хэрэгжүүллээ.

**Төслийн хөгжлийн зорилго** нь зорилтот дөрвөн аймгийн 5-10 насны, малчин өрхийн 7,500 орчим хүүхдүүдийн боловсролын хүртээмж, чанар, үр ашгийг нэмэгдүүлнэ.

**Төслийн зорилтууд:**

1) “Гэр бүлийн орчинд хүүхдийг сургуульд бэлтгэх хөтөлбөр”-ийг туршин сургуулийн өмнөх боловсролын хүртээмж хангалтгүй байгаа алслагдсан орон нутгийн малчин өрхийн хүүхдийг сургуульд амжилттай бэлтгэн, эцэг эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ.
2) “Хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөр”-өөр дамжуулан эцэг эх, гэр бүлээсээ тусдаа айлд болон сургуулийн дотуур байранд амьдарч буй бага ангийн хүүхдүүдийн сургууль болон дотуур байрын амьдралд дасан зохицох, сурах, хөгжих үйл явцыг дэмжинэ.
3) Сургуульд сурч байгаагүй болон бага ангиас сургууль завсардсан хөдөөгийн хүүхдүүдэд зориулсан “Бага боловсрол нөхөн олгох сургалтын хөтөлбөр”-ийг боловсруулан туршин хэрэгжүүлэх замаар тэдний сургуульдаа эргэн суралцах үйл явцыг дэмжинэ.

2016 оны 12 сарын 31-ний байдлаар төсөл хэрэгжсэн орон нутгийн малчдын хүүхдийн бага боловсролын хүртээмж, чанар, үр ашиг дээшилж, малчин өрхийн нийт 8,033 хүүхэд төслөөс үр шим хүртээд байна.

Мөн 16,066 эцэг эх, 1,954 захирал, бага ангийн болон дотуур байрын багш, номын санч, нийгмийн ажилтан зэрэг сургуулийн ажилтнууд, 143 насан туршийн боловсролын багш, 692 орон нутгийн удирдлага болон холбогдох мэргэжилтнүүд төслийн хүрээнд шууд үр шим хүртжээ.

1. Архангай аймаг (Жаргалант, Өлзийт, Өндөр-Улаан, Тариат, Хайрхан, Хангай, Хашаат, Хотонт, Цэцэрлэг, Эрдэнэмандал сумд), Өвөрхангай аймаг (Баянгол, Баян-Өндөр, Богд, Бүрд, Есөнзүйл, Зүүнбаян-Улаан, Сант, Тарагт, Уянга, Хайрхандулаан сумд) Дорнод аймаг (Матад, Сэргэлэн, Халхгол, Цагаан-Овоо, Чойбалсан сумд) болон Сүхбаатар аймаг (Баяндэлгэр, Мөнххаан, Онгон, Уулбаян болон Эрдэнэцагаан сумд)
2. 2016 оны 1 дүгээр сард Дэлхийн Банк төслийн хэрэгжих хугацааг 2016 оны 6 дугаар сарын 21-нээс 2017 оны 6 дугаар сарын 21 хүртэл нэг жилээр сунгаснаар төсөл 5 жил хэрэгжихээр болсон.

## 1.2 ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ

### 1.2.1. Зорилт 1: Гэр бүлийн орчинд хүүхдийг сургуульд бэлтгэх хөтөлбөр (ГБОСБХ)–ийн хэрэгжилт

***Зорилт 1.*** *Гэр бүлийн орчинд хүүхдийг сургуульд бэлтгэх хөтөлбөрийг туршин сургуулийн өмнөх боловсролын хүртээмж хангалтгүй байгаа алслагдсан орон нутгийн малчин өрхийн хүүхдийг сургуульд амжилттай бэлтгэн, эцэг эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ.*

Энэхүү зорилтын хүрээнд Гэр бүлийн орчинд хүүхдийг сургуульд бэлтгэх (ГБОХСБ) 96 өдрийн хөтөлбөр боловсруулан туршиж, хүүхдэд зориулсан **"Би Чадна"** гарын авлага, эцэг эхчүүдэд зориулсан **"Та өөрөө багш"** гарын авлагыг, **сонсдог номын** хамт нэвтрүүлснээр малчин эцэг эх 5 настай хүүхдээ гэрийн нөхцөлд сургуульд бэлтгэх боломж бүрдсэн. Сургуулийн өмнөх боловсролд (СӨБ) хамрагдах боломжгүй байсан алслагдсан хөдөөгийн малчин өрхийн 3,763 хүүхэд гэр бүлийнхээ орчинд сургуульд амжилттай бэлтгэгдэж, сургуульд элсэн орсон байна. Хөтөлбөрийн хүрээнд 7,500 гаруй эцэг эх шууд үр шим хүртжээ.





Түүнчлэн дээрх хөтөлбөртэй хамт хүүхдийн сонирхлыг татахуйц сэтгэхүй хөгжүүлэх **тоглоом, номын багцыг** бэлтгэж, зорилтот 30 сум, 4 баг, аймгийн төвийн номын сан, МУБИС-ийн Сургуулийн өмнөх боловсролын сургууль, Архангай аймгийн Багшийн коллежид байгуулсан нийт 45 **"Миний номын өргөө"**-гөөр дамжуулан малчин эцэг эх, хүүхдүүдэд тогтмол түгээж ашиглуулж байна. Багц бүрт 3 тоглоом, 10 үлгэрийн ном байдаг. Нийт 10 өөр багц байх ба тэдгээрийг бүгдийг судалж дууссанаар хүүхэд 30 тоглоом, 100 номтой танилцдаг.

Гарын авлага, ном, тоглоом зэрэг материалуудыг ашиглан өдөрт 20-30 минут, долоо хоногт 3-4 цаг гэртээ хүүхэдтэйгээ үр бүтээлтэй ажиллахыг эцэг эхчүүдэд зөвлөдөг. Эцэг эх гэр бүлийн орчинд хүүхдийнхээ 6 үндсэн чадварыг хөгжүүлэх боломжтойгоор хөтөлбөрийг боловсруулсан.

**Хэл яриа**
31 дасгал

**Байгаль нийгмийн орчин**
27 дасгал

**Дуу хөгжим, дүрслэх урлаг**
52 дасгал

**Зан чанар, харилцаа**
20 дасгал

**Хөдөлгөөн, эрүүл мэнд**
30 дасгал

**Математик**
33 дасгал

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн онцлог хэрэгцээнд зориулсан ном, тоглоомын багцыг 2014 оноос эхлэн нэвтрүүлжээ. Төслийн сүүлийн жил буюу 2016-2017 оны хичээлийн жилд хөгжлийн бэрхшээлтэй 76 хүүхэд эдгээр ном, тоглоомын багцыг ашиглаж байна.

Мөн эцэг эхэд зөвлөн туслах үүрэг бүхий **5 чиглүүлэгч багш нарыг** сум бүрт бэлтгэсэн.

### 1.2.2. Зорилт 2: Хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөр (ХБЦНХ)-ийн хэрэгжилт

***Зорилт 2:*** *"Хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөр"-өөр дамжуулан эцэг эх, гэр бүлээсээ тусдаа айлд болон сургуулийн дотуур байранд амьдарч буй бага ангийн хүүхдүүдийн сургууль болон дотуур байрын амьдралд дасан зохицох, сурах, хөгжих үйл явцыг дэмжинэ.*



ХБЦНХ нь хүүхдийн хөгжлийг бүхий л талаар дэмжиж, бүтээлчээр унших, бичих, ярих, сонсох, сэтгэн бодох чадварыг нэгдмэл байдлаар хөгжүүлэх, хичээлийн хоцрогдлыг багасгах, сурах сонирхлыг өдөөх, өөрийгөө нээн, шинэ орчинд дасан зохицож, бие даан сурч амьдрах чадвартай болгох зорилготой 105 аргазүй бүхий 2 модулиас бүрдэнэ.

Сум бүрийн сургуулийн дотуур байранд "Хүүхэд хөгжлийн танхим" байгуулан, иж бүрэн тохижуулж, бага (1-5 дугаар) ангийн хүүхдүүд чөлөөт цагаа үр бүтээлтэй өнгөрүүлэх, сурах, хөгжих таатай орчин бий болгосны үр дүнд нийт 4,196 хүүхдийн хөгжилд тодорхой ахиц өөрчлөлт гарснаас, нийт 2,854 хүүхэд Монгол хэл, Математикийн хичээлдээ сурлагын амжилт гаргасан байна. Хүүхэд хөгжлийн танхимд 6-10 насны хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон оюун ухаан хөгжүүлэх тоглоомууд болон танин мэдэхүйн номуудыг байрлуулсан.

### 1.2.3. Зорилт 3: Бага боловсрол нөхөн олгох хөтөлбөр (ББНОХ)–ийн хэрэгжилт

***Зорилт 3:*** *Сургуульд сурч байгаагүй болон бага ангиас сургууль завсардсан хөдөөгийн хүүхдүүдэд зориулсан "Бага боловсрол нөхөн олгох сургалтын хөтөлбөр"-ийг боловсруулан туршин хэрэгжүүлэх замаар тэдний сургуульдаа эргэн суралцах үйл явцыг дэмжинэ.*



Сургуульд огт сураагүй эсвэл бага ангиас сургууль завсардсан 8-аас дээш насны хүүхдүүдэд зориулсан 1-3 дугаар ангийн Монгол хэл, Математикийн бага боловсрол нөхөн олгох 18 модуль бүхий хөтөлбөр боловсруулж нэвтрүүлсэн. Хөтөлбөрийг нэвтрүүлснээс хойш төслийн 4 дэх жилийн байдлаар 119 хүүхэд уг хөтөлбөрт хамрагдаж, үүнээс 74 хүүхдийн суралцах чадвар нэмэгдсэнээс 59 хүүхэд нь сургуульд болон дүйцсэн хөтөлбөрт эргэн оржээ. Бага боловсрол нөхөн олгох сургалтын 30 танхимыг зорилтот сумдын ерөнхий боловсролын сургууль болон **Насан туршийн боловсролын төвд** түшиглэн байгуулж, шаардлагатай тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангасан.

### 1.2.4. Зорилт 4: Эцэг эх, олон нийтийн оролцоог хангах

***Зорилт 4.*** *Төслийн хүрээнд боловсролын байгууллагуудын болон салбар хоорондын хамтын ажиллагааг хангах, тэдгээрийн бодлого, үйл ажиллагаатай уялдуулан зохицуулах, эцэг эх, орон нутгийн иргэд, удирдлагууд болон холбогдох боловсролын байгууллагуудын идэвхтэй оролцоог хангана.*

Төслийн хүрээнд Төслийн удирдах зөвлөл (ТУЗ), Техникийн зөвлөх баг (ТЗБ), зорилтот 4 аймагт Төслийн орон нутгийн зөвлөл (ТОНЗ), зорилтот 30 суманд Олон нийтийн боловсролын зөвлөл (ОНБЗ)-үүд тус тус байгуулагдаж,

төслийн хэрэгжилтэд өөр өөрийн үүрэгтэйгээр оролцлоо. Тодруулбал, ТУЗ нь төслийн хэрэгжилтийг стратеги удирдлагаар хангах, салбарын болон салбар хоорондын, бусад хандивлагч байгууллагуудын уялдааг хангах, төсөлд оролцогчдын хариуцлагатай байдлыг сайжруулах, төслийн хэрэгжилтэд хяналт тавих; ТЗБ нь төслийн үйл ажиллагааг төрөөс баримталж буй боловсролын бодлого, үйл ажиллагаатай уялдуулан зохицуулах, мэргэжлийн удирдлага, дэмжлэгээр хангах, төслийн хүрээнд боловсруулан гаргах аливаа бүтээгдэхүүнд техникийн үнэлэлт, дүгнэлт өгөх, төслийн багт техникийн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх; ТОНЗ нь тухайн орон нутаг дахь төслийн үйл ажиллагааны хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, салбарын болон орон нутгийн бодлого, бусад хандивлагч байгууллагын үйл ажиллагаатай уялдуулах, төслийн хэрэгжилтийн явцад төсөл хэрэгжүүлэгч болон түншлэгч байгууллагаас дэвшүүлэн тавьсан асуудлыг шийдвэрлэх, төслийн шинэ санаачилга, тэргүүн туршлага, оновчтой санааг түгээн дэлгэрүүлэн цаашид тогтвортой байдлыг хангах, төслийн хэрэгжилтэд хяналт тавих, зөвлөн туслах; ОНБЗ нь өөр өөрийн сум, багт байгаа төслийн зорилтот хүүхдүүдийг тодорхойлох, тэдний болон эцэг эхийн нөхцөл байдал, хэрэгцээг тодорхойлох, тэдэнд чиглэсэн үйл ажиллагааг өөрсдийн нөөц боломжийг ашиглан сумын хэмжээнд санаачлан хэрэгжүүлэхэд эцэг эх, орон нутгийн иргэд, удирдлагууд болон холбогдох боловсролын байгууллагуудын идэвхтэй оролцоог хангах замаар тэдний санал санаачилгыг дэмжин идэвхжүүлэх, төслийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, үр дүнтэй, тогтвортой хамтын ажиллагааг бий болгох үүрэгтэй оролцсон байна.

## 1.3. ТӨСЛИЙН ЭЦСИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, АРГАЧЛАЛ

### 1.3.1 Төслийн эцсийн үнэлгээний зорилго

Төслийн зорилго, зорилтын биелэлт, үр дүн, зорилтот бүлэгт үзүүлсэн үр нөлөө, тогтвортой байдал, хөрөнгө нөөцийн ашиглалт, иргэд олон нийт болон төсөл хэрэгжүүлэгч байгууллага, **оролцогч талуудын идэвх, оролцоо, чадавхид шууд болон шууд бусаар** үзүүлсэн үр нөлөөг үнэлэх явдал юм. Үнэлгээнд дараах асуудлуудыг тухайлан авч үзсэн. Үүнд:

1. **Төслийн төлөвлөлт, дизайн**
    - Төслийн баримт бичиг төсөл хэрэгжсэн хугацаан дахь хөгжлийн бодлогууд, боловсролын салбарын бодлого, төслийн зорилгын хүрээнд хамаарах хэрэгцээнд нийцсэн байдал, оруулсан хувь нэмэр
2. **Төслийн зорилго, зорилгын биелэлт, үр дүн**
    - Төслийн зорилго, зорилтын биелэлт, ерөнхий үр дүнг үнэлэх,
    - Төслийн бүрэлдэхүүн тус бүрээр төлөвлөсөн болон хүрсэн үр дүнг харьцуулан үнэлэх,

- Төсөл хэрэгжсэнээр зорилтот хүүхдүүд, тэдний эцэг эх, оролцогч бусад талуудад гарсан өөрчлөлтийг төсөл хэрэгжихээс өмнөх (суурь судалгааны тайланд үндэслэн) болон хэрэгжсэний дараах нөхцөл байдлыг харьцуулах замаар үнэлэх,

**3. Төслийн нөөцийн ашиглалт буюу төсвийн үр дүнтэй байдал**

- Төслийн төсөв, санхүүжилтийн хуваарилалт, зарцуулалтын үр дүнтэй байдал, сайн туршлага болон авсан сургамж,
- Гол оролцогч талууд болох БСШУСЯ, хэрэгжүүлэгч байгууллага ХИС-гийн Монгол дахь хөтөлбөр, төслийн зөвлөхүүд, ТУЗ, ТЗБ-ийн оролцоо, үйл ажиллагааг үнэлэх,

**4. Тогтвортой байдал**

- Төслийн хүрээнд туршсан шинэ санаачилга, бий болсон сайн туршлагууд, төсөл дууссаны дараа тогтвортой үргэлжлэх боломжийг үнэлэх, тухайлбал:
    - Сумын түвшинд олон нийтийн боловсролын зөвлөл;
    - Олон нийтийн санаачилгыг дэмжих тэтгэлэгт төсөл;
    - Орон нутаг дахь эцэг эх, иргэдийн оролцоо;
    - Гэр бүлийн орчинд сургуульд бэлтгэх хөтөлбөр, Миний номын өргөө, ном, тоглоомын багц, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан ном, тоглоомын багц ашиглах үйл ажиллагаа;
    - Хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөр, Хүүхэд хөгжлийн танхим;
    - Бага боловсрол нөхөн олгох хөтөлбөр, үйл ажиллагаа.

**5. Ерөнхий үнэлгээ, дүнэлт, сургамж**

- Төсөл үр дүнтэй хэрэгжихэд нөлөөлсөн хүчин зүйлүүд, төслийг хэрэгжүүлэхэд үндэсний болон орон нутгийн түвшинд тулгарч байсан хүндрэл, бэрхшээл, тэдгээрийг даван туулж байсан арга замыг тодорхойлж, дүгнэх,
- Төслийн хэрэгжилтийн явцад хуримтлуулсан туршлага, авсан сургамжуудыг тодорхойлох, тэдгээрт тулгуурлан санхүүжүүлэгч болон хэрэгжүүлэгч байгууллагууд болох Дэлхийн Банк, ХИС-гийн Монгол дахь хөтөлбөр, Засгийн газрын байгууллагуудад өгөх санал зөвлөмж боловсруулах

### 1.3.2. Төслийн эцсийн үнэлгээний хамрах хүрээ, аргачлал

Төслийн эцсийн үнэлгээг төсөл хэрэгжсэн 4 аймаг, 30 суманд оролцогч талуудын **оролцоонд тулгуурласан** Үнэлгээний хэлэлцүүлэг хийх замаар хийж гүйцэтгэсэн. Үнэлгээний зөвлөх нь Сумын ОНБЗ-ийн бэлтгэл ажлын удирдамж, ОНБЗ-өөс гурван зорилт тус бүрээр зохион байгуулах үнэлгээний хэлэлцүүлгийн аргачлал, удирдамжийг боловсруулж, 4 аймгийн

5 суманд туршсан (Сумын бэлтгэл ажлын болон зорилтот хэлэлцүүлгүүдийн удирдамжуудыг Удирдамж 1-4-өөс харна уу). Мөн аймгийн түвшинд зохион байгуулах үнэлгээний хэлэлцүүлэг хийх удирдамжийг боловсруулсан (Аймгийн түвшний хэлэлцүүлгийн удирдамж №5-г харна уу).

Сумын түвшинд сумын ОНБЗ-ийн гишүүд хамтран төслийн үр шимийг хүртсэн хүүхдүүдийн эцэг эх, чиглүүлэгч багш нарыг оролцуулсан дараах гурван тусдаа хэлэлцүүлгийг Үнэлгээний зөвлөхийн боловсруулсан удирдамжийн дагуу зохион байгуулсан. Үүнд:

а. Зорилт 1- Гэр бүлийн орчинд сургуульд бэлтгэх хөтөлбөрийн шууд үр шимийг хүртсэн хүүхдүүдийн эцэг эх, багш нарын хэлэлцүүлэг (4 цаг)

б. Зорилт 2-Хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөрийн шууд үр шимийг хүртсэн хүүхдүүдийн эцэг эх, асран хамгаалагчид ба дотуур байрны багш нарын хэлэлцүүлэг (4 цаг)

в. Зорилт 3-Бага боловсрол нөхөн олгох хөтөлбөрийн шууд үр шимийг хүртсэн хүүхдүүдийн эцэг эхчүүд болон төслийн үр шимийг шууд бусаар хүртсэн багш нар болон бусад оролцогч талуудын нэгдсэн хэлэлцүүлэг (4 цаг)

Хэлэлцүүлэг тус бүрийг зохион байгуулахад ОНБЗ-ийн гишүүд болон төслийн хүрээнд бэлтгэгдсэн чиглүүлэгч багш нараас бүрдсэн дөрвөн гишүүн илтгэгч, чиглүүлэгч, тэмдэглэл хөтлөгч, баримтжуулагч гэсэн тусгайлсан үүрэгтэй оролцсон ба нийт 30 сумын хэлэлцүүлгийг зохион байгуулахад нийт 360 Зөвлөлийн гишүүд болон чиглүүлэгч багш нар хамтран оролцсон.

Сумын түвшний хэлэлцүүлэг тус бүрт оролцогчдыг сонгохдоо 2016-2017 онд төслийн үр шимийг хүртэж буй хүүхдийн тоог харгалзан дараах байдлаар доод ба дээд хязгаарыг тогтоосон. Сумдын үнэлгээний хэлэлцүүлэгт оролцогчдын тоо зарим тохиолдолд дээд хязгаараас илүү олон байсан.

**Хүснэгт 1. Үнэлгээний хэлэлцүүлэг тус бүрт оролцогчдын тоо, ХИС**

| | **Зорилт 1. Хэлэлцүүлэг 1** | | **Зорилт 2. Хэлэлцүүлэг 2** | | | **Шууд бус** |
|---|---|---|---|---|---|---|
| **Аймаг сумд** | Гэрээр СӨБ-д хамрагдаж буй хүүхдүүд | Хэлэлцүүлэг 1-т Оролцогчдын тоо | Дотуур байрны хүүхдийн тоо | Айлд амьдардаг хүүхдийн тоо | Хэлэлцүүлэг 2. Оролцогчдын тоо | Хэлэлцүүлэг 3. Шууд бус үр шимийг хүртэгчид ба оролцогч талууд |
| АРХАНГАЙ | | | | | | |
| Жаргалант | 41 | 16-20 | 14 | 204 | 20-25 | 20-25 |
| Өлзийт | 27 | 16-20 | 34 | 98 | 20-25 | 20-25 |
| Өндөр-Улаан | 30 | 16-20 | 21 | 148 | 20-25 | 20-25 |
| Тариат | 24 | 16-20 | 14 | 100 | 20-25 | 20-25 |
| Хайрхан | 28 | 16-20 | 21 | 110 | 20-25 | 20-25 |
| Хангай | 30 | 16-20 | 29 | 89 | 20-25 | 20-25 |
| Хашаат | 31 | 16-20 | 77 | 180 | 20-25 | 20-25 |
| Хотонт | 35 | 16-20 | 81 | 114 | 20-25 | 20-25 |
| Цэцэрлэг | 30 | 16-20 | 56 | 131 | 20-25 | 20-25 |
| Эрдэнэмандал | 22 | 16-20 | 58 | 215 | 20-25 | 20-25 |
| Нийт | 298 | 160-200 | 405 | 1389 | 200-250 | 200-250 |
| ӨВӨРХАНГАЙ | | | | | | |
| Аймгийн төв номын сан | 24 | 16-20 | | | | |
| Баянгол | 44 | 16-20 | 18 | 64 | 20-25 | 20-25 |
| Баян-Өндөр | 27 | 16-20 | 95 | 81 | 20-25 | 20-25 |
| Богд | 65 | 16-20 | 35 | 111 | 20-25 | 20-25 |
| Бүрд | 25 | 16-20 | 21 | 73 | 20-25 | 20-25 |
| Есөнзүйл | 28 | 16-20 | 25 | 76 | 20-25 | 20-25 |
| Зүүнбаян-Улаан | 10 | 16-20 | 38 | 43 | 20-25 | 20-25 |
| Сант | 23 | 16-20 | 47 | 89 | 20-25 | 20-25 |
| Тарагт | 25 | 16-20 хамтдаа | 11 | 32 | 20-25 хамтдаа | 20-25 хамтдаа |
| Туяа баг | 6 | | 41 | | | |
| Уянга | 160 | 20-25 | 69 | 196 | 20-25 | 20-25 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Хайрхандулаан | 41 | 16-20 | 19 | 60 | 20-25 | 20-25 |
| Нийт | 478 | 180-225 | 419 | 825 | 200-250 | 200-250 |
| **ДОРНОД** | | | | | | |
| Аймгийн төв номын сан | 19 | 10-15 хамтдаа | | | | |
| Хан-Уул цогцолбор сургууль | 16 | | | | | |
| Матад | 15 | 10-15 | 19 | 25 | 16-20 | 20-25 |
| Сэргэлэн | 16 | 10-15 | 28 | 10 | 16-20 | 20-25 |
| Халхгол | 22 | 10-15 хамтдаа | 18 | 23 | 16-20 хамтдаа | 20-25 хамтдаа |
| Ялалт баг | 9 | | 13 | 6 | | |
| Цагаан-Овоо | 15 | 10-15 | 32 | 23 | 16-20 | 20-25 |
| Чойбалсан | 12 | 10-15 | 6 | 60 | 16-20 | 20-25 |
| Нийт | 124 | 60-90 | 116 | 147 | 80-120 | 100-125 |
| **СҮХБААТАР** | | | | | | |
| Баяндэлгэр | 24 | 10-15 | 23 | 68 | 20-25 | 20-25 |
| Мөнххаан | 15 | 10-15 | 27 | 81 | 20-25 | 20-25 |
| Онгон | 20 | 10-15 | 7 | 78 | 20-25 | 20-25 |
| Уулбаян | 17 | 10-15 | 7 | 46 | 20-25 | 20-25 |
| Эрдэнэцагаан | 26 | 10-15 | 33 | 153 | 20-25 | 20-25 |
| Нийт | 102 | 50-75 | 97 | 426 | 100-125 | 200-250 |
| Бүгд | 1007 | 590 | | 3824 | 745 | 875 |

Дээрх хэлэлцүүлгүүдэд Зорилт 1-ийн үр шимийг шууд хүртсэн нийт 590 эцэг эх, багш; Зорилт 2-ын үр шимийг шууд хүртсэн 745 эцэг эх, багш; төслийн үр шимийг шууд бусаар хүртсэн цэцэрлэгийн болон сургуулийн багш нар, багийн засаг дарга болон бусад оролцогч талууд болон Зорилт 3-ын үр шимийг шууд хүртсэн хүүхдийн эцэг эхийн төлөөлөл 875 гаруй хүн оролцсон.

Аймгийн түвшинд ТОНЗ-ийн гишүүд, Аймгийн Боловсрол, Соёл, Урлагийн Газар (БСУГ), СӨБ ба Бага боловсролын төлөөлөл болон аймгийн түвшний бусад оролцогч талуудын үнэлгээний хэлэлцүүлгийг зохион байгуулахад аймаг тус бүрт 15-20 хүн оролцсон.

# 2 ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

## 2.1. ТӨСЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ДИЗАЙН

### 2.1.1. Боловсролын салбарын бодлоготой нийцсэн байдал, оруулсан хувь нэмэр

Монгол улс 2008-2009 оны хичээлийн жилээс эхлэн Ерөнхий боловсролын 12 жилийн тогтолцоонд шилжсэнтэй холбоотойгоор цэцэрлэгийн насыг 2-5 нас болгосон. Мөн сургуульд элсэн орох насыг өмнө нь 8 байсныг 6 нас болгосон.

Энэхүү өөрчлөлтийн улмаас Монгол улсын хүн амын 30%-ийг эзэлдэг хөдөөгийн малчин өрхүүд шинэ хүндрэл бэрхшээлтэй тулгарсан. Хөдөөгийн сумын сургуулийн дэргэдэх дотуур байранд суулгах нь нүүдэлчин малчин өрх хүүхдээ сургуульд хамруулах цорын ганц арга зам байсаар ирсэн. Төслийн суурь судалгаагаар хүүхдээ сургуульд сургахын тулд хэдэн зуун малчин өрхүүд дараах хүндрэлтэй тулгардаг гэжээ. Үүнд:

- 6 настай хүүхдээ сургуулийн дотуур байранд суулгаж, жилд 9 сарын турш хүүхдээсээ тусдаа байх
- Аав нь малаа маллаж үлдээд, ээж нь сумын төвд хүүхэдтэйгээ хамт байрлаж, хүүхдээ сургуульд явуулах
- Хүүхдээ сумын төвд байдаг хамаатныхаа айлд байлгаж сургуульд явуулах
- Хүүхдээ 7-8 нас хүртэл нь сургуульд явуулахгүй байх

Ийм бага насны хүүхэд гэр бүлээсээ 9 сарын турш хол байх нь тэдний сэтгэл санаанд сөргөөр нөлөөлдөг. Үүн дээр эдгээр хүүхдүүдийн ихэнх нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдалгүйгээр сургуульд шууд ордог нь тэдэнд суралцахад нь бэрхшээл учруулж, сурлагаар хоцрогдоход хүргэдэг. Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамны (БСШУСЯ) мэдээгээр 2011 онд сургуулийн өмнөх насны хүүхдүүдийн 38% нь сургуульд бэлтгэгдэлгүйгээр сургуульд ордог байсан. Эдгээр хүүхдүүдийн ихэнх нь хөдөө орон нутагт байсан. Түүнчлэн 6-14 насны сургууль завсардсан хүүхдүүдийн 80,5% нь хөдөө орон нутагт байсан ба сургууль завсардалт, улиран сурах явдал нь бага ангийн сурагчдын дунд хамгийн өндөр байсан байна.

Түүнчлэн албан бус сургалтын хөтөлбөр нь 9-49 насны иргэдийг хамардгаас гадна бага ангиасаа завсардсан хүүхдүүд боловсролд нөхөн хамрагдах боломжгүй байсан.

"Алслагдсан хөдөөгийн малчдын хүүхдүүдийн бага боловсролын үр дүнг сайжруулах нь" төсөл нь сургуульдаа болон сумын төвд дасан зохицохын тулд

өөрийн гэсэн онцлог асуудлуудтай тулгардаг, үүнээсээ болж тэдний цаашдын хөгжилд хүндрэл тулгардаг байсан алслагдсан хөдөөгийн, нүүдэлчин малчдын 5-10 насны хүүхдүүдийн боловсролд тусгайлан чиглэсэн юм. Тус төсөл нь өөрийн тавьсан зорилго болох алслагдсан хөдөөгийн малчдын хүүхдүүдэд чанартай бага боловсрол эзэмших боломжийг нь нэмэгдүүлэх зорилгоо бүрэн биелүүлсэн.

### A. Сургуулийн өмнөх боловсролын эцэг эхийн оролцоог хангасан хувилбарт сургалтын аргазүйг боловсруулсан.

Монгол улсын Засгийн газраас сургуулийн өмнөх боловсролын (СӨБ) хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилтыг дэвшүүлсээр ирсэн нь бага насны хүүхдийн хөгжил, боловсрол нь төрийн бодлогод чухал байр суурь эзэлдгийг харуулж байна. Төсөл эхлэх үед хэрэгжиж байсан Боловсролын салбарыг 2006-2015 онд хөгжүүлэх Мастер төлөвлөгөөнд СӨБ-ын хамрагдалтыг 99 хувь хүртэл өсгөж, бага насны хүүхдийн хөгжлийн (БНХХ) хэрэгцээг хангахуйц боловсролын чанартай үйлчилгээг бий болгох зорилтыг дэвшүүлж байсан.[3] Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны Үйл ажиллагааны хөтөлбөрт “... Хүүхэд бүрийг цэцэрлэгт хамруулах хөтөлбөр хэрэгжүүлж хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд хамрагдах боломжоор хангах”[4] зорилт дэвшүүлсэн.

СӨБ-ын хамран сургалтын хувь жил бүр бага зэрэг өсөж байгааг доорх График 1- аас харж болох хэдий ч СӨБ-ын хамран сургалт энэ насны хүн амын өсөлтийг (Хүснэгт 2-ийг харна уу) гүйцэж чадахгүй байсаар байна. Ялангуяа хөдөөгийн малчин өрхийн хүүхдүүдийн СӨБ-д хамрагдалт маш доогуур байна. НҮБХС-гийн 2013 онд хийсэн судалгаагаар 36-59 сартай (4-5 настай) хөдөө орон нутгийн хүүхдүүдийн СӨБ-д хамрагдалт 40 гаруй хувьтай байсан байна.

**Хүснэгт 2. Цэцэрлэгийн насны хүүхдийн тоо, ҮСГ**

| Нас | 2012 | 2013 | 2014 | 2015 |
|---|---|---|---|---|
| Нийт хүн ам | 2,867,744 | 2,930,277 | 2,995,949 | 3,057,778 |
| 2 | 57,955 | 62,637 | 68,912 | 80,174 |
| 3 | 63,145 | 59,893 | 65,610 | 74,695 |
| 4 | 59,102 | 64,425 | 61,520 | 70,689 |
| 5 | 52,611 | 59,684 | 65,564 | 64,704 |
| 2-5 настай хүүхдүүд | 232,813 | 246,639 | 261,606 | 290,262 |

Эх сурвалж: ҮСГ

3 ХИС-Монгол дахь хөтөлбөр. 2013. Төслийн суурь судалгааны тайлан.
4 МУЗГ-ын 2016-2020 оны Үйл ажиллагааны хөтөлбөр. http://legalinfo.mn/annex/details/7409?lawid=12120

**График 1. СӨБ–ын хамрагдалт**

БСШУСЯ-ны СӨБ-ын жилийн тайлан 2009-2015




Эх сурвалж: БСШУСЯ-ны СӨБ-ын жилийн тайлангуудаас түүж авав.

Монгол улсын СӨБ-ын тухай хуулинд зааснаар СӨБ-ыг цэцэрлэгийн үндсэн сургалт болон хувилбарт сургалтын хэлбэрээр хүргэдэг. Цэцэрлэгийн үндсэн сургалт нь 2 наснаас сургуульд элсэн орох хүртэлх насны хүүхдийг хамрах ба жил бүрийн 9 дүгээр сарын 1-нээс 36 долоо хоног үргэлжлэхдээ ажлын 5 өдөр бүтэн өдрөөр хичээллэдэг бол хувилбарт сургалтууд нь зун эсвэл хаврын улиралд цөөн цагаар үргэлжилдэг. Үндсэн сургалтад хамрагдаж чадахгүй байгаа хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх зорилго бүхий "хувилбарт сургалт"-уудад хамрагддаг. Үүнд "эзлжийн бүлгийн", "явуулын багшийн", "нүүдлийн бүлгийн" сургалтын үйл ажиллагаа багтдаг.

БСШУ-ны Сайдын 2012 оны А/131 тоот тушаалаар баталсан "Хувилбарт сургалтыг зохион байгуулах журам"-д тус сургалтын нийт үргэлжлэх хугацааг болон ямар хэлбэрээр зохион байгуулахыг зааж өгсөн. Гэсэн хэдий ч бодит байдал дээр нүүдлийн гэр цэцэрлэгийн бүлэг богино хугацаатайгаар холимог бүлгээр зохион байгуулагддаг.

**Хүснэгт 3. Хувилбарт сургалтын стандарт цаг, хэлбэр**

| Хөтөлбөрийн хэлбэр | Цэцэрлэгийн Өдрийн | Ээлжийн | Гэр цэцэрлэг | Явуулын багшийн |
|---|---|---|---|---|
| 2-3 нас | 36 долоо хоног | 240 | | 240 |
| 4 нас | 36 долоо хоног | 280 | 280 | 280 |
| 5 нас | 36 долоо хоног | 360 | 360 | 360 |
| Хэлбэр | | Жилд 2 сараас доошгүй удаа | Жилд 6 сар хүртэлх хугацаа | Сард хоёроос доошгүй удаа өрх гэрт хүрч үйлчлэх |

Эх сурвалж: (БСШУ-ны Сайдын 2012 оны А/131 тушаал)

5 СӨБ-ын тухай хууль. 4.1.9

СӨБ-д хамрагдаж буй хүүхдүүдийн дунд малчдын хүүхдийн эзлэх хувийг насны ангиллаар авч үзвэл (дараах График 2-ыг харна уу), 6 настай СӨБ-д хамрагдаж буй хүүхдүүдийн 51% нь малчдын хүүхэд байгаа нь малчдын хүүхдүүд сургуульд орох нас нь дөхөхөөрөө л СӨБ-д хамрагддаг нь харагдаж байна. Учир нь цэцэрлэгийн үндсэн ангид 9 сарын турш хамрагдах боломжгүй байдаг тул ихэвчлэн хувилбарт сургалтуудаар малчдын хүүхдүүдийг сургуульд бэлтгэдэг. Гэсэн хэдий ч алслагдсан хөдөөгийн малчин өрхийн хүүхдүүд сургуульд шууд бэлтгэлгүй орох тохиолдол нилээдгүй байдаг байсан.

**График 2. СӨБ–ын хүүхдүүдэд малчдын хүүхдийн эзлэх хувь, насаар, БСШУСЯ**




ГБОСБХ нь малчин эцэг эхчүүд хүүхдээ гэр бүлийнхээ тав тухтай орчинд нь, гэр бүл тусгаарлагдахгүйгээр, өрхийн төсөвт дарамтгүйгээр хүүхдээ сургуульд бэлтгэж байгаа нь боловсролын салбарын шинэчлэлийн үзэл санаа болон СӨБ-ын үзэл санаатай нийцэж байгаа юм. Учир нь "Хүүхэд аз жаргалтай, баяр баясгалантай, дуртай, хөгжилтэйгээр суралцах үйлд оролцсон тэр үед өөрсдийн бүхий л боломж, чадвараа дайчлан илүү бүтээлчээр суралцдаг".

Боловсролын чанарын шинэчлэлийн үзэл санааны хүрээнд "хүүхэд бүрт хичээл зааж сургах гэдэг ойлголтоос хүүхэд бүрийг өөрийн гэсэн

6 БСШУЯ. Сургуулийн өмнөх боловсролын цөм хөтөлбөр.
7 БСШУЯ. СӨБ-ийн цөм хөтөлбөр. Удиртгал. 2013 он.

сонирхолтой, суралцах чадвартай, ном унших хүсэлтэй, амьдралын төлөө зүтгэдэг чармайлттай болгоход тусалдаг систем, эцэг эхчүүд, сургууль, багш нартай хамтран ажиллах үүрэг оролцоог хөгжүүлэхийг зорьж байна”. Энэхүү зорилтын хүрээнд ГБОСБХ нь эцэг эхийн оролцоог хангасан, хүүхдийн сурах үйл явцыг дэмжсэн хувилбарт сургалтын шинэлэг хэлбэрийг бий болгож, нэвтрүүлсэн нь боловсролын салбарт оруулж буй томоохон хувь нэмэр юм. Өмнө нь сургуулийн өмнөх насны хүүхдийн боловсрол, асаргаа халамж нь цэцэрлэгт суурилсан байснаас эцэг эхийн оролцоог үгүйсгэдэг, тэднийг хүүхдэдээ боловсрол олгох чадваргүй гэж үздэг байсан.

### Б. Малчин өрхийн онцлог нөхцөл байдалд нийцсэн байдал

Төсөл хэрэгжсэн 30 суманд энэхүү хөтөлбөрөөр хүүхдээ гэр бүлийн орчинд нь сургуульд бэлтгэсэн эцэг эхчүүд өөрсдөө ГБОСБХ нь малчин өрхийн болон орон нутгийн онцлогт нийцтэй байсан гэсэн шалгуураар үнэлэхэд 75% нь маш сайн гэж, 18.5% сайн гэж, 5.9% нь хангалттай гэж үнэлсэн байна.

**График 3. ГБОСБХ–ийн малчин өрхийн онцлогт нийцтэй байдал, 30 сумын үнэлгээний нэгтгэл**




Төслийн суурь судалгаанд дурдсанаар малчин өрх сумын төвөөс алслагдсан байдгаас малаа орхин сумын төв рүү нүүж, 5 настай хүүхдээ цэцэрлэгт хамруулж чаддаггүй, цэцэрлэгт хамруулах гэхээр байлгах айл байдаггүй, дотуур байранд 5 настай хүүхдийг авдаггүй. Төслийн суурь судалгаанд дурдахдаа цэцэрлэгт хамруулахын тулд ээж нар нь сумын төв рүү нүүж ирж, хүүхэдтэйгээ хамт амьдрах хэрэгтэй болдог байсан учраас ихэвчлэн богино хугацааны гэр цэцэрлэгт хамруулдаг байсан. Гэр цэцэрлэгийг зун 3 долоо хоногийн хугацаатайгаар зохион байгуулдаг ба 2-5 насны хүүхдүүдийг ангилалгүйгээр нэг бүлэгт оруулж, ижил сургалтын хэрэглэгдэхүүн ашиглан зохион байгуулдаг учраас үр дүн муутай.[8] Мөн тоглоом наадгай дутмаг байдаг.

8 ХИС. Төслийн суурь судалгааны тайлан. 2013 он

Төсөл хэрэгжүүлэх 30 сумыг сонгохдоо малчин өрхийн хүүхдүүдийн СӨБ-ын хамрагдалт доогуур, сургууль завсардалт хамгийн өндөр сумдыг сонгосон. Үүнд: малчин өрх олонтой, хүн ам ихтэй, СӨБ-ын хамрагдалт доогуур, сургууль завсардалт улсын дунджаас өндөр үзүүлэлттэй, 2009-2010 оны зудад нэрвэгдсэн гэх зэрэг шалгуур үзүүлэлтүүдээр сонгосон.

Эцэг эхчүүд хүүхэдтэйгээ байнга хамт байдаг ч өөрсдөө хүүхдэдээ хэрхэн, юу зааж өгөхөө мэддэггүй байсан. Хөтөлбөр нь эцэг эхчүүдэд хүүхдийнхээ боловсролд чухал үүрэгтэйг ойлгуулж, оролцоог нь нэмэгдүүлсэн. Эцэг эхчүүд нь гэр бүлийнхээ орчинд хүүхдээ сургуульд бэлтгэснээр хүүхдүүд нь гэр бүлээсээ тусгаарлагдахгүйгээр, гэр бүлийн төсөвт нэмэлт дарамтгүйгээр хүүхдээ сургуульд бэлтгэж чадсан байна.

Хүүхдэд зориулсан “Би чадна” номоос гадна, үүнтэй нягт уялдаатай, эцэг эхчүүдэд ойлгомжтой, ашиглахад хялбар “Та өөрөө багш” гарын авлагыг, сонсдог номын хамт боловсруулсан нь малчин эцэг эхчүүд хүүхдэдээ гэр бүлийнхээ тав тухтай орчинд нь  хүүхдээ сургуульд бэлтгэх боломж олгосон. “Эцэг эхчүүдийн боловсролын түвшин харилцан адилгүй. Зарим эцэг эхчүүд уйгаржин бичгийг сурч байсан тул кирилль үсгээ сайн мэддэггүй.” Иймээс эцэг эхчүүдийн гарын авлагыг энгийн, зурган тэмдэглэгээтэйгээр боловсруулсан ба сонсдог номын хэлбэрээр гаргасан нь бичиг үсгийн боловсролоос үл хамааран эцэг эхчүүдэд чухал дэмжлэг болсон байна.

*“Малынхаа бэлчээр дээр байхдаа сонсож чээжилчхээд гэртээ ирээд хүүхдэдээ тайлбарлаж өгдөг” Архангай, Хотонт сумын малчин эцэг эх*



Эцэг эхчүүдийн гарын авлага нь эцэг эхчүүдэд хүүхдийн олон дуу, шүлэг, оньсого чээжлэхэд нь туслахаас гадна өөрсдийн унших, бичих чадвараа сайжруулах боломж олгосон. Эцэг эхчүүд мөн хүүхдийн дуу олныг сурсан гэж байв.

*“Би өөрөө 3-р анги төгссөн. Бараг ном уншдаггүй байсан. Сонгуулийн үеэр сонгуулийн сурталчилгаанаас өөр юм уншиж үзээгүй байсан” Архангай-Өлзийт сумын малчин аав*

“Малчин өрхийн амьдралын хэв маяг, хүүхдийн онцлогт тохирсон сургалтын хөтөлбөр, (ном, тоглоомын багц) багц сургалтын хэрэглэгдэхүүний тусламжтайгаар гэр бүлийн орчинд хүүхдийг сургуульд бэлтгэх боломж бүрдсэн (БСШУСЯ-ны илтгэл, Төслийн хаалтын хэлэлцүүлэг, 2017/05/29).

## B. Хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөр нь дотуур байрын орчин нөхцөл, үйл ажиллагааг сайжруулсан.

Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт "Хөдөөд малчны хүүхэд 6-8 насандаа сонголттойгоор суралцах боломжтой болж, дотуур байрын орчин нөхцөлийг сайжруулна" гэж заасныаас гадна "Бүх шатны боловсрол, сургалтын байгууллагад нийгэм, сэтгэлзүй, дэд бүтцийн эрүүл, аюулгүй, ээлтэй орчин, нийгмийн үйлчилгээг бий болгоно" гэж заасан. Үүнтэй холбоотойгоор 3.2.6.-д "Сурагчид дотуур байрандаа эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг сайжруулж, бага ангийн 6-8 настай хүүхдэд зориулсан асаргаа, халамж, хөгжлийн үйлчилгээтэй болгоно" гэсэн заалтыг тодорхой тусгасан.

2016-2017 оны хичээлийн жилд Монгол улсад нийт 38,968 ор бүхий 513 дотуур байранд 34,598 хүүхэд амьдарч байгаагийн 25,063 нь буюу 72,4% нь малчдын хүүхэд байна. Архангай, Өвөрхангай аймагт дотуур байрын хүүхдүүдийн дунд малчдын хүүхдүүд 81%-87% эзэлж байна.

**Хүснэгт 4. Дотуур байрын хүчин чадал ба хүүхдийн мэдээлэл, 2016–2017, БСШУСЯ**

| 2016-2017 | Дотуур байр | Зориулалтын | Зор/ бус | Хүчин чадал /ор/ | Хүсэлт гаргасан | эм | Үүнээс малчдын хүүхэд | эм | Амьдарч буй хүүхэд | эм | Үүнээс малчдын хүүхэд | эм |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Үндэсний | 513 | 414 | 99 | 38,968 | 37,602 | 19,456 | 26,703 | 13,876 | 34,598 | 17,935 | 25,063 | 13,035 |
| Архангай | 32 | 30 | 2 | 2472 | 2399 | 1302 | 2069 | 1125 | 2232 | 1212 | 1946 | 1059 |
| Өвөрхангай | 32 | 23 | 9 | 1213 | 2213 | 1169 | 1774 | 934 | 2042 | 1081 | 1655 | 875 |
| Дорнод | 23 | 16 | 7 | 1232 | 977 | 469 | 531 | 254 | 908 | 441 | 501 | 242 |
| Сүхбаатар | 15 | 10 | 5 | 1197 | 949 | 545 | 654 | 371 | 864 | 492 | 622 | 348 |

Малчин өрхөд 6 настай хүүхдээ сургуульд оруулахтай зэрэгцэн хэд хэдэн бэрхшээл тулгардаг байсан. Жишээлбэл, хүүхэд дангаараа дотуур байранд байх боломжгүй, биеэ даах чадвар сураагүй, гэрээ санадаг тул сургуульд оруулахын тулд ихэвчлэн ээж нь сумын төвд нүүж ирдэг, аав нь малаа хараад гэртээ үлдэж, залуу гэр бүл хоёр хуваагддаг байсан. Зарим өрх малаа орхин гэр бүлээрээ сумын төвд нүүж ирдгээс малчин өрхийн тооноос хасагдаж, ажилгүй өрхийн ангилалд шилждэг байсан. Хүүхдээ айлд болон дотуур байранд байлгах сонголт хийсэн тохиолдолд хүүхэд гэрээ санаж, хичээлээ давтахгүй байснаар бусад хүүхдээс сурлагаараа хоцрогдоход хүрдэг байсан.

9 МУЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр. http://legalinfo.mn/annex/details/7409?lawid=12120
10 http://www.mecss.gov.mn/data/1701/EBS_2016_2017.pdf

"Хөдөө орон нутагт дотуур байрын хүрэлцээ, хангамж, нөхцөл муугаас малчдын хүүхдүүд сургуульд сурахын тулд айлын хашаанд гэр барьж, дүү нараа харж, өрхийн тэргүүний үүрэг гүйцэтгэж амьдрах тохиолдол олон байна. Энэ нь хүүхдийг хараа хяналтгүй байдалд орхиход хүргэж байна." (БМДИ-ийн сургуулийн нийгмийн ажилтан, дотуур байрын багшийн сургалт хариуцсан аргазүйч, 2014.6.13, http://www.itpd.mn/index.php?r=content/view&id=193)

Сургуульд элсэн орж буй хүүхдүүд ихэнх нь гэрээсээ хол амьдарч үзээгүй, аав ээжээсээ тусгаарлагдаж үзээгүй, бие дааж өөрийгөө хувцаслах, хооллох чадваргүй байдаг. Тухайлбал төслийн суурь судалгаагаар "хүүхдийн сэтгэлзүйн байдал таатай бус, гэрээ их санасан, цочирдсон, халтар, цэвэрч биш, гунигтай царайтай, уйланхай, инээхээ больсон, удаан алхдаг, анхаарлаа төвлөрүүлж чадахгүй, орондоо шээх, гэрийн даалгавраа хийхгүй байх, хувцсаа өмсөөд дотуур байрын гадаа эцэг эхээ хүлээж суух зэрэг шинж тэмдэг илэрдэг байсан.  Мөн Пүрэв, Баасан гарагт эцэг эх нь ирж авахад баяр баясгалантай болж, харин Даваа, Мягмар гарагт сургуульдаа ирэхдээ гунигтай болдог" гэж төслийн суурь судалгаанд дурджээ.

Дотуур байрын тохижилт, амьдрах орчин нь хүүхдэд таагүй орчин байсан. "Зургаан настай хүүхэд сургуульд явдаг болсон, дотуур байрын нөхцөл үнэхээр тохиромжгүй байна. Тэднийг асран хамгаалах багшийн хүрэлцээ байхгүй. Нялхаараа байгаа хүүхдүүд гэрээсээ хол хямарна. Сургуулийн амьдралд дасах гэж хэсэг хямарна. Ээжийнхээ мөөмнөөс гараагүй хүүхдүүдийг гэрээс нь хол дотуур байранд байлгаж байгаад их санаа зовж байна. Нөгөө талаас зургаан настай хүүхдээ сургуульд явуулах гээд зарим залуу гэр бүл хоёр тусдаа амьдарч эхэлж байна. Аав нь малаа хараад үлддэг. Ээж нь төвд хүүхдээ эргэж тойрч тусдаа байдаг. Энэ нь эргээд гэр бүл салах шалтгаан болж байгаа юм билээ. Ер нь Хүүхдийн эрхийн хорооноос сануулга ирсэн. Дотуур байранд хуарангийн нөхцөлд хүүхдийг амьдруулна гэдэг бол хүүхдийн амьдралд гэм хор учруулсан зохимжгүй орчин учраас Хүүхдийн эрхийн хорооноос дотуур байрын хүүхдийг эцэг эхтэй нь ойр байлгах, дотуур байрын нөхцөл байдлыг гэр орны нөхцөлтэй дүйцүүлэх хэмжээнд тусгай хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагатай гэсэн санал тавьсан. Нөгөө талаас эцэг, эх хүүхэдтэйгээ долоо хоногт биш юм аа гэхэд сар бүр ирж уулздаг болох ёстой[11]" гэж 2014 онд болсон "Дотуур байрын орчин нөхцөлийг сайжруулах арга зам" зөвлөлдөх уулзалтаар санал дэвшүүлж байжээ.

11 "Дотуур байран дахь хүүхэд хамгаалал" зөвлөлдөх уулзалт, 2014,07,03. Хүүхэд хамгааллын үндэсний сүлжээ, Нээлттэй нийгэм форумтай хамтарч "Дотуур байран дахь хүүхэд хамгаалал, стратегийн өмгөөлөл" төслийг хэрэгжүүлж байгаа бөгөөд энэ хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн 16 дотуур байранд очиж судалгаа явуулжээ. https://dnn.mn

Дотуур байрын багшийн хувьд дунджаар 80-100 хүүхдэд нэг багш ноогддог гэхээр хүүхэдтэй тулж ажиллах ямар ч боломжгүй. Иймээс хүүхдүүд багштайгаа чөлөөтэй ярилцаж, асуулт асуухаасаа айдаг. Дотуур байрын багш нар хүүхдэд амьдрах ур чадвар зааж сургах, бусад хичээлийн бус арга хэмжээг зохион явуулах үүрэгтэй боловч тогтмол явуулдаг үйл ажиллагааны хөтөлбөргүй байжээ.

Айлд байдаг хүүхдүүдийн хувьд бүр ч олон бэрхшээлтэй тулгардаг. Тухайлбал чөлөөтэй байж чаддаггүй, гэрийн ажлаас хийлцэх хэрэгтэй болдог, хамт тоглох ярилцах хүүхэд байхгүй, тогтмол цагт хооллодоггүй, асран хамгаалагчаас хамааралтай зэрэг бэрхшээлтэй тулгардаг. Дотуур байр эсвэл айлд байдаг бага ангийн хүүхдүүдэд сургуулийн шинэ орчинд дасан зохицоход нь туслах хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөр байхгүй байсан.

Иймээс дотуур байранд болон айлд амьдардаг бага ангийн хүүхдүүдэд зориулсан Хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөр боловсруулсан нь бага боловсролын үр дүнг сайжруулахад болон малчдын хүүхдүүдийн суралцах орчинг сайжруулахад чухал хувь нэмэр оруулсан.

### Г. ХБЦНХ-ийн малчин өрхийн онцлогт нийцтэй байдал

Дотуур байранд болон айлд амьдардаг малчин өрхийн 1-5 ангийн хүүхдүүдэд зориулж Хүүхэд хөгжлийн танхимыг тохижуулж, Хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөрийг хэрэгжүүлснийг эцэг эх, асран хамгаалагчид 4 түвшнээр үнэлэхдээ 66,3% нь маш сайн гэж, 21,1% нь сайн гэж, 12% нь хангалттай хэрэгжсэн гэж, 0,5% нь сайжруулах шаардлага бий гэж үнэлсэн.

**График 4. ХБЦНХ-ийн нийцтэй байдал, 30 сумын үнэлгээний нэгтгэл**



Энэхүү Зорилтыг үнэлэхэд оролцсон эцэг эх, асран хамгаалагчийг төлөөлж, хэлэлцүүлэгт оролцсон 800 орчим асран хамгаалагчдаас малчин эцэг эхчүүд ихэвчлэн алслагдсан байдгаас хүүхдүүдийг нь түр асран халамжилж байгаа айлын төлөөлөл болж буй асран хамгаалагчид нэлээд оролцсон тул зарим нь Хүүхэд хөгжлийн танхимаар орж үзээгүй, ХБЦНХ-ийн талаар мэдээлэл муутай байсныг дурдах нь зүйтэй.

### Хүснэгт 5. ГБОСБХ-ийн өмнө ба дараах өөрчлөлт

| № | Төсөл хэрэгжихээс өмнөх нөхцөл байдал ба бэрхшээл | Төсөл хэрэгжсэнээр гарсан үр дүн, өөрчлөлт |
|---|---|---|
| 1 | Эцэг эхчүүд хүүхдээ сургуульд явуулахын тулд гэр бүл тусгаарлагдахад хүрдэг байсан. | Хүүхдүүддээ санаа зовохгүйгээр аав ээж нь гэртээ санаа амар хамтдаа малаа маллаж үлддэг болсон. |
| 2 | Гэр бүлээрээ сумын төв рүү нүүж ирэх тохиолдолд малчин өрхийн тоо буурч, ажилгүйчүүдийн тоо нэмэгддэг байсан. | Малчин өрхийн тоо буурахгүй, ажилгүйдэл нэмэгдэхгүй. |
| 3 | Эцэг эхчүүд хүүхдэдээ байнга санаа зовдог, байн байн эргэж ирдэг байсан. | Эцэг эхчүүд хүүхдээ аюулгүй, аз жаргалтай байгааг мэдэж, санаа амар байх болсон. |
| 4 | Хүүхдийг нь гэртээ байлгаж буй айлын хүмүүс хүүхэдтэй яаж харилцахаа мэддэггүй байсан. | Хүүхдийг гэртээ байлгаж байгаа айлынхан хүүхдийн хичээл сурлагад санаа зовохгүй байх болсон. |
| 5 | Хүүхдүүд гэрээ санаж, сэтгэл санааны гутралд ордог байсан. "Аав ээжийгээ ирж авахыг хүлээгээд гадаа хувцсаа өмсөөд сууж байдаг" | Хүүхдүүд үе тэнгийнхэнтэйгээ тоглож, аз жаргалтай байдаг болсон. Амралтын өдрөөр гэртээ харихдаа Хүүхэд хөгжлийн танхим руугаа яардаг болсон. |
| 6 | Хүүхдүүдэд чөлөөт цагаараа хийх зүйл байхгүй телевиз үзэж эвсэл гадаа дэлгүүр, айл хэсэж өнгөрөөдөг байсан. | Хүүхдүүд даалгавраа хийж, гар урлалын бүтээл хийж, авьяасаа хөгжүүлэх төрөл бүрийн үйл ажиллагаанд хамрагдаж байна. |
| 7 | Айлд байгаа хүүхдүүд хамт тоглох хүүхэд байхгүй, дэмжлэг байхгүй уйддаг байсан. | Хүүхэд төвдөө бусад олон хүүхдүүдтэй тоглож, хамтран суралцаж, хүүхдийн оролцооны байгууллагад бие биедээ тусалдаг болсон. |
| 8 | Дотуур байранд хүүхэд хөгжлийн хөтөлбөр, стандарт, аргазүй огт байхгүй байсан. | Дотуур байранд бага ангийн хүүхдүүдэд чиглэсэн Хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөр бий болсон. |
| 9 | Дотуур байрны орчин бага насны хүүхдүүдэд ээлтэй бус байсан. | Дотуур байранд Хүүхэд хөгжлийн танхим байгуулагдаж, бага насны хүүхдэд зориулсан ном, тоглоом бусад сургалтын материалуудтай болгосон. |

12 ХИС. Төслийн суурь судалгааны тайлан. 2013 он.

**Зураг 1. ХБЦНХ-ийн өмнөх (дээд талын зураг) ба дараах (доод талын зураг) нөхцөлийг харьцуулсан зураг, Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын хэлэлцүүлэг 2.**



### Д. Бага боловсролыг нөхөн олгоход дэмжлэг үзүүлэх хичээлийн хөтөлбөрийг боловсруулж нутагшуулсан.

Монгол улсын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх "Мастер төлөвлөгөө"-нд малчин өрхийн хүүхдүүд боловсролд тэгш хамрагдах боломжоор хангагдаагүй байгааг дурдаад завсардсан хүүхдийг "сургуульд буцааж суралцуулах тусгай хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх" зорилт дэвшүүлсэн[13] байна.

"Боловсрол" үндэсний хөтөлбөрт (2010-2021) "Суралцагчдад хүртээмжтэй, чанартай, хэрэгцээнд нь нийцсэн боловсрол эзэмших тэгш боломжийг бүрдүүлэх" гэсэн стратегийн зорилт дэвшүүлсэн бөгөөд түүний хүрээнд "Боловсрол нөхөн олгоход дэмжлэг үзүүлэх" арга хэмжээг хэрэгжүүлэхдээ: сургуулийн гадна байгаа сургуулийн насны хүүхдийг боловсролын үйлчилгээнд хамруулах бодлого боловсруулж хэрэгжүүлэх, боловсролын стандарттай уялдуулан бага, суурь, бүрэн дунд боловсрол нөхөн олгох сургалтын агуулга, арга хэлбэрийг боловсронгуй болгох тухай заасан байна.[14]

13 Монгол улсын Боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө, УБ, 2006, х.29

14 Боловсрол үндэсний хөтөлбөр 2010-2021, Монгол улсын Засгийн газрын 2010 оны 31 дүгээр тогтоолоор баталсан

Бага, суурь, бүрэн дунд боловсролоос завсардсан суралцагчдад боловсрол нөхөн олгох албан бус сургалтыг Дүйцсэн хөтөлбөрийн сургалт хэмээдэг ба бага боловсролын дүйцсэн хөтөлбөрт 10 наснаас дээш насны хүүхдийг хамруулахаар заасан байдаг нь бага ангиасаа завсардсан эсвэл сургуульд огт ороогүй хүүхдүүдэд боловсрол нөхөн олгоход хүндрэлтэй байдаг. Дүйцсэн хөтөлбөрөөр суралцагчдын мэдээллийг 12 нас хүртэлх ангиллаар 2012-2013 оны үзүүлэлтийг харьцуулахад 2016-2017 онд бага насны хүүхдийн завсардалт зорилтот аймгуудад улсын дундажтай харьцуулахад эрс багассан байна.

**Хүснэгт 6. Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн хөтөлбөрөөр суралцагчид, насны бүлгээр, 2016–2017, БСШУСЯ**

| 2016-2017 | суралцагчид | эм | Нас <10 | эм | 11 нас | эм | 12 нас | эм |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Үндэсний | 9,116 | 2,761 | 296 | 86 | 187 | 55 | 301 | 61 |
| Архангай | 452 | 120 | 2 | | 4 | | 7 | |
| Өвөрхангай | 512 | 141 | 5 | 0 | 4 | 1 | 6 | - |
| Дорнод | 125 | 49 | | | | | 2 | |
| Сүхбаатар | 488 | 165 | 12 | 3 | 5 | 1 | 10 | - |
| 2012-2013 | суралцагчид | эм | <10 | эм | 11 | эм | 12 | эм |
| Үндэсний | 11,810 | 3794 | 398 | 129 | 252 | 97 | 377 | 126 |
| Архангай | 625 | 196 | 9 | 2 | 13 | 6 | 18 | 7 |
| Өвөрхангай | 761 | 245 | 18 | 4 | 19 | 6 | 28 | 13 |
| Дорнод | 308 | 104 | 7 | 4 | 4 | 0 | 7 | 4 |
| Сүхбаатар | 608 | 212 | 9 | 3 | 8 | 2 | 16 | 3 |

Ихэвчлэн гэрээсээ хол, айлд байхаар гэрээ санадаг, хичээлийн хоцрогдолтой учраас сургуульд явах дургүй болсон зэрэг шалтгаанаас сургууль завсардалт эрс багассан тул Бага боловсрол нөхөн олгох хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд (ХБХ)-ийг хамруулсан байна. ЕБС-д суралцахгүй байгаа 6-14 насны хүүхдүүдийн тоог 2012-2013 онтой харьцуулахад 2016-2017 онд зорилтот аймгуудад 4-7 дахин буурсан ба ялангуяа Дорнод, Сүхбаатар аймагт эрс багассан байна.

**Хүснэгт 7. ЕБС-д суралцдаггүй 6-14 насны хүүхдүүд, шалтгаанаар, 2012-2013 ба 2016-2017, БСШУСЯ**

| Аймаг 2016-2017 | бүгд | эм | Амьдралын гачигдлаас | Сурах дургүйгээс | Ажил эрхлэхээр | Өвчний улмаас | Шалтгаан тодорхойгүй | Сургуульд огт ороогүй | Ороод завсардсан |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Үндэсний | 445 | 150 | 65 | 24 | - | 193 | 163 | 341 | 104 |
| Архангай | 42 | 11 | 5 | 5 | - | 24 | 8 | 26 | 16 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Өвөрхангай | 36 | 15 | 3 | 4 | - | 11 | 18 | 25 | 11 |
| Дорнод | 1 | 1 | | | 1 | | | 1 | |
| Сүхбаатар | 9 | 1 | | | 9 | | | 8 | 1 |
| 2012-2013 | бүгд | эм | Амьдралын гачигдлаас | Сурах дургүйгээс | Ажил эрхлэхээр | Өвчний улмаас | Шалтгаан тодорхойгүй | Сургуульд огт ороогүй | Ороод завсардсан |
| Үндэсний | 2332 | 937 | 836 | 180 | 70 | 815 | 431 | 1267 | 1065 |
| Архангай | 147 | 60 | 42 | 18 | 6 | 65 | 16 | 59 | 88 |
| Өвөрхангай | 248 | 79 | 118 | 29 | 0 | 68 | 33 | 105 | 143 |
| Дорнод | 47 | 17 | 24 | 2 | 5 | 11 | 5 | 30 | 17 |
| Сүхбаатар | 100 | 28 | 22 | 1 | 2 | 66 | 9 | 49 | 51 |

Бага боловсролоос завсардсан хүүхдүүд ихэвчлэн сургуульд огт ороогүй эсвэл хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байдаг ба хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг сумын сургуульд хүлээн авахад бэлэн биш учраас сургуулиас завсардсан байсан. Орон нутагт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тусгай боловсрол эзэмшүүлэх бүтэц, чадавх байдаггүй. Хөнгөн хэлбэрийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн сургуулийн ангид сургахаас өөр сонголт байдаггүй байсан. Сонсголын болон харааны бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан төвлөрсөн тусгай сургууль зөвхөн Улаанбаатар хотод байдаг. Харин алслагдсан хөдөөгийн малчин эцэг эхчүүд хүүхдээ Улаанбаатар хот руу явуулж сургах боломж байдаггүй байсан ба хөдөлгөөний бэрхшээлтэй, тэргэнцэртэй болон Аутизм, Дауны синдром зэрэг оюуны бэрхшээлтэй хүүхдүүдэд бага боловсрол эзэмших боломж байдаггүй байсан.

Өнөөдөр манай улсад насан туршийн боловсролын 374 “Гэгээрэл” төв дүүрэг, сум бүрт үйл ажиллагаагаа явуулж байна. Тус төв нь сургууль завсардсан иргэдэд бага, суурь, бүрэн дунд боловсролыг дүйцсэн хөтөлбөрийн сургалтаар нөхөн эзэмшүүлэх, насанд хүрэгчдэд бичиг үсэг, амьдрах ухааны боловсрол олгох үйл ажиллагааг зохион байгуулж, иргэдийн боловсрол эзэмших хэрэгцээг хангаж, сургууль завсардалтыг бууруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Түүнчлэн насан туршийн боловсролын үндсэн зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь дараах 5 үндсэн чиглэлтэй. Үүнд:

1. Гэр бүлийн боловсрол
2. Иргэний боловсрол
3. Ёс суртахуун-төлөвшлийн боловсрол
4. Гоо зүй-мэдрэмжийн боловсрол
5. Амьдрах ухааны боловсрол

Бага боловсролоос завсардсан хүүхдүүдийн хувьд бичиг үсэг бүрэн сураагүй байдаг тул цаашид суралцах боломжгүй байдаг. Иймээс ББНОХ-ийг сургалтын хэрэглэгдэхүүний хамт боловсруулж, НТБ-ын төв дээр танхим байгуулснаар бага боловсролоос завсардсан хүүхдүүдэд Монгол хэл, Математикийн боловсролыг нөхөн олгох боломж бүрдсэн.

Гэр бүлийн орчинд бага насны хүүхдийг хөгжүүлэх, боловсрол нөхөн олгоход эцэг эхийн оролцоо чухал учраас хөтөлбөрийн агуулга, гарын авлагыг боловсруулахдаа “Эцэг эхийн ашиглах ном”, “Хүүхдийн ашиглах ном”-ыг хоорондоо уялдаатай байхаар тусад нь боловсруулсан нь эцэг эхчүүдэд хүүхдэдээ боловсрол нөхөн олгоход туслах аргазүй, мэдлэгийг олгосон байна. Мөн хөтөлбөрийг хичээлүүдэд хуваадж, тус бүр 12-оос 16 нүүр, дээд тал нь 44 нүүр байхаар тус тусад нь хэвлэж, хадгалалт тээвэрлэлтэд тэсвэртэй хавтсанд хийж өгсөн нь багш, хүүхэд, эцэг эхчүүд өөрсдийн ашиглаж буй модулиа сугалж авч ашиглах боломжтой болгосон байна.



## Е. ББНОХ-ийн малчин өрхийн онцлогт нийцсэн байдал

Зорилтот бүлгийн онцлогт нийцтэй эсэхийг төслийн шууд үр шимийг хүртсэн эцэг эхчүүд, оролцогч талууд үнэлэхдээ 66% нь маш сайн гэж, 23,2% нь сайн гэж, 10,8% нь боломжийн хэрэгжсэн гэж үнэлсэн.

**График 5. ББНОХ–ийн нийцтэй байдал, 30 сумын үнэлгээний нэгтгэл**




Энэ хөтөлбөр хэрэгжсэнээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн илрүүлэлт, боловсролд хамран сургалт нэмэгдсэн. Бага боловсрол нөхөн олгох хөтөлбөр, номын багц нь бага ангиас сургууль завсардсан эсвэл сургуульд огт суралцаж байгаагүй 8-10 насны малчин өрхийн хүүхдүүд, тэдгээрийн эцэг эхэд зааж сургах, улмаар сургуульд эргэн суралцах үйл явцыг дэмжихэд бодитой хувь нэмэр оруулжээ. Хэлэлцүүлэгт оролцогчид хөтөлбөрийн нийцтэй байдлыг дараах байдлаар тайлбарлаж байсан. Доорх хүснэгтийг харна уу.

**Хүснэгт 8. Хүүхэд ба эцэг эхчүүд – ББНОХ–ийн өмнө ба дараа**

| № | Төсөл хэрэгжихээс өмнөх нөхцөл байдал ба бэрхшээл | Төсөл хэрэгжсэнээр гарсан үр дүн, өөрчлөлт |
|---|---|---|
| 1 | Сургууль завсардсан, сургуулиас гадуур байгаа хүүхдүүдэд зориулсан сургууль, багш, эцэг эхчүүд ашиглаж болох хялбар хөтөлбөр байгаагүй. | Монгол хэл, Математикийн хичээ-лийн цогц хөтөлбөр, сургалтын хэрэглэгдэхүүний хамт боловсруулснаар ХБХ-үүдийг тэгш хамруулан сургах нөхцөл бий болсон. |
| 2 | Сургуулиас завсардсан хүүхдүүд сургуульд дасан зохицоогүй, сурах сонирхолгүй байсан. | Хүүхдүүд унших, бичих болон Математикийн үндсэн мэдлэгээ эзэмшсэнийхээ дараа сургуульд үргэлжлүүлэн суралцдаг. |
| 3 | Хөдөө орон нутагт байгаа хөгжлийн бэрхшээлтэй бага насны хүүхдүүд сургууль, багшийн талаар анхны мэдэгдэхүүнгүй. | ХБХ-үүд Насан туршийн боловсролын төвөөөр дамжуулан сургуульд сурч, хичээл, сургуульд дуртай, сурах эрмэлзэлтэй болсон. |
| 4 | ХБХ-үүд байнга гэртээ байдаг учраас хүнтэй харьцах чадвар муу, нийгэм-шээгүй байсан. | Нийгэмшсэн нь бусад хүүхэдтэй харилцдаг болсон. |
| 5 | Эцэг эхчүүд нь хүүхдээ унших, бичиж сургах ямар ч боломжгүй гэж үздэг байсан. | Эцэг эхчүүд ХБ-тэй хүүхдээ унших, бичиж сургах эрмэлзэлтэй болж, дэмжлэг үзүүлэх болсон. |
| 6 | Сургууль ХБХ-ийг илрүүлэх алхам хийдэггүй байсан. | ХБХ-ийг илрүүлэх, тодорхойлох, оношлох чиглэлээр хамтын ажиллагаа нэмэгдсэн. |

### 2.1.2. Боловсролын салбарын бодлогод оруулсан хувь нэмэр

Тус төсөл нь боловсролын салбарын хөгжилд дараах гурван чухал хувь нэмрийг оруулсан.

1. Сургуулийн өмнөх боловсролыг гэр бүлийн орчинд эцэг эхчүүд өөрсдөө олгох ГБОСБХ-ийг боловсруулан сургууль, цэцэрлэгээр дамжуулан нутагшуулсан нь хөдөөгийн алслагдсан малчдын хүүхдийг СӨБ-д хамруулах хувилбарт сургалтын хэлбэрийг баяжуулсан, эцэг эхчүүдийн оролцоог нэмэгдүүлсэн, гэр бүлийн халуун дулаан уур амьсгал дунд хүүхдийн сурах орчинг бүрдүүлсэн үр дүнтэй хувилбар бий болсон.

БСШУСЯ-наас ГБОСБХ-ийг хувилбарт сургалтын шинэ хэлбэр болгон хөгжүүлэх, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах чиглэлээр судалгаа, дүн шинжилгээ хийж байна (БСШУСЯ-ны илтгэл, Төслийн хаалтын хэлэлцүүлэг, 2017/05/09).

2. Сургуульд суралцах хугацаандаа гэр бүлээсээ тусдаа амьдарч байгаа хүүхдийн сургууль, дотуур байрын амьдралд дасан зохицох, сурах, хөгжих үйл явцыг нь дэмжих хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөрийг бий болгосон. Хөдөөгийн сургуулийн дотуур байранд Хүүхэд хөгжлийн танхимыг байгуулан Хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлсэн нь дотуур байрын өдөр тутмын үйл ажиллагааг идэвхжүүлж, хүүхдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хүүхдийн оролцоог дэмжих хөтөлбөрийн стандартыг хөгжүүлэх үндэс суурь болсноос гадна хүүхдийг сургуульдаа дуртай болгох, нийгмийн ур чадварууд болон авьяасыг нь хөгжүүлэх, улмаар хүүхдийн хичээлийн хоцрогдлоос урьдчилан сэргийлэх, сургалтын амжилтыг ахиулах хөтөлбөр болсон. Энэ хөтөлбөрийг бусад сумдад түгээн дэлгэрүүлэхэд зардал өртөг их шаардахгүй тул бусад аймаг сумдын дотуур байранд авч ашиглах бүрэн боломжтой.

БСШУСЯ-наас дотуур байрын багшийн тасралтгүй хөгжлийг хангах, нэмэлт орон тоо бий болгох асуудлаар эрхзүйн баримт бичигт тусган хэрэгжүүлэх бодлого баримталж байна. МУЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт дотуур байранд бага насны хүүхэдтэй ажиллах асрагч багшийн орон тоо бий болгох зорилт дэвшүүлсэн (БСШУСЯ-ны илтгэл, Төслийн хаалтын хэлэлцүүлэг, 2017/05/09).

3.Бага боловсрол нөхөн олгох хөтөлбөр, багцыг боловсруулж, амжилттай туршин нутагшуулснаар хөдөө орон нутагт амьдарч буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, бусад шалтгаанаар сургуулиас гадуур байгаа хүүхдүүд болон эх хэл дээрээ бичих, унших чадвараа сайжруулах шаардлагатай бусад хүүхдүүд эцэг эх, багш нар, олон нийтийн дэмжлэгтэйгээр бага боловсролд тэгш хамрагдах боломжийг бий болголоо.

“Тус багцыг зорилтот бус 9 сумын дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж буй 1-3-р ангийн 180 гаруй хүүхдүүд, тэдний эцэг эхэд ашиглуулж, туршлаа. Сүм хийдэд суугаа лам хүүхдүүдийн сурах эрхийг хангах зорилгоор Гандантпунцаглан хийдийн 28, Шанх баруун хүрээ, Эрдэнэзуу хийдийн 30 лам хүүхдийг хамруулж, тэдэнд бага боловсрол эзэмших боломжийг бүрдүүллээ” (Өвөрхангай, ТОНЗ).

4. Нутгийн захиргааны болон боловсролын байгууллагууд, эцэг эх, олон нийт бага насны хүүхдийн хөгжлийн асуудлаар хамтран ажиллах нь үр дүнтэй болохыг олон нийтэд харуулсан. Малчдын 5-10 насны хүүхдийн өмнө тулгамдаж буй боловсролын асуудлыг шийдвэрлэхэд оролцогч талуудын оролцоог хангах зорилго бүхий олон нийтийн төлөөллөөс бүрдсэн, сайн дурын үндсэн дээр нэгдсэн, орон тооны бус Олон нийтийн боловсролын зөвлөл (ОНБЗ) гэсэн бүтцийг бий болгож, туршсан нь эцэг эх, сургууль, багш, орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын үүрэг, оролцоо чухал болохыг харуулж, сургууль, цэцэрлэгийн хамтын ажиллагаа, залгамж холбоо сайжирсан.

2016 онд Боловсролын тухай хуульд дараах нэмэлт өөрчлөлтүүдийг оруулсан нь бага насны хүүхдийн боловсролд эцэг эх, олон нийтийн оролцоог баталгаажуулж өгсөн. Үүнд Бага, дунд боловсролын тухай хуулинд захирлын үүрэгт:

- 20.2.2: “.... хөтөлбөр, төлөвлөгөө, дүрэм, журам боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулахад... эцэг эх, олон нийтийн оролцоо, түншлэлийг ханган ажиллах”
- 20.2.4: сургуулийн төсөв, санхүүгийн үйл ажиллагааг .... эцэг эхийн оролцоотой төлөвлөх,..... Зарцуулах”
- 20.2.11: “шийдвэр гаргахад ... эцэг эх, олон нийтийн оролцоог хангах....”
- 46.2.5: Эцэг эх, асран хамгаалагчийн үүрэгт шинээр “боловсрол эзэмшихэд нь хүүхдэдээ байнга дэмжлэг, туслалцаа үзүүлэх, урамшуулан дэмжих”
- 46.2.6: “хүүхдийнхээ суралцах, төлөвших, авьяасыг хөгжүүлэх сургалт, үйл ажиллагааны явц, үр дүнтэй танилцах” үүрэгтэй гэж заасан.

## 2.2. ТӨСЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛГЫН БИЕЛЭЛТ, ҮР ДҮН

### 2.2.1. Гэр бүлийн орчинд хүүхдийг сургуульд бэлтгэх хөтөлбөрийн үр дүн, биелэлт

Төслийн бичиг баримтад дунд хугацааны үнэлгээний дараа оруулсан өөрчлөлтөөр ГБОСБХ-ийн чиглэлээр дараах үр дүнг гаргахаар заасан.

**Хүснэгт 9. Төслийн үр дүнгийн хүрээний ГБОСБХ-тэй холбоотой шалгуур үзүүлэлтүүдийн биелэлт**

| Статус | Зорилтын шалгуур үзүүлэлтүүд | Суурь үзүүлэлт | Эцсийн үзүүлэлт | Хэрэгжилт |
|---|---|---|---|---|
| Шинээр нэмэгдсэн | ГБОСБХ-өөр сургуульд амжилттай бэлтгэгдсэн зорилтот бүлгийн хүүхдүүдийн тоо | 0 | 3,300 | 3,804 |
| Хасагдсан | Сургууль, дотуур байрын орчинд дасаж чадахгүй, хичээлийн хоцрогдлоос шалтгаалан 1-3 дугаар ангидаа сургууль завсардаж буй хүүхдийн тоог бууруулах. | 0 | 25% | |
| Статус | Үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд | Суурь үзүүлэлт | Эцсийн үзүүлэлт | Хэрэгжилт |
| Хэвээрээ | Сургуульд бэлтгэх ном, тоглоомын багц, Миний Номын Өргөөг зорилтот 30 суманд | 0 | 30 | 45 |
| Хэвээрээ | ГБОСБХ-ийг боловсруулж, туршин, 30 суманд хэрэгжүүлнэ. | 30 | 30 | 30 |

Энэхүү бүрэлдэхүүний хүрээнд Гэр бүлийн орчинд сургуульд бэлтгэх хөтөлбөрийг боловсруулж, туршин, 4 аймгийн зорилтот 30 суманд хэрэгжүүлсэн. Энэхүү хөтөлбөр нь хүүхдэд СӨБ-ын 6 үндсэн ур чадварыг олгоход чиглэсэн.

Түүнчлэн зорилтот 30 сумын сургууль, аймгийн төвийн 2 номын сан, Архангай, Дорнод аймгийн Багшийн Коллеж зэрэг газруудад нийт 45 Миний номын өргөөг байгуулсан. Эдгээр номын өргөө нь эцэг эхчүүд болон хөтөлбөрт хамрагдаж буй хүүхдүүдэд ном, тоглоомын багцыг түгээх, аргазүйн дэмжлэг үзүүлэх зорилготой. Ном, тоглоомын нэг багц нь 3 тоглоом, 10 номноос бүрдэж байсан ба хүүхдүүд 10 багцыг судалж дуусахдаа нийт 30 өөр өөр тоглоом, 100 номыг судалж дуусгасан байна.

#### А. ГБОСХ-оор 4 аймгийн 30 суманд 4 жилд 3,800 хүүхэд сургуульд бэлтгэгдлээ.

Төсөл хэрэгжих хугацаанд 30 сум, 4 аймгийн төвийн номын сангаар дамжин хэрэгжүүлсэн ГБОСБХ-өөр нийт 3,804 хүүхэд гэр бүлийн орчиндоо сургуульд

бэлтгэгдсэн байна. Жил тутам зорилтот суманд 1,000 гаруй хүүхэд сургуульд бэлтгэгдэж байгаа нь эдгээр 30 суманд СӨБ-д хамрагдаж буй 2-6 насны нийт хүүхдийн 1/3 –тэй тэнцүү байна. Эдгээрээс ГБОСБХ-ийн үнэлгээний хэлэлцүүлэгт 590 гаруй эцэг эхчүүд, сургагч багш нар буюу нийт үр шимийг хүртэгчдийн 16% нь оролцсон.

### Хүснэгт 10. Сургуульд бэлтгэх хөтөлбөрийн үр шим хүртэгч хүүхдүүд, ХИС

| Аймаг | Сумын нэр | Жил II | | Жил III | | Жил IV | | Жил V – 2016 оны 12 сарын байдлаар | | Жил V – 2017 оны 3 сарын байдлаар | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Эр | Эм | Эр | Эм | Эр | Эм | Эр | Эм | Эр | Эм |
| | Аймгийн төв | | | 7 | 3 | | 1 | | | | |
| Архангай | Жаргалант | 9 | 8 | 24 | 34 | 22 | 12 | 22 | 19 | 22 | 19 |
| | Өлзийт | 6 | 10 | 37 | 21 | 9 | 24 | 18 | 9 | 18 | 9 |
| | Өндөр-Улаан | 11 | 7 | 42 | 16 | 15 | 9 | 12 | 18 | 11 | 19 |
| | Тариат | 8 | 8 | 32 | 21 | 9 | 13 | 12 | 12 | 12 | 12 |
| | Хайрхан | 11 | 6 | 27 | 29 | 13 | 11 | 16 | 12 | 16 | 12 |
| | Хангай | 11 | 5 | 21 | 23 | 16 | 16 | 14 | 16 | 14 | 16 |
| | Хашаат | 8 | 6 | 27 | 30 | 19 | 17 | 15 | 16 | 15 | 16 |
| | Хотонт | 11 | 7 | 17 | 11 | 25 | 21 | 17 | 17 | 18 | 17 |
| | Цэцэрлэг | 8 | 8 | 31 | 21 | 19 | 7 | 9 | 20 | 10 | 20 |
| | Эрдэнэмандал | 12 | 5 | 28 | 30 | 8 | 6 | 8 | 14 | 8 | 14 |
| | Дүн | 95 | 70 | 293 | 239 | 155 | 137 | 143 | 153 | 144 | 154 |
| | Аймгийн төв | | | 13 | 7 | 12 | 11 | 14 | 10 | 14 | 10 |
| Өвөрхангай | Баянгол | 7 | 8 | 27 | 31 | 21 | 20 | 23 | 21 | 23 | 21 |
| | Баян-Өндөр | 9 | 7 | 27 | 31 | 24 | 22 | 20 | 7 | 20 | 7 |
| | Богд | 7 | 9 | 48 | 33 | 45 | 35 | 40 | 25 | 40 | 25 |
| | Бүрд | 11 | 9 | 15 | 11 | 12 | 15 | 13 | 12 | 13 | 12 |
| | Есөнзүйл | 10 | 11 | 12 | 16 | 19 | 15 | 16 | 12 | 16 | 12 |
| | Зүүнбаян-Улаан | 8 | 8 | 13 | 10 | 10 | 8 | 5 | 5 | 5 | 5 |
| | Сант | 6 | 10 | 16 | 12 | 19 | 11 | 13 | 10 | 13 | 10 |
| | Тарагт | 7 | 9 | 12 | 12 | 12 | 9 | 15 | 16 | 15 | 16 |
| | Уянга | 7 | 9 | 32 | 28 | 62 | 79 | 78 | 88 | 78 | 88 |
| | Хайрхандулаан | 5 | 11 | 17 | 11 | 13 | 17 | 22 | 19 | 22 | 19 |
| | Дүн | 77 | 91 | 232 | 202 | 249 | 242 | 259 | 225 | 259 | 225 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Аймгийн төв | | | 13 | 7 | 19 | 17 | 10 | 9 | 15 | 9 |
| Дорнод | Хан-Уул цогцолбор сургууль | | | | | | | | | 8 | 8 |
| | Матад | 9 | 7 | 16 | 10 | 17 | 3 | 10 | 5 | 12 | 3 |
| | Сэргэлэн | 4 | 8 | 9 | 9 | 13 | 11 | 8 | 8 | 8 | 8 |
| | Халхгол | 10 | 6 | 10 | 12 | 18 | 16 | 12 | 9 | 12 | 10 |
| | Ялалт баг | | | | | | | 5 | 3 | 5 | 4 |
| | Цагаан-Овоо | 9 | 7 | 19 | 20 | 13 | 8 | 5 | 4 | 10 | 5 |
| | Чойбалсан | 9 | 7 | 15 | 11 | 9 | 13 | 4 | 5 | 5 | 7 |
| | Дүн | 41 | 35 | 82 | 69 | 89 | 68 | 54 | 43 | 75 | 54 |
| | Аймгийн төв | | | 8 | 12 | | | | | | |
| Сүхбаатар | Баяндэлгэр | 9 | 3 | 10 | 8 | 14 | 11 | 11 | 10 | 13 | 11 |
| | Мөнххаан | 6 | 8 | 12 | 10 | 11 | 10 | 11 | 3 | 8 | 7 |
| | Онгон | 5 | 5 | 5 | 8 | 15 | 23 | 12 | 6 | 11 | 9 |
| | Уулбаян | 6 | 6 | 9 | 3 | 14 | 6 | 12 | 5 | 12 | 5 |
| | Эрдэнэцагаан | 8 | 8 | 15 | 11 | 24 | 22 | 11 | 14 | 13 | 13 |
| | Дүн | 34 | 30 | 59 | 52 | 78 | 72 | 57 | 38 | 57 | 45 |
| Бүгд | | 247 | 226 | 666 | 562 | 571 | 519 | 513 | 459 | 535 | 478 |
| Нийт хүүхэд | | 473 | | 1228 | | 1090 | | 972 | | 1013 | |
| Эцэг эх | | 946 | | 2456 | | 2180 | | 1944 | | 2026 | |
| Эмэгтэй хувь | | 48 | | 46 | | 48 | | 47 | | 47.2 | |

## Б. Малчдын 5 настай хүүхдүүд СӨБ-д бүрэн хамрагдаж, сургуульд орж байна.

"Хүүхдийг сургуульд бэлтгэж оруулах нь амжилттай суралцах үндэс болдог. СӨБ-ын үйлчилгээнд хамрагдаж сургуульд орсон хүүхэд болон СӨБ-ын үйлчилгээнд хамрагдаагүй сургуульд орсон хүүхдийн хооронд хөгжлийн ялгаа үүсдэг."[16] НҮБ-ын Хүүхдийн Сангаас 2010 ба 2013 онд хийсэн Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаанд (ОҮБТС) хөдөө, орон нутгийн хүүхдүүд болон СӨБ-д огт хамрагдаагүй хүүхдүүдийг сумын төв/аймаг/нийслэлийн болон СӨБ-д хамрагдсан хүүхдүүдтэй харьцуулахад хөгжлийн хувьд хоцрогдох талтай байна. Ялангуяа бичиг үсгийн болон тоо тоолох ай нь хамгийн их ялгаатай байсан байна.

Төслөөс өмнө зарим аймагт малчин өрхийн 5 настай хүүхдүүдийн хагасаас илүү нь СӨБ-д хамрагдаж чадахгүй сургуульд ордог байсан (Өвөрхангай, ТОНЗ). Цэцэрлэгүүд малчин өрхийн хүүхдүүдийг зуны улиралд гэр цэцэрлэг

16 БСШУСЯ-ны илтгэл, Төслийн тайлангийн хэлэлцүүлэг, 2017/05/29, Улаанбаатар хот

болон бусад богино хугацааны хувилбарт сургалтаар хамруулдаг ч СӨБ-ын хамрагдалт дунджаар 42,1%-76,6,%-тай байсан. Дараах хүснэгтийг харна уу.

**Хүснэгт 11. СӨБ–ын хамрагдалтын хувь зорилтот 30 суманд, 2012–2013 (Суурь судалгааны тайлан)**

| Архангай аймаг | СӨБ-ын хамрагдалтын хувь | Өвөрхангай аймаг | СӨБ-ын хамрагдалтын хувь |
|---|---|---|---|
| Хашаат | 64 | Баян-Өндөр | 33 |
| Хотонт** | 50 | Баянгол | 38 |
| Хангай | 52 | Зүүнбаян-Улаан | 64 |
| Тариат** | 66 | Уянга** | 41 |
| Өндөр-Улаан ** | 62 | Тарагт ** | 39 |
| Цэцэрлэг | 57 | Богд | 42 |
| Жаргалант** | 48 | Хайрхандулаан | 46 |
| Өлзийт | 41 | Бүрд | 44 |
| Хайрхан | 56 | Есөнзүйл | 41 |
| Эрдэнэмандал | 55 | Сант | 33 |
| Дундаж % | 55,1 | Дундаж % | 42,1 |
| Дорнод аймаг | | Сүхбаатар аймаг | |
| Цагаан-овоо | 85 | Мөнххаан | 75 |
| Сэргэлэн | 76 | Уулбаян | 68 |
| Матад | 69 | Онгон | 72 |
| Чойбалсан | 74 | Баяндэлгэр | 55 |
| Халхгол** | 79 | Эрдэнэцагаан | 63 |
| Дундаж % | 76,6 | Дундаж % | 66,6 |

Сургуульд бэлтгэлгүй орсон хүүхэд бусад хүүхдээс сурлагаараа хоцрогдох, улмаар сургуульд дургүй болох зэрэг сөрөг талтай талаар эцэг эхчүүд тэмдэглэн хэлж байсан. Төсөл хэрэгжсэн ихэнх сумдад малчин өрхийн 5 настай хүүхдүүд 100% СӨБ-ыг эзэмшиж сургуульд орж байна.

”СӨБ-ын цөм хөтөлбөрийг бүрэн эзэмшээд сургуульдаа ордог болсноор анхаарлаа төвлөрүүлж чаддаг, үзэг харандаагаа барьж чаддаг, гарын хөдөлгөөн нь зүгширсэн байдаг.”

### B. Ном, тоглоомын багц нь хүүхдийг сонирхолтойгоор, бүтээлчээр суралцах чадварт суралцуулдаг.

Орон нутагт хүүхдэд сонирхолтой ном, тоглоом худалдан авах боломжгүй байдаг. Бага насны хүүхдэд тоглоом бол хамгийн чухал суралцах хэрэглэгдэхүүн болж байдаг. Ном, тоглоомын багцыг ашигласнаар хүүхдийн сурах сонирхол нэмэгдэж байсан. Мөн аав, ээждээ дараагийн багцаа солиход нь шахалт үзүүлж байсан.

*"Хүүхэд 14 хоноод л багцаа сольё гэдэг. Солихгүй бол уурлана. Тиймээс аав, ээж нь зайлшгүй сум явж солих хэрэгтэй болдог." (Сант сумын малчин)*

Түүнчлэн ном, тоглоомын багц дээрх гараа угааж, цэвэрч нямбай ашиглах тухай заавар нь хүүхдийг нүүр гараа угааж, цэвэрч байхад сургасан. Учир нь гэртээ байдаг бага насны хүүхэд өглөө босоод гар нүүрээ угааж хэвшээгүй байсан байна.





## Г. Хүүхэд, эцэг эхчүүд, багш нарт гарсан өөрчлөлт

ГБОСБХ-ийн үнэлгээний хэлэлцүүлэгт тус хөтөлбөрийн үр шимийг шууд хүртсэн 590 хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчид оролцсон. Хэлэлцүүлгээр тус хөтөлбөрийн үр дүн, үр өгөөжийг үнэлж, хүүхэд, эцэг эхчүүд, багш нарт гарсан өөрчлөлтийн талаар хэлэлцсэн юм.

**ГБОСБХ-ийн хүүхэд, эцэг эх, багш нарт гарсан үр өгөөжийг оролцогч талуудын 75% нь маш сайн гэж, 5 хүн тутмын 1 нь сайн гэж, 5,3% нь хангалттай хэрэгжсэн гэж, 0,8% нь сайжруулах шаардлага бий гэж үнэлсэн.**

**График 6. ГБОСБХ-ийн үр өгөөжтай байдал, 30 сумын оролцооны үнэлгээний нэгтгэл**



## Д. Хүүхдүүд СӨБ-ын 6 үндсэн чадварыг бүрэн эзэмшсэн.



Хүүхдүүдийн СӨБ-ын 6 үндсэн чадвар болох хэл яриа, байгаль/нийгмийн орчин, дуу хөгжим/дүрслэх урлаг, зан харилцаа, хөдөлгөөн эрүүл мэнд, матетатикийн төсөөлөл зэргийг хөгжүүлж чадсан. Дэлхийн Банкны СӨБ-ын чанарын судалгаагаар (2017) ХИС-ийн ГБОСБХ-т хамрагдсан хүүхдүүдийг гэр цэцэрлэгт хамрагдсан хүүхдүүдтэй харьцуулахад ГБОСБХ-д хамрагдсан хүүхдүүдийн бага насны хүүхдийн хөгжлийн 5 ай, үүнд танин мэдэхүй, хэл ярианы хөгжил, нийгэм-сэтгэлзүй, гүйцэтгэх чадвар, жижиг булчингийн хөгжил зэрэг нь гэр цэцэрлэгийн хүүхдийнхээс хол илүү байсныг судалгааны тайланд дурдаж баталгаажуулсан байна.

### Хүснэгт 12. Хүүхэд – ГБОСБХ-ийн өмнө ба дараа, 30 сумын хэлэлцүүлгээр хамгийн олон давтагдсан үр дүн

| № | Төсөл хэрэгжихээс өмнөх нөхцөл байдал ба бэрхшээл | Төсөл хэрэгжсэнээр гарсан үр дүн, өөрчлөлт |
|---|---|---|
| 1 | Бүрэг ичимхий, хүнтэй харьцах, ярих чадвар дутмаг, дуу цөөтэй, хүнээс айдаг. | Нүүрэмгий. Өөрийнхөө үзэл бодлыг чөлөөтэй илэрхийлдэг болсон. Өөрийгөө танилцуулдаг болсон. |
| 2 | Өнгө, дүрс ялгадаггүй | Өнгө дүрсээ ялгаж чаддаг. Дүрс эвлүүлдэг. |
| 3 | Тоо мэддэггүй. Сайн л бол 1-10 хүртэл тоолдог байсан. | Тоо тоолж, бодож сурсан. Буузаа тоолж идэх гэх мэтээр амьдрал дээр ашигладаг. |
| 4 | Гар нь зүгшрээгүй. Зураг зурах талаар юу ч мэддэггүй | Гарын ур дүй сайжирсан. Зураг зурах дуртай. |
| 5 | Эмх замбараагүй. Гар нүүрээ угаадаггүй. | Цэвэрч нямбай болсон. Багцан дээрх зөвлөгөөг дагаж тоглоомоо хураадаг, гараа угаадаг. |
| 6 | Шүлэг дуу юу ч мэдэхгүй байсан. | Үлгэрийн ном, зураг харж ярих дуртай, шүлэг, оньсого чээжилж хүмүүст ярьж, таалгадаг. |
| 7 | Сургуульд шууд бэлтгэлгүй ордог байсан.<br>Бусад хүүхэдтэй харилцаж чаддаггүй байсан. | Бусад хүүхэдтэй хамтарч тоглодог, тоглоомоо хуваалцдаг болсон. |
| 8 | Ганцаараа л өөрийгөө л аргалаад саатуулаад явдаг байсан. | Сэтгэн бодох чадвар эрс сайжирсан. |
| 9 | Хичээлийн хэрэгсэл байхгүй, харандаа цаас өгөхөөр сараачаад хаячихдаг. | Хичээлийн хэрэгсэл хэрхэн ашиглахаа мэддэг. Өөрийн хичээл хийдэг булантай болсон. |

Малчин өрхийн 5 настай хүүхдүүд хөтөлбөрт хамрагдахаасаа өмнө "бүрэг ичимхий, хүнтэй харьцах, ярих чадвар дутмаг, цөөн үгээр ярьдаг, хүнээс бишүүрхдэг, уйлдаг" байсан бол хөтөлбөрт хамрагдсанаар хэл ярианы хөгжил сайжирч "нүүрэмгий, өөрийнхөө үзэл бодлыг чөлөөтэй илэрхийлдэг, өөрийгөө танилцуулдаг, бүтэн өгүүлбэрээр ярьдаг, чээжилсэн шүлэг, оньсогоо хүн орж ирэхэд таалгадаг, чээжилсэн шүлгээ уншиж өгдөг, үлгэр ярьдаг болсон". Шүлэг дуу олныг сурч, үлгэрийн ном, зураг харж ярих дуртай болсон гэж үнэлгээнд оролцсон эцэг эхчүүд санал нэгтэйгээр тэмдэглэсэн.

Хүүхдүүд "өнгө дүрсээ ялгаж чаддаг, дүрс эвлүүлдэг болсон", "гар нь зүгшрээгүй байсан бол гарын ур дүй нь сайжирсан", "зураг зурах дуртай болсон", "сонссон үлгэрээ зургаар илэрхийлдэг болсон", "тоо тоолж, бодож чаддаг. Буузаа тоолж идэх гэх мэтээр амьдрал дээр ашигладаг", "сэтгэн бодох чадвар эрс сайжирсан" гэсэн үр дүнгүүдийг эцэг эхчүүд тэмдэглэсэн.

**Зураг 2. Хүүхдийн гарын дүйг бүтээлээр нь харьцуулсан харьцуулалт, өмнө ба дараа**



Сум бүр хүүхдэд гарсан ахиц дэвшлийг баримтжуулсан. Жишээ нь, Архангай аймгийн Өлзийт суманд ГБОСБХ-т хамрагдсан хүүхдүүдийн "гарааны үнэлгээний дундаж 39%-тай байсан. Барианы үнэлгээний дундаж 92%-тай болж, 53%-иар өссөн. Хүүхдүүдийн хэл ярианы чадвар сайжирсан, багш нартайгаа чөлөөтэй харилцан ярилцаж, өөрийгөө илэрхийлэх чадвар сайжирсан. Номтой харьцаж сурсан. 1-10 хүртэлх цифрээ нүдэлж, 100 хүртэл тоолж сурсан, хийсвэрээр бодлого бодож, эрүүл ахуйн энгийн чадвар дадал эзэмшсэн. 3-7 дуу, 5-10 шүлэг мэддэг болсон. 4 улирлын ялгаа, хөгжмийн зэмсэг ялгаж сурсан" гэжээ.

Төсөл хэрэгжихээс өмнө эцэг эхчүүд хүүхдэдээ сургуульд орохоос нь өмнө

хичээлийн хэрэгсэл авч өгдөггүй байсан. Иймээс хүүхдүүд хичээлийн хэрэгсэл хэрхэн ашиглахаа мэддэггүй. “Хичээлийн хэрэгсэл байхгүй, харандаа, цаас өгөхөөр сараачаад хаячихдаг байсан” бол хичээлийн хэрэгсэл ашиглаж чаддаг болсноор сургуульд орох нэг бэлтгэл болсон. Түүнчлэн ном, тоглоомын багц дээрх санамж нь хүүхдийг номоо үзэхийн өмнө гараа угаах, хичээлийн хэрэгсэлтэйгээ ариг гамтай харьцах зэрэгт сургасан.

**Зураг 3. Дорнод аймгийн Сэргэлэн сумын Хэлэлцүүлэг 1.**

Шүлэг: Хүүхдэд гарсан үр дүн (Баруун талд), Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын Хэлэлцүүлэг 1. Зураг: Төслөөс өмнө манай хүүхэд (Зүүн талд)



Үүний үр дүнд сургуульд бэлтгэгдэн ороод суралцах чадвар сайтай, хурдан уншиж, бичиж сурч байна.

> *“1-р ангийн хүүхдүүд 2014-2015 онд 22 үг, 2015-2016 онд 39 үг, 2016-2017 онд 44 үг уншиж байсан” (Архангай аймгийн Өлзийт сумын Зорилт 1-ийн хэлэлцүүлэг)*

## Е. Эцэг эхчүүд хүүхдээ сургуульд бэлтгэх аргазүй, ур чадвар эзэмшсэн.

Хүүхдийн хөгжилд эцэг эхийн оролцоо хэдий чинээ их байх тусам хүүхэд илүүтэй хөгжиж байдаг. Судалгаагаар эцэг эх нь хүүхдүүдтэйгээ хамт ном уншдаг, хүүхдэдээ үлгэр ярьж өгдөг бол тухайн хүүхдийн үгийн баялаг илүү сайн, ойлгох чадвар сайн, ном унших сонирхолтой болдог ба том болоод ч ном уншигч болдог байна (Дуурсмаа ба бусад, 2008[17]). Дэлхийн Банкны (2017) СӨБ-ын чанарын судалгаагаар ГБОСБХ-т хамрагдсан хүүхдүүдийн ээжүүд Гэр цэцэрлэгт хамрагдсан хүүхдүүдийн ээж нартай харьцуулахад сүүлийн 3 өдөр гэртээ хүүхэдтэйгээ ажилласан байдал, хүүхдийнхээ хөгжлийг дэмжих нь илүү байсан байна. Тухайлбал, ХИС-ийн ГБОСБХ-т хамрагдсан хүүхдүүдийн ээжүүд хүүхэдтэйгээ хамт эд юмсыг нэрлэсэн/тоолсон/зурсан, хамт тоглосон,

17 Дэлхийн Банк. Монгол улсын сургуулийн өмнөх боловсрол: Үйлчилгээний хүртээмж, чанар, хүүхдийн хөгжлийн үр дүн. 2016 оны 11 сар

гадуур хамтдаа цагийг өнгөрөөсөн, дуу дуулсан, үлгэр ярьсан, ном үзсэн/уншсан зэрэг нь гэр цэцэрлэгт хамрагдсан хүүхдийн ээжтэй харьцуулахад бараг 3 дахин илүү байсан байна.

ГБОСБХ-ийг хэрэгжүүлсэн нь "бага насны хүүхдийн хөгжилд анхаарах нь чухал болохыг эцэг эхэд мэдрүүлсэн. Ингэснээр эцэг эхчүүд бага насны хүүхэдтэй ажиллах аргазүйд суралцаж, ном унших сонирхолтой болж, өөрсдөө давхар суралцах (бичиг үсгийн боловсролын түвшин ахих) зэрэг үр дүн гарсан."[18]

Малчин эцэг эхчүүд "Та өөрөө багш" гарын авлагын дагуу сургалтад хамрагдаж хүүхдээ сургуульд бэлтгэх аргазүйг эзэмшсэн. "Эцэг эхчүүд хүүхдэдээ дүрс, тоо хэрхэн заахыг мэддэггүй байсан. Сайн л бол 1-ээс 10-ын тоог тоолуулж, дарааллаар нь чээжлүүлдэг байснаас биш эд юмстай холбож, нэмж хасахыг зааж мэддэггүй байсан. Эцэг эхчүүдэд зориулсан хөтөлбөр, гарын авлага байхгүй байсан учраас хүүхдээ хэрхэн сургах, хэрхэн урамшуулах, хэрхэн сонирхлыг нь татах, хэрхэн тоглуулахаа мэддэггүй байсан" гэж эцэг эхчүүд хэлсэн байна.

Хүүхдээ урмын үгээр тэтгэдэг болсон. Мөн хүүхдээр сонголт хийлгэж сурсан. Эхлээд энийгээ хийх үү, тэрийгээ хийх үү?, ямар өнгөөр будах вэ? гэх мэтээр өөрөөр нь сонголт хийлгүүлж сурсан байна. Хүүхэдтэйгээ хамтран зураг зурж, ярилцдаг, тоглодог болсон. Үлгэр ярьж өгдөг болсон. Хүүхдээ сонсдог болсон гэсэн үр дүнгүүдийг дурдсан.

СӨБ-ын цөм хөтөлбөрт эцэг эхчүүдийн үүргийг тодорхойлохдоо:

- Хүүхдээ анхааралтай сонсож, ярилцах;
- Хүүхдийнхээ асуултад ач холбогдол өгч, хариулт өгөх, хамтран хариулт олох;
- Хүүхдэдээ асуулт тавих, ярилцах;
- Хүүхдэдээ үлгэр, өгүүллэг уншиж өгөх, ярилцах;
- Хүүхдэд өгсөн амлалтаа биелүүлэх;
- Хүүхдийнхээ зурсан зураг, бүтээлүүдийг үзэж сонирхох, саналаа хэлж, урам өгөх;
- Хүүхдийн бүтээлийн "хавтас"-ыг нь баяжуулах;
- Хүүхэд бодол санаа, мэдрэмжээ зурах, урлаж бүтээх, тоглох үйлээр илэрхийлэхийг урамшуулж дэмжих;
- Хүүхэд дуулах, шүлэг унших, бүжиглэх, жүжиглэхэд нь талархах, зоригжуулах;
- Үзэж харсан, оролцсон үйл явдлынх нь тухай хүүхэдтэйгээ ярилцах гэж тодорхойлсон байдаг.

18 БСШУСЯ-ны илтгэл, Төслийн тайлангийн хэлэлцүүлэг, 2017/05/29, Улаанбаатар

Тэгвэл эцэг эхчүүд эдгээр үүргийг ойлгож, ашиглаж, биелүүлж сурсан нь эцэг эхчүүдтэй хийсэн ярилцлагаас харагдаж байсан. "Эцэг эхчүүд хүүхдийнхээ анхны багш нь болж урам авч байна."

> *"Удаан сууж чадахгүй дороо уйддаг. 15-20 минут л яг идэвхтэй суудаг. Тиймээс өөрийнх нь сонирхолтой юмыг эхлээд хийлгэдэг. Яг өөрийнх нь хийе гэсэн үед нь л хийлгэх хэрэгтэй. ... Хүүхдэд зүгээр уншиж өгөхөөр сонирхдоггүй. Тиймээс дуугаа өөрчилж (дүрд тоглож) уншиж өгдөг" (Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын эцэг эхчүүдийн зөвлөмж).*

### Ё. Эцэг эхчүүдийн хандлага маш ихээр өөрчлөгдөж, хүүхдэдээ цаг зарцуулдаг, орчин бэлдэж өгдөг болсон.

Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр эцэг эчхүүдийн хүүхдийн боловсролд хандах хандлагад маш их ахиц гарсан. Төслөөс өмнө эцэг эхчүүд малаа л чухал гэж боддог байсан учраас хүүхдэдээ цаг гаргадаггүй байсан. Хүүхдэд багш л юм заах сургах ёстой гэж үздэг байсан. Харин та өөрөө багш гарын авлагыг ашигласныхаа дараа эцэг эхчүүд хүүхдэдээ цаг гаргадаг болсон, хүүхдийнхээ суралцах явц, хүсэл сонирхлыг тогтмол анхаардаг болсон гэж эцэг эхчүүдийн хэлэлцүүлэгт тэмдэглэж байсан.

> *"Өмнө нь багш л хүүхдэд хичээл заах ёстой гэсэн сэтгэлгээтэй байсан."*

Эцэг эхчүүдийн хүүхдийн хөгжлийн талаар мэдлэг ойлголт дээшилж, хүүхдээ суралцах, хөгжих орчин нөхцөлөөр хангадаг болсон. Өмнө нь хүүхдэдээ тоглоом наадгай авч өгдөггүй байсан. Авч өгвөл буу, машин зэрэг л авч өгдөг. Сэтгэхүй хөгжүүлэх тоглоомын талаар огт мэддэггүй байсан. Мөн сургуульд ороогүй хүүхдэд зориулж бичгийн хэрэгсэл, ном, дэвтэр авч өгдөггүй байсан. Хүүхдэд зураг зурах ширээ, сандал, орчин бэлдэж өгдөггүй байсан. Төслийн үр дүнд сэтгэхүй хөгжүүлэх тоглоомын ач холбогдлын талаар мэдэж авсан.

Өмнө нь сургуульд ороогүй хүүхдэд зураг зурах ширээ, сандал, орчин бэлдэж өгдөггүй байсан. Харин төслийн үр дүнд бараг бүх малчин өрх хүүхдэдээ хичээлийн хэрэгсэл, хичээл хийх булан, шинээр бэлдэж өгсөн. Энэ нь төслийн үндсэн зорилго биш байсан ч эцэг эхчүүд өөрсдөө энэ ямар чухал болохыг ойлгож авснаар өөрсдөө сайн дурааараа гэртээ хичээл хийх булан бэлдэж өгсөн. Хичээлийн хэрэгсэл авч өгдөг болсноор хүүхэд хичээлийн хэрэгсэлтэй харьцаж сурсан.

> *"Өмнө нь дэвтэр, харандаа өгөхөөр сараачаад хаячихдаг байсан."*

## Хүснэгт 13. Эцэг эхчүүд– ГБОСБХ–ийн өмнө ба дараа, хэлэлцүүлгийн нэгтгэл

| № | Төсөл хэрэгжихээс өмнөх нөхцөл байдал ба бэрхшээл | Төсөл хэрэгжсэнээр гарсан үр дүн, өөрчлөлт |
|---|---|---|
| 1 | Эцэг эхчүүдэд зориулсан хөтөлбөр, гарын авлага байхгүй байсан. | “Та өөрөө багш” номтой болсноор хүүхдээ яаж сургах арга барил олж авсан. |
| 2 | Эцэг эхчүүд “малаа л чухал гэж боддог” байснаас хүүхдэдээ цаг гаргадаггүй байсан. | Хүүхдэдээ цаг гаргадаг, хичээлийг тогтмол хийлгэж сурсан. |
| 3 | Эцэг эхчүүд хүүхдэдээ дүрс, тоо хэрхэн заахыг мэддэггүй байсан. Сайн л бол 1-ээс 10-ын тоог тоолуулдаг байсан. Тоглоом, наадгай, бусад бодит юмстай холбож ойлгуулж мэддэггүй байсан. | Хүүхэдтэйгээ хамтран зураг зурж, ярилцдаг, тоглодог болсон. Үлгэр ярьж өгдөг болсон. Эцэг эхчүүд хүүхдийнхээ анхны багш нь болж урам авч байна. |
| 4 | Хүүхдэдээ тоглоом, наадгай авч өгдөггүй байсан. Авч өгвөл буу, машин зэрэг л авч өгдөг. Сэтгэхүй хөгжүүлэх тоглоомын талаар огт мэддэггүй байсан. | Сэтгэхүй хөгжүүлэх тоглоомын талаар мэдэж авсан. Хүүхэдтэйгээ ойр дотно болсон. Урмын үгээр тэтгэдэг болсон. |
| 5 | Сургуульд ороогүй хүүхдэд зориулж бичгийн хэрэгсэл, ном дэвтэр авч өгдөггүй байсан. Сургуульд орохоор нь л авч өгдөг. | Хичээлийн хэрэгсэл авч өгдөг. Бүтээлийн хавтастай болсон. |
| 6 | Хүүхдэд зураг зурах ширээ, сандал, орчин бэлдэж өгдөггүй байсан. | Хүүхдэдээ хичээл хийх орчин бэлдэж өгсөн. Бүтээлийг нь ил харагдахуйц газар өлгөснөөр орж ирсэн хүн бүр харж хүүхдэд урам дэм өгдөг болсон. |
| 7 | “Миний номын өргөө” болон хүүхдийн сэтгэхүйг хөгжүүлэх ном, тоглоом байхгүй байсан. | “Миний номын өргөө”-нд тогтмол ирж багцаа сольдог болсон. Аав нарын оролцоо сайжирсан. Цаг агаар муу үед аав нь хүүхдийнхээ сурсан шүлгийг утсан дээрээ бичиж, багшид нь шалгуулдаг. |

Бүтээлийн хавтастай болсон. Хүүхдэдээ хичээл хийх орчин бэлдэж өгөхдөө ширээнийх нь ард “бүтээлийг нь ил харагдахуйц газар өлгөснөөр орж ирсэн хүн бүр харж хүүхдэд урам дэм өгдөг болсон.”

**Зураг 4. Хүүхдийн бүтээлийн булан (Архангай аймгийн Хотонт сум)**



Дэлхийн Банкны СӨБ-ын чанарын судалгаагаар (2017) ХИС-гийн ГБОСБХ-т хамрагдсан хүүхдүүдийг гэр цэцэрлэгт хамрагдсан хүүхдүүдтэй харьцуулахад өрхийн нийгэм эдийн засгийн үзүүлэлтүүд, тухайлбал ээж аавын боловсролын түвшин, өрхийн тэргүүн ажилгүй зэрэг үзүүлэлтүүд доогуур байсан боловч хүүхдийн хөгжлийг дэмжихэд таатай орчин бүрдүүлэх тал дээр гэр цэцэрлэгийн хүүхдүүдийн гэр бүлээс хол илүү байсан байна. ХИС-гийн хөтөлбөрт хамрагдсан хүүхдүүд өөрсдийн гэртээ хийсэн тоглоом, гэр ахуйн зүйлсээр тоглох нь илүү байсан.[19]

Эдгээрийн үр дүнд  эцэг эхчүүд хүүхэдтэйгээ ойр дотно болсон гэж үнэлсэн байна.  Мөн эцэг эхчүүдийн сургуульд хандах харилцаа хандлага өөрчлөгдсөн, сургуульд орсон хойно нь багштайгаа ойр харилцаатай болсон.

### Ж. Аав нарын оролцоо эрс дээшилсэн

Хүүхдийн сургууль, цэцэрлэгийн эцэг эхийн хуралд оролцох, багштай нь уулзах зэрэг ажлыг ээж, эмээ нарт ихэвчлэн даатгадаг байсан бол “Миний номын өргөө”-нд тогтмол ирж багцаа сольж, багшид нь шалгуулж, зөвлөгөө авдаг болсноор аав нарын оролцоо эрс сайжирсан дам үр дүн гарсан байна. Цаг агаар муу үед аав нь хүүхдийнхээ сурсан шүлгийг утсан дээрээ бичиж, багшид нь шалгуулж, даалгаврыг нь тайлбарлуулж аваад явдаг. (Өвөрхангай аймгийн Тарагт сум) Гэртээ очоод ээжид нь тайлбарлаж өгдөг. Зарим ном, тоглоомын багцыг аав нь эхэлж үзээд хүүхдэдээ тайлбарлаж өгөх зэргээр аав нарын үүрэг, оролцоо сонирхол дээшилсэн байна.

19 Дэлхийн Банк. СӨБ-ийн чанарын судалгаа. 2015

**Зураг 5. Хэлэлцүүлгийн оролцогчид аав нарын оролцоог илэрхийлсэн байдал, Архангай аймгийн Өлзийт, Хашаат сум**



### 3. Багш нарын ур чадвар, сургууль, цэцэрлэгийн залгамж холбоо сайжирсан.

Төслийн сумдад эцэг эхэд зөвлөн туслах үүрэг бүхий чиглүүлэгч багшийг бэлдсэн. Суманд дор хаяж 5 чиглүүлэгч багшийг бэлдсэн ба эдгээр багш нар бусад багш нарт сургалт явуулж хамтран ажилласан. Ихэнх сумд хүүхдийн сургуульд ороход дөхөм байлгах, шинэ орчинд дасан зохицох үйл явцыг дэмжих зорилгоор 5-р ангийн багш нарыг чиглүүлэгч багшаар бэлдсэн. Ингэснээр хүүхдүүд дараа жил сургуульд ороход нь тухайн багш үргэлжлүүлэн авч, сургуульд нь хичээл заах юм.

Ийм хамтын ажиллагааны үр дүнд сургууль цэцэрлэгийн хамтын ажиллагаа, залгамж холбоо сайжирч, хүүхэд сургуульд ороод шинэ орчинд дасан зохицоход нь дэмжлэг болсон.

## 2.2.2 Хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөрийн үр дүн, биелэлт

Төслийн бичиг баримтад дунд хугацааны үнэлгээний дараа оруулсан өөрчлөлтөөр ХБЦНХ-ийн чиглэлээр дараах үр дүнг гаргахаар заасан.

### Хүснэгт 14. ХБЦНХ–ийн чиглэлээр гарах үр дүнгийн үзүүлэлтүүд

| Өөрчлөлт | Зорилтын шалгуур үзүүлэлтүүд | Суурь үзүүлэлт | Эцсийн үзүүлэлт | Хэрэгжилт |
|---|---|---|---|---|
| Шинээр нэмсэн | ХБЦНХ-д хамрагдаж сурлагын амжилтаа ахиулсан зорилтот бүлгийн хүүхдүүдийн тоо | 0 | 4120 | 6124 |
| Хассан | Сургууль, дотуур байрын орчинд дасж чадахгүй, хичээлийн хоцрогдлоос шалтгаалан 1-3 дугаар ангидаа сургууль завсардаж буй хүүхдийн тоог бууруулах. | 0 | 25% | |
| Хассан | ХБЦНХ-ийн зорилтот бүлгийн хүүхдүүдэд гарч байгаа сэтгэл санааны өөрчлөлт, ахицыг багш, эцэг эх болон хүүхдүүдээс санал асуулга авах, зан байдлын ажиглалт хийх зэрэг хүүхдэд ээлтэй үнэлгээний аргуудыг ашиглан тодорхойлно. | | 25% | |
| Статус | Дунд хугацааны үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд | Суурь үзүүлэлт | Эцсийн үзүүлэлт | Хэрэгжилт |
| Хэвээрээ | Зорилтот сумдын сургуулиуд хүүхдүүдийн хэрэгцээнд нийцсэн ХБЦНХ-ийг хэрэгжүүлсэн байна. | 30 | 30 | 30 |

## А. ХБНЦХ–т нийт 6,124 хүүхэд хамрагдаж шууд үр шимийг нь хүртсэн

Хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөрт төслийн 30 суманд 5 жилийн хугацаанд нийт 6,124 хүүхэд хамрагдсан байна. Төслийн сүүлийн жил 30 зорилтот суманд 3,500 орчим хүүхдийг хамруулсан.

### Хүснэгт 15. ХБЦНХ–т хамрагдсан хүүхдийн тоо, ХИС

| Аймаг | Сумд | Жил II (2013-2014) | | | Жил III (2014-2015) | | | Жил IV (2015-2016) | | | Жил V (2016-2017) | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | эм | эр | бүгд | эм | эр | бүгд | эм | эр | бүгд | эм | эр | бүгд |
| Архангай | Жаргалант | 47 | 68 | 115 | 55 | 61 | 116 | 67 | 77 | 144 | 54 | 62 | 116 |
| | Өлзийт | 45 | 46 | 91 | 39 | 44 | 83 | 69 | 60 | 129 | 69 | 63 | 132 |
| | Өндөр-Улаан | 61 | 50 | 111 | 80 | 71 | 151 | 62 | 81 | 143 | 84 | 99 | 183 |
| | Тариат | 9 | 12 | 21 | 25 | 22 | 47 | 43 | 38 | 81 | 64 | 53 | 117 |
| | Хайрхан | 56 | 14 | 70 | 46 | 49 | 95 | 88 | 81 | 169 | 78 | 69 | 147 |
| | Хангай | 35 | 30 | 65 | 47 | 39 | 86 | 48 | 38 | 86 | 66 | 52 | 118 |
| | Хашаат | 32 | 31 | 63 | 31 | 36 | 67 | 79 | 64 | 143 | 74 | 60 | 134 |
| | Хотонт | 60 | 64 | 124 | 69 | 50 | 119 | 83 | 87 | 170 | 93 | 102 | 195 |
| | Цэцэрлэг | 62 | 63 | 125 | 83 | 81 | 164 | 89 | 95 | 184 | 101 | 86 | 187 |
| | Эрдэнэмандал | 37 | 45 | 82 | 239 | 200 | 439 | 160 | 104 | 264 | 157 | 116 | 273 |
| | Дүн | 444 | 423 | 867 | 714 | 653 | 1367 | 788 | 725 | 1513 | 840 | 762 | 1602 |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Өвөрхангай | Баянгол | 47 | 45 | 92 | 37 | 34 | 71 | 45 | 62 | 107 | 46 | 41 | 87 |
| | Баян-Өндөр | 82 | 73 | 155 | 77 | 83 | 160 | 95 | 93 | 188 | 91 | 75 | 166 |
| | Богд | 83 | 76 | 159 | 58 | 88 | 146 | 70 | 59 | 129 | 85 | 75 | 160 |
| | Бүрд | 36 | 46 | 82 | 34 | 35 | 69 | 41 | 34 | 75 | 49 | 45 | 94 |
| | Есөнзүйл | 33 | 52 | 85 | 34 | 56 | 90 | 42 | 38 | 80 | 52 | 52 | 104 |
| | Зүүнбаян-Улаан | 10 | 17 | 27 | 13 | 18 | 31 | 45 | 44 | 89 | 40 | 40 | 80 |
| | Сант | 65 | 66 | 131 | 74 | 62 | 136 | 77 | 66 | 143 | 76 | 60 | 136 |
| | Тарагт | 17 | 15 | 32 | 21 | 15 | 36 | 20 | 16 | 36 | 22 | 21 | 43 |
| | Туяа баг | | | | | | | 24 | 19 | 43 | 22 | 19 | 41 |
| | Уянга | 54 | 76 | 130 | 102 | 114 | 216 | 159 | 112 | 271 | 144 | 121 | 265 |
| | Хайрхандулаан | 38 | 33 | 71 | 16 | 14 | 30 | 39 | 33 | 72 | 46 | 33 | 79 |
| | Дүн | 465 | 499 | 964 | 466 | 519 | 985 | 657 | 576 | 1233 | 673 | 582 | 1255 |
| Дорнод | Матад | 13 | 7 | 20 | 15 | 9 | 24 | 28 | 13 | 41 | 30 | 12 | 42 |
| | Сэргэлэн | 11 | 15 | 26 | 10 | 12 | 22 | 20 | 17 | 37 | 17 | 16 | 33 |
| | Халхгол | 18 | 21 | 39 | 8 | 17 | 25 | 19 | 16 | 35 | 36 | 20 | 56 |
| | Ялалт баг | | | | | | | | | | | | |
| | Цагаан-Овоо | 28 | 18 | 46 | 22 | 13 | 35 | 38 | 23 | 61 | 24 | 30 | 54 |
| | Чойбалсан | 22 | 27 | 49 | 22 | 15 | 37 | 39 | 20 | 59 | 37 | 18 | 55 |
| | Дүн | 92 | 88 | 180 | 77 | 66 | 143 | 144 | 89 | 233 | 144 | 96 | 240 |
| Сүхбаатар | Баяндэлгэр | 36 | 21 | 57 | 55 | 39 | 94 | 72 | 69 | 141 | 47 | 42 | 89 |
| | Мөнххаан | 40 | 44 | 84 | 37 | 49 | 86 | 65 | 51 | 116 | 46 | 62 | 108 |
| | Онгон | 21 | 19 | 40 | 37 | 31 | 68 | 44 | 49 | 93 | 45 | 40 | 85 |
| | Уулбаян | 18 | 18 | 36 | 19 | 23 | 42 | 31 | 26 | 57 | 26 | 27 | 53 |
| | Эрдэнэцагаан | 69 | 58 | 127 | 47 | 45 | 92 | 70 | 79 | 149 | 88 | 98 | 186 |
| | Дүн | 184 | 160 | 344 | 195 | 187 | 382 | 282 | 274 | 556 | 252 | 269 | 521 |
| | Бүгд | 1185 | 1170 | | 1452 | 1425 | | 1871 | 1664 | | 1909 | 1709 | |
| Нийт хүүхэд | | | | 2355 | | | 2877 | | | 3535 | | | 3618 |
| Эмэгтэй хувь | | 49.7 | | | 49.5 | | | 47.1 | | | 47.2 | | |

## Б. ХБЦНХ хэрэгжүүлэн дотуур байрын Хүүхэд хөгжлийн танхим байгуулснаар хүүхэд сургуульдаа болон дотуур байрандаа дуртай болсон.

ХБЦНХ-ийг дотуур байранд байгуулсан "Хүүхэд хөгжлийн танхим"-аар дамжуулан дотуур байрын болон айлд амьдардаг 1-5-р ангийн хүүхдүүдийн дунд хэрэгжүүлснээр хүүхэд гэрээ санахаа больж, дотуур байрандаа дуртай, сургуульдаа дуртай болсон.

Айлд байгаа хүүхдүүд зурагт үздэг, эсвэл гадаа тоглох нь их, эсвэл дэлгүүр хэсдэг, айл хэсдэг, байн байн гэртээ харихаар явдаг байсан бол хүүхэд дотуур байр болон сургуульдаа дуртай болсон. Олон найз нөхөдтэй болсон. Бусадтай хамтарч ажиллах чадвартай болсон. "Бяцхан ОНБЗ" хүүхдийн оролцооны байгууллагын гишүүн болж бусад хүүхдүүдтэйгээ хамтран олон төрлийн үйл ажиллагаанд оролцдог болсон.

Түүнчлэн төслөөс зарласан олон нийтийн санаачилгыг дэмжих тэтгэлэгт төслийн хүрээнд нэмэлт ур чадвар эзэмшүүлэх дугуйлан секцэд хамрагдаж, хайчилбар, наамал хийх, шатар даам сурах, уран унших, илтгэл бичих зэрэг ур чадвар, авьяасаа хөгжүүлсэн. Дуу, шүлэг, хөгжим, бүжиг сурсан. Бүтээлч сэтгэлгээтэй, дүрслэн бодох чадвартай болсон. Сургуулиас зохиох ажилд идэвхтэй оролцдог.

*“Амралтын өдрүүдээр гэртээ харьчихаад Хүүхэд хөгжлийн танхимд сургалттай гээд заавал Даваа гарагт буцаж ирдэг болсон. Дотуур байр руугаа яардаг болсон”*

*Дотуур байр сайхан шүү*

*Дотно дулаан санагддаг шүү...*

*(Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын Хэлэлцүүлэг 2. Хүүхдэд гарсан үр дүн)*

### B. Хүүхдийн сурлагын ахиц сайжирч, хоцрогдол арилснаар сургуулиас завсардах эрсдэл буурсан.

ХБЦНХ-ийн үр дүнд, хүүхдүүд Хүүхэд хөгжлийн танхимдаа даалгавраа хийх дуртай болсноор бие даах чадвар нь дээшилж, хичээлдээ сонирхолтой болсноор хичээлийн ахиц сайжирсан.

Төслийн сумд Монгол хэл, Математикийн хичээлээр гарааны болон барианы үнэлгээг хийдэг болсноор сум бүр өөрсдийн бага ангийн хүүхдүүдийн ахицыг үнэлж сурсан.

**Хүснэгт 16. 2012/2013 ба 2016/2017 оны шалгалтын дүнгийн өсөлтийн хувь**

| Судлагдахуун | 2012/2013 оны хичээлийн жилийн сурлагын амжилтыг 2015/2016 хичээлийн жилийн сурлагын амжилттай харьцуулсан байдал | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| бүлэг | 1-р анги | 2-р анги | 3-р анги | 4-р анги | 5-р анги | Дундаж |
| Монгол хэлний хичээл | +9,28% | +9,75% | +9,03% | +13,99% | +8,31% | +10,07% |
| Математикийн хичээл | +6,60% | +10,40% | +7,70% | +11,38% | +11,73% | +9,56% |

*“2012 оныхоос шалгалтын хувь 2016 онд монгол хэл-4.2%, Математик-8.7% ахисан. (Дорнод аймгийн Халхгол сум ОНБЗ)*

Чөлөөт цагаа өнгөрүүлэх танхимтай болж, даалгавраа хийж, тэмцээн уралдаанд амжилт гаргадаг болсноор хичээлийн ахиц сайжирч, хичээлийн хоцрогдол арилсан.

“Айлд байгаа болохоор хэсэж сэлгүүцэж чөлөөт цагаа өнгөрөөх газаргүй байсан” (Архангай аймгийн Хайрхан сум). Гэртээ байлгаж байгаа айл ч бас өөр айлын хүүхэдтэй ажиллахдаа муу, хэнээс асуухаа мэддэггүй байсан тухайгаа илэрхийлсэн юм.

*“Айлын хүүхэд хэцүү шүү*
*Аяыг нь олоход бэрх шүү*
*Ардын багш аргатай шүү*
*Арга эв нь олдсон шүү”*
*(Архангай аймгийн Хайрхан сумын айлд амьдардаг хүүхдүүдийн асран хамгаалагчдын төлөөлөл)*

Эцэг эхчүүд нь хүүхдээ дотуур байр болон айлд байхдаа хичээлээ муу давтдаг, сурлага нь муудах болов уу гэж санаа зовдог ч юу ч хийж чаддаггүй байсан.

Мөн төслийн зорилтот сумдад хүүхдийн оролцооны бүлгүүд “Бяцхан ОНБЗ” шинээр байгуулагдсанаар хүүхдүүдийн оролцоо, идэвх санаачилга, хамт олны уур амьсгалд эерэгээр нөлөөлсөн.

### Г. Дотуур байранд амьдардаг бага ангийн хүүхдийн тоо нэмэгдсэн

Төслийн бүх зорилтот суманд дотуур байрын хүүхдийн тоо болон дотуур байранд байрлах бага ангийн хүүхдийн тоо нэмэгдсэн.

Дорнод аймгийн Халхгол сумын ЕБС 350 хүүхэдтэй, үүнээс бага ангид 188 хүүхэд суралцдаг. Мөн алслагдсан Ялалт багийн сургуульд 69 хүүхэд сурдгаас 46 нь бага ангид суралцдаг.

ХБЦХН хэрэгжсэн 4 жилийн хугацаанд энэ хөтөлбөрт нийт 221 хүүхэд хамрагдсанаас дотуур байранд - 92, айлд- 129 сурагч амьдарч байсан. Сумын төвийн дотуур байранд анх 2012 онд бага ангийн 5 хүүхэд, харин 6 настай нэг ч хүүхэд байхгүй байсан бол 2016-2017 оны хичээлийн жилд дотуур байранд 6 настай 5 хүүхэд, бага ангийн 19 хүүхэд амьдарч байна.

“Аймгийн зорилтот 10 сумын нийт 1-5-р ангийн хүүхдүүдийн 39,6%-нь манай төслийн үр шимийг хүртэж байна.” (Өвөрхангай, ТОНЗ)

Зарим сумдад 5 настай хүүхдүүдийг багцаа солих гээд ирэхэд нь дотуур байр болон Хүүхэд хөгжлийн танхимтай танилцуулж, өдөржин байлгаж дасгадаг нь хүүхдийн дотуур байранд байх сонирхлыг төрүүлж өгдөг байна (Дорнод аймгийн Халхгол сум). Үүний үр дүнд дотуур байранд амьдардаг бага ангийн хүүхдийн тоо нэмэгдэж, эцэг эх нь сэтгэл амар малаа маллах боломжтой болсон.

### Зураг 6. Сухбаатар аймгийн Мөнххаан сумын Хэлэлцүүлэг 2-ын Зураг: Хүүхэд төслийн дараа




Ингэснээр малчин эцэг эх нь хүүхдэдээ санаа зовохгүй байх, гэр бүл тусгаарлагдахгүй байх давуу тал бий болсон. Мөн сумын түвшинд малчин өрхийн тоог бууруулахгүй байх, мал маллах сонирхолтой залуу өрхийг дэмжих, сумын төв дээр ажилгүй иргэдийн тоог бууруулах зэрэг орон нутгийн бодлоготой нийцэж байгаа юм.

### Д. Эцэг эхийн оролцоо, багштай хамтарч ажиллах нь нэмэгдсэн.

ХБЦНХ-ийн үнэлгээний хэлэлцүүлэгт тус хөтөлбөрийн үр шимийг шууд хүртсэн 745 хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчид оролцсон. Хэлэлцүүлгээр тус хөтөлбөрийн үр дүн, үр өгөөжийг үнэлж, хүүхэд, эцэг эхчүүд, багш нарт гарсан өөрчлөлтийн талаар хэлэлцсэн юм.

**ХБЦНХ-ийг эцэг эх, асран хамгаалагчид ерөнхийд нь 64% нь маш сайн гэж, 26% нь сайн гэж, 9,2% нь хангалттай хэрэгжсэн гэж, 1% нь сайжруулах шаардлага бий гэж үнэлсэн.**

### График 7. ХБЦНХ-ийн үр өгөөжтэй байдлын 30 сумын үнэлгээний нэгтгэл



Эцэг эхчүүд багш, сургууль л хүүхдэд эрдэм ном заах ёстой гэж боддог байсан. Хүүхэд юм сурахгүй бол багшийг буруутгадаг, дуудуулж байж сургууль дээр хааяа ирдэг байсан бол сургуулийн үйл ажиллагаа, бага ангийн багшийн ажлын ачааллыг ойлгодог, үнэлдэг болсон. Хүүхдийнхээ авьяасаа нээх, хөгжих тал дээр нь дэмжиж, багш нартай нь хамтран ажилладаг болсон.




Эцэг эхчүүд Хүүхдийн хөгжлийн дэвтэр ашиглан хүүхдийнхээ хөгжил, чадварт гарч буй ахицыг хянадаг болсон (Өвөрхангай ТОНЗ).

Эцэг эхчүүдийн сайн дурын оролцоо нэмэгдэж байна. Жишээ нь, хүүхдийнхээ дүрийн тоглолтын хувцсыг гарын доорх материалаар хийж өгөх, хуруун хүүхэлдэй хийх, ном авч өгөх зэргээр оролцоо нь нэмэгдсэн байна.

## Е. Хүүхдийн сэтгэлзүйн таатай байдлын судалгааг авч ашигладаг болсон

Төсөл хэрэгжүүлэх явцад дотуур байранд болон айлд амьдардаг хүүхдүүдээс хичээлийн жилийн эхэнд болон төгсгөлд “Хүүхдийн сэтгэлзүйн таатай байдлын судалгаа”-г авч байсан.

Төслийн хүрээнд 2015-2016 онд 447 хүүхдээс сэтгэл зүйн таатай байдлын судалгааг 3 дахь жилдээ авсан ба судалгаанд оролцсон хүүхдүүдийн 33% дотуур байранд, 64% хамаатныдаа, 3% таньдаг айлдаа амьдардаг хүүхдүүд байсан. Тус судалгааг 2015-2016 оны хичээлийн жилийн эхэнд болон сүүлд хийж харьцуулсан байна. Судалгаагаар сурагчдын 93,5% нь “дотуур байр, амьдарч буй айл таалагддаг” гэж, 99,2% нь “сургуульдаа дуртай” гэж хариулжээ. Харин хичээлийн жилийн эхэнд сурагчдын 10% нь “Гэртээ байгаа юм шиг дураараа байж чаддаггүй” гэсэн бол хичээлийн жилийн эцэст 24% нь болж өссөн байна.

**Хүснэгт 17. Хүүхдийн нийгэм сэтгэлзүйн байдлын судалгааны үр дүнгээс, 2015–2016, ХИС**

| А-1. Амьдарч байгаа дотуур байр, амьдарч байгаа айл чинь таалагддаг уу? | | А-2. Хамт амьдарч байгаа хүмүүстэйгээ гэртээ байгаа шигээ өөрийн дураар байж чаддаг уу? | | А-3. Сургуульд сурах дуртай юу? 1-2 дугаар ангийн сурагчдын хариулт | | А-4. Багш болон том хүмүүсээс асуух зүйл байвал айхгүй асууж чаддаг уу? | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Тийм | Үгүй | Үгүй / хичээлийн жилийн эхэнд/ | Үгүй / хичээлийн жилийн эцэст/ | Тийм | Үгүй | Үгүй / хичээлийн жилийн эхэнд/ | Үгүй / хичээлийн жилийн эцэст/ |
| 93.5 % | 6.5% | 10% | 24% | 99.2 % | 0.8 % | 39% | 40% |

*“2015-2016 оны хичээлийн жилд 1,065 хүүхдээс авсан судалгаанаас*

*харахад 1-2-р ангийн хүүхдүүдийн сэтгэлзүйн таатай байдал 3,6 %, 3-5-р ангийн хүүхдүүд 4,3% сэтгэлзүйн таатай байдал сайжирч дотуур байрандаа дасан зохицсон үр дүн харагдаж байна" (Өвөрхангай ТОНЗ)*

Дээрх судалгаагаар "өөрийгөө хөгжүүлэх чадвар" 68%-аас 87,5% болж, "шинэ зүйл сурах хүсэл эрмэлзэл" 87.5%-аас 90.4% болж, "бие биедээ туслах" хандлага 95,5%-аас 97% болж бага зэрэг дээшилсэн бол "ангийн найз нөхөдтэйгээ харилцах харилцаа" хичээлийн жилийн эхэнтэй харьцуулахад хичээлийн жилийн төгсгөлд буурсан байв. Энэхүү судалгааны асуулга нь зөвхөн Тийм, Үгүй гэсэн хоёр сонголттой, учир шалтгааныг асуусан болон хариултыг давхар шалгасан асуулга байхгүй байсны улмаас дээрх бууралтын шалтгааныг нь тайлбарлах боломжгүй байв. Цаашид энэхүү аргачлалыг хүүхдийн сэтгэлзүйн байдлыг илүү нарийвчлан тодорхойлж, ашиглахад хялбар байдлаар сайжруулах шаардлагатай.

**Хүснэгт 18. Хүүхдийн нийгэм сэтгэлзүйн байдлын судалгааны үр дүнгээс, 2015–2016, ХИС**

| Ангийн хүүхдүүд, найз нөхөдтэйгээ харилцах харилцаа, хандлага | | Бие биедээ туслах, дэмжих хандлага | | Аливаа бэрхшээлийг даван туулах чадвар, өөрийн сонирхсон зүйлээ хийх, өөрийгөө хөгжүүлэх чадвар | | Шинэ зүйл сурах хүсэл эрмэлзэл | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Хичээлийн жилийн эхэнд | Хичээлийн жилийн төгсгөлд | Хичээлийн жилийн эхэнд | Хичээлийн жилийн төгсгөлд | Хичээлийн жилийн эхэнд | Хичээлийн жилийн төгсгөлд | Хичээлийн жилийн эхэнд | Хичээлийн жилийн төгсгөлд |
| 95 % | 88 % | 95,5 % | 97 % | 45,4 % | 68 % | 87,5 % | 90,4 % |

## Ё. Дотуур байрын үйл ажиллагааг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулсан.

Дотуур байрын үйл ажиллагааны стандарт байхгүйгээс дотуур байрын багш нар өмнө нь ямар ч үйл ажиллагаа зохион байгуулдаггүй байсан ба дотуур байрын багшийн нэр хүнд доогуур байсан.

ХБЦНХ-ийг хэрэгжүүлэх явцад дотуур байрын өдөр тутмын үйл ажиллагаа идэвхжиж, дотуур байрын багш нар хийх ажилтай, урамтай болсон. Хүүхэд хөгжлийн танхимын дүрэм тогтоож, танхимын уриатай болсон. Мөн дотуур байрын сайн туршлагыг түгээх, туршлага солилцох уулзалтыг байнга хийдэг болсон нь төсөл хэрэгжээгүй бусад суманд туршлага, аргазүйг түгээхэд хувь нэмрээ оруулсан (Өвөрхангай, ТОНЗ).

Дотуур байрын үйл ажиллагааны хүрээнд хүүхдийн оролцооны байгууллагыг идэвхжүүлснээр ахлах ангийн хүүхдүүд нь бага ангийнхандаа туслах, эсвэл дотуур байранд анх орж буй нэгнээ дэмжин туслах, хүүхдүүд хамтран авьяас

сонирхлоо хөгжүүлэх боломжийг бий болгосон.

*Төслийн зорилтот 10 сумын хэмжээнд хүүхдийн оролцооны 10 бүлэг 2015 онд шинээр байгуулагдсан (Бяцхан ОНБЗ).*

## Ж. Заах аргазүйн нэгдлийн багш нарын заах аргазүйг хөгжүүлсэн

Бүтээлч сэтгэлгээний 108 арга бүхий хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад багш нарын заах аргазүй эрс сайжирсан гэсэн үр дүнг бараг бүх сумдад тэмдэглэсэн.

| | |
|---|---|
| Дуртай дургүйгээ мэддэггүй<br>Дугуйлан секц хичээлдэггүй байснаа<br>Нэг төрлийн дугуйланг<br>Нэлээн хэд болголоо | Багшийн харцнаас бултганаж<br>Бодож сэтгэхээ мартаж байснаа<br>Багшийн баяртай мишээлээс<br>Бодол санаа минь ундардаг болсон |
| Багшийн арга дутмагаас<br>Багачуудын идэвх суларсан байсан<br>Багшийн арга сайжирснаар<br>Баялаг эрдэмд умбалаа | Хөхрөн униартах хөдөөд минь<br>Хүүхдийг Ивээх Сан ирснээр<br>Хөдөөгийн багш бидний<br>Хүсэл мөрөөдөл биелсэн. |
| | *Дорнод аймгийн Чойбалсан сумын хэлэлцүүлэг* |

ХБНЦХ-ийн бүтээлч сэтгэлгээний аргуудыг 1-5-р ангийн хичээлүүдийн бүлэг сэдэвтэй уялдуулан гарын авлага зөвлөмж гаргасан (Өвөрхангай, Уянга).

*"Бүтээлч сэтгэлгээний аргуудыг хэрэгжүүлснээр багшийн хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх заах аргазүйд ахиц гарсан. Хүүхэд хөгжүүлэх бүтээлч сэтгэлгээний 108 аргаа багш нарт бүрэн дүүрэн эзэмшүүлэхийг зорьж сургалтаа 40 гаруй багшид 5 удаа 8 өдөр зохион байгууллаа" (Дорнод аймгийн Халхгол сум)*

## 2.2.3 Бага боловсрол нөхөн олгох Хөтөлбөрийн үр дүн биелэлт

ББНОХ бүрэлдэхүүний дагуу төслийн хүрээнд дараах шалгуур үзүүлэлтүүдийг ашигласан.

**Хүснэгт 19. ББНОХ-ийн шалгуур үзүүлэлтүүдийн өөрчлөлт ба биелэлт**

| Өөрчлөлт | Зорилтын шалгуур үзүүлэлтүүд | Суурь үзүүлэлт | Эцсийн үзүүлэлт | Хэрэгжилт |
|---|---|---|---|---|
| Шинээр | ББНОХ-д хамрагдаж ур чадвараа сайжруулсан зорилтот бүлгийн хүүхдүүдийн тоо | 0 | 86 | 206 |
| Хассан | Бага боловсрол нөхөн олгох хөтөлбөрт хамрагдсан зорилтот бүлгийн хүүхдүүдэд гарсан өөрчлөлт болон ахицыг тодорхойлох | | 15% | |
| Хассан | 6-10 насны сургууль завсардсан хүүхдүүдээс сургуульдаа эргэн орсон хүүхдийн тоо нэмэгдсэн байх | | 15% | |

| Өөрчлөлт Статус | Дунд хугацааны үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд | Суурь үзүүлэлт | Эцсийн үзүүлэлт | Хэрэгжилт |
|---|---|---|---|---|
| Хэвээрээ | Бага боловсрол нөхөн олгоход чиглэсэн Математик, Монгол хэлний хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ. | 6 | 6 | Биелсэн |

## A. ББНОХ-т 206 хүүхэд хамрагдсанаас 62 хүүхэд ЕБС, Дүйцсэн хөтөлбөрт шилжсэн.

Бага боловсрол нөхөн олгох хөтөлбөрөөр сургуульд огт ороогүй эсвэл сургуулиасаа завсардсан хөгжлийн бэрхшээлтэй эсвэл сургууль хол, сурлагаар хоцорсон зэрэг олон шалтгаанаар завсардсан байсан 206 гаруй хүүхэд хичээллэж тэдгээрээс 62 нь ЕБС-ийн зохих ангид эсвэл тусгай сургуульд болон дүйцсэн хөтөлбөрт шилжин суралцаж байна.

Төслийн эхний жилүүдэд сургуульд явах бүрэн боломжтой мөртлөө гэр бүлийнхээ мал аж ахуйд тусалдаг эсвэл хичээлийн хоцрогдолтой, сургуульд дургүй зэрэг шалтгаанаар завсардсан хүүхдүүдийг илрүүлэн ЕБС-ийн холбогдох ангид шилжүүлж байсан бол төслийн сүүлийн жилд голчлон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг илрүүлэн, боловсролд хамруулж байна. Дараах хүснэгтийг харна уу.

### Хүснэгт 20. ББНОХ-оос ЕБС ба Дүйцсэн хөтөлбөрт шилжсэн хүүхдүүдийн мэдээлэл, 2014-2017, ХИС

| № | Аймаг | Сумын нэр | Хүйс | Нас | Хөтөлбөрөөр хичээллэсэн хугацаа | Аль модуль үзсэн | Сургуульдаа эргэн орсон он сар | Хэддүгээр анги орсон |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2014-2015 оны хичээлийн жил | | | | | | | |
| 1 | Архангай | Хашаат | эр | 8 | 2 жил | 1.2 | 1/9/2014 | 2а |
| 2 | | | эр | 9 | 2жил | 1 | 1/9/2014 | 1б |
| 3 | | Өндөр-Улаан | эр | 8 | 5 сар | 1 | 1/9/2014 | 1б |
| 4 | | Жаргалант | эр | 8 | 3 сар | 1 | 1/9/2014 | 1 |
| 5 | Сүхбаатар | Уулбаян | эм | 10 | 8 сар | 2 | 1/9/2014 | 2Б |
| 6 | | Эрдэнэ-цагаан | эр | 11 | 8 сар | 2,3 | 1/9/2014 | 5Б |
| 7 | | Онгон сум | эм | 14 | 3 сар | 3 | 1/9/2014 | 3А |
| 8 | | Баяндэлгэр сум | эр | 8 | 3 сар | 1 | 1/9/2014 | 1 |
| | 2015-2016 оны хичээлийн жил | | | | | | | |
| 1 | Архангай | Хайрхан | эр | 14 | 8 сар | 1.1-3.3 | 9/1/2015 | 5 |
| 2 | | Жаргалант | эр | 7 | 6 сар | 1 | 9/1/2015 | 1 |
| 3 | | | эр | 7 | 4 сар | 1 | 9/1/2015 | 1 |
| 4 | | Хашаат | эр | 11 | 1 жил 4 сар | 1.1-3.3 | 9/1/2015 | 5 |
| 5 | | | эр | 7 | 8 сар | 1 | 9/1/2015 | 1 |
| 6 | | | эр | 7 | 8 сар | 1 | 9/1/2015 | 1 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | | Өндөр-Улаан | эр | 7 | 3 сар | 1 | 9/1/2015 | 1 |
| 8 | | | эр | 11 | 3 сар | 1 | 9/1/2014 | 5 |
| 9 | | Эрдэнэ-мандал | эр | 8 | 3 сар | 2 | 9/1/2015 | 3 |
| 10 | | | эм | 12 | 1 жил | 3 | 9/1/2015 | 4 |
| 11 | Өвөрхангай | Баянгол | эр | 7 | 10 сар | 1.1-1.2 | 9/1/2015 | 1 |
| 12 | | | эр | 7 | 10 сар | 1.1-1.2 | 9/1/2015 | 1 |
| 13 | | | эр | 7 | 10 сар | 1.1-11.2 | 9/1/2015 | 1 |
| 14 | | Баян-Өндөр | эр | 7 | 6 сар | 1.1 | 9/1/2015 | 1 |
| 15 | | Богд | эм | 10 | 6 сар | 3.1-3.3 | 9/1/2015 | 4 |
| 16 | | | эр | 8 | 6 сар | 2.1-2.3 | 9/1/2015 | 2 |
| 17 | | Есөнзүйл | эр | 7 | 6 сар | 1.1 | 9/1/2015 | 1 |
| 18 | | | эр | 7 | 6 сар | 1.1 | 9/1/2014 | 1 |
| 19 | | Зүүнбаян-Улаан | эр | 12 | 6 сар | 1.2 | 9/1/2015 | 5 |
| 20 | | Тарагт | эр | 7 | 11 сар | 1.1 | 9/1/2015 | 1 |
| 21 | | | эр | 7 | 4 сар | 1.1-1.3 | 9/1/2015 | 1 |
| 22 | | Уянга | эр | 11 | 10 сар | 2 бүрэн | 9/1/2015 | 3 |
| 23 | | | эр | 11 | 10 сар | 3 бүрэн | 9/1/2014 | 2 |
| 24 | | | эр | 9 | 10 сар | 1 бүрэн | 9/1/2015 | 1 |
| 25 | | | эм | 7 | 10 сар | 1 бүрэн | 9/1/2015 | 1 |
| 26 | | Хайрхан дулаан | эм | 7 | 6 сар | 1 бүрэн | 9/1/2015 | 1 |
| 27 | | | эр | 7 | 6 сар | 1 бүрэн | 9/1/2015 | 1 |
| 28 | | | эр | 7 | 6 сар | 1 бүрэн | 9/1/2014 | 1 |
| 29 | | | эм | 7 | 6 сар | 1 бүрэн | 9/1/2015 | 1 |
| 30 | | | эр | 7 | 6 сар | 1 бүрэн | 9/1/2015 | 1 |
| 31 | Сухбаатар | Эрдэнэ-цагаан | эм | 11 | 3 сар | модуль 3-1, 2, 3 | 9/1/2015 | 4 |
| 32 | | Уулбаян | эр | 10 | 1 жил | модуль 2 | 9/1/2015 | 2 |
| 33 | | | эм | | 1 жил | | 9/1/2015 | 3 |
| | 2016-2017 оны хичээлийн жил | | | | | | | |
| 1 | Архангай | Жаргалант | эр | 7 | 1 жил | | 9/1/2016 | 1 |
| 2 | | Цэцэрлэг | эр | 8 | 1 жил | | 9/1/2016 | 1 |
| 3 | | | эр | 13 | 2.8 жил | | 3/1/2017 | Дүйцсэн хөт-т |
| 4 | | Өндөр-Улаан | эр | 12 | 2 жил | | 9/1/2016 | |
| 5 | | Тариат | эр | 11 | 1.5 жил | | 9/1/2016 | |
| 6 | | | эр | 16 | 1 жил | | 9/1/2016 | |
| 7 | | | эр | 16 | 1 жил | | 9/1/2016 | |
| 8 | | | эр | 14 | 1 жил | | 9/1/2016 | |
| 9 | | | эр | 16 | 2 жил | | 9/1/2016 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 10 | Архангай | Хангай | эр | 15 | 1.5 жил | | 9/1/2016 | Дүйцсэн хөт-т |
| 11 | | | эр | 16 | 1.5 жил | | 9/1/2016 | |
| 12 | | | эр | 16 | 1.4 жил | | 9/1/2016 | |
| 13 | | Хотонт | эр | 10 | 2 жил | | 9/1/2016 | |
| 14 | | | эр | 14 | 1.6 жил | | 9/1/2016 | |
| 15 | | | эр | 11 | 1 жил | | 9/1/2016 | |
| 16 | | | эр | 11 | 1 жил | | 9/1/2016 | |
| 17 | | Эрдэнэ-мандал | эр | 13 | 1.3 жил | | 9/1/2016 | |
| 18 | | | эр | 16 | 1.5 жил | | 9/1/2016 | |
| 19 | | | эр | 14 | 1.5 жил | | 9/1/2016 | |
| 20 | | | эм | 14 | 1.6 жил | | 9/1/2016 | |
| 21 | Өвөрхангай | Уянга | эм | 7 | | модуль 1.1-1.3 | 2017/03сар | 2 |

### Б. Зорилтот сумдад сургууль завсардалтыг эрс бууруулсан.

ЕБС-д суралцаагүй 6-14 насны хүүхдүүдийн тоо, шалтгааныг 2012-2013 онтой харьцуулахад 2016-2017 оны хичээлийн жилд улсын хэмжээнд энэ тоо эрс буурсан байна. Мөн зорилтот аймгуудад амьдралын гачигдлаас эсвэл сурах дургүйгээс гэсэн шалтгаанаар сургууль завсардах явдал байхгүй болсноос гадна сургуульд огт ороогүй, эсвэл ороод завсардсан хүүхдийн тоо эрс буурсан байна. Дараах хүснэгтийг харна уу.

**Хүснэгт 21. ЕБС-д суралцаггүй 6-14 насны хүүхдүүд, шалтгаанаар, 2012-2013 ба 2016-2017, БСШУСЯ**

| Аймаг | бүгд | эм | Амьдралын гачигдлаас | Сурах дургүйгээс | Ажил эрхлэхээр | Өвчний улмаас | Шалтгаан тодорхойгүй | Сургуульд огт ороогүй | Ороод завсардсан |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2016-2017 | | | | | | | | | |
| Үндэсний | 445 | 150 | 65 | 24 | - | 193 | 163 | 341 | 104 |
| Архангай | 42 | 11 | 5 | 5 | - | 24 | 8 | 26 | 16 |
| Өвөрхангай | 36 | 15 | 3 | 4 | - | 11 | 18 | 25 | 11 |
| Дорнод | 1 | 1 | | | 1 | | | 1 | |
| Сүхбаатар | 9 | 1 | | | 9 | | | 8 | 1 |

| 2012-2013 | бүгд | эм | Амьдралын гачигдлаас | Сурах дургүйгээс | Ажил эрхлэхээр | Өвчний улмаас | Шалтгаан тодорхойгүй | Сургуульд огт ороогүй | Ороод завсардсан |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Үндэсний | 2332 | 937 | 836 | 180 | 70 | 815 | 431 | 1,267 | 1,065 |
| Архангай | 147 | 60 | 42 | 18 | 6 | 65 | 16 | 59 | 88 |
| Өвөрхангай | 248 | 79 | 118 | 29 | 0 | 68 | 33 | 105 | 143 |
| Дорнод | 47 | 17 | 24 | 2 | 5 | 11 | 5 | 30 | 17 |
| Сүхбаатар | 100 | 28 | 22 | 1 | 2 | 66 | 9 | 49 | 51 |

Сургууль завсардсан хүүхдүүдийг судалж, илрүүлэн, сургуульд хамруулахад багийн засаг дарга нар сургуультай хамтарч ажилласнаар зорилтот сумдад сургууль завсардалтыг эрс бууруулсан.

> *"Аймгийн хэмжээнд сургууль завсардалтын түвшин 10-12 хувиар буурч, төсөлд хамрагдсан 10 сумын хэмжээнд 6-10 насны хүүхдийн сургууль завсардалтыг эрс бууруулж чадлаа." (Өвөрхангай, ТОНЗ)*

### В. ББНОХ–өөр хичээллэсэн хүүхэд, эцэг эх, багш нарт гарсан үр дүн

ББНОХ-ийн үнэлгээний хэлэлцүүлэгч оролцогч 845 оролцогч талуудын төлөөлөл ББНОХ-ийн үр дүнг үнэлэхдээ 70% нь маш сайн гэж, 21,6% нь сайн гэж, 7,7% нь хангалттай хэрэгжсэн гэж, 0,4% нь сайжруулах шаардлага бий гэж үнэлсэн.

**График 8. ББНОХ–ийн үр дүнгийн үнэлгээ, 30 сумын үнэлгээний нэгтгэл**




### Г. ББНОХ нь хүүхдийн уншиж, бичих чадварыг нэмэгдүүлж, сургуульд дуртай болгосон.

Бага боловсролоос завсардсан хүүхдүүд уншиж, бичиж чадахгүй, хичээлээсээ хоцорсны улмаас сургуульд явах дургүй болсон байдаг. Сургууль завсардсан шалтгаан нь аймаг, сум бүрээр ялгаатай байна. Зарим суманд сургууль завсардсан хүүхэд байхгүй байв.

*“Өвөрхангай аймагт сүүлийн 3 жилийн хугацаанд нийт сургууль завсардсан 69 хүүхэд энэ хөтөлбөрт хамрагдсанаас 29 нь сургуульдаа эргэн орж, 40 нь дүйцсэн хөтөлбөрөөр суралцаж байна.” (Өвөрхөнгай, ТОНЗ)*

ББНОХ-т хамрагдсанаар сургууль завсардсан хүүхдүүд нийгэмшиж, хэл ярианы хөгжилд нь ахиц гарсан. Унших, бичих чадвар эзэмшсэн. Мөн авьяасаа хөгжүүлсэн. Хүүхэд сургуульд дуртай болж, эцэг эхчүүд хүүхдийнхээ боловсролд анхаардаг болсон нь хөтөлбөрийн чухал үр дүн байлаа.

*“Сургууль завсардсан уяач хүүхдүүд*
*Хөдөлмөр эрхэлдэг болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд*
*Бичиг үсэггүй эцэг эх, иргэд олон нийтэд*
*Бага боловсрол нөхөн олгохын төлөө*
*Багаараа хамтран хувь нэмрээ оруулсан” (Дорнод, Сүхбаатар аймаг)*

### Д. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн илрүүлэлт, эцэг эхийн боловсролд хандах хандлага өөрчлөгдсөн.

Хөдөөгийн малчдын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд сургуульд явах, бичиг үсэг сурах боломжоор хязгаарлагдмал байсан. Ихэнх нь “байнга гэртээ байдаг учраас сургууль багшийн талаар ойлголтгүй байдаг”. ББНОХ-ийг боловсруулж, сургалтын орчин, хэрэглэгдэхүүнийг бэлдэж, НТБ-ын багш нарыг бага ангийн Монгол хэл, Математикийн сургалт явуулах чиглэлээр бэлтгэснээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн илрүүлэлт, оношилгоо нэмэгдсэн.

*“Эмчийн үзлэг, эрүүл мэндийн мэдээлэл дутмаг байсан.” (Архангай аймаг Хашаат сум)*

Төслийн сумдад Олон нийтийн боловсролын зөвлөлийн үйл ажиллагааны үр дүнд (ОБНЗ) БЗД нарын оролцоо нэмэгдсэн нь илрүүлэлт нэмэгдэхэд нөлөөлсөн. Мөн орон нутгийн засаг захиргаа болон эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажилладаг болсон нь ХБХ-ийн боловсролын хамрагдалтад эерэгээр нөлөөлсөн.

Хүүхдүүд боловсролд хамрагдсанаар тэдний оюун ухаан, авьяас чадвар, өөртөө үйлчлэх ур чадвар эрс хөгжсөн. Түүнчлэн хүүхдийнхээ төлөө эцэг эхчүүд багш нартай болон сургуультай хамтарч ажилладаг болсон. Орон нутгийн бусад байгууллагууд сургууль завсардсан хүүхдийг илрүүлэх, сургуульд хамруулахын төлөө хамтарч ажилладаг болсон байна.

Төслийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг илрүүлж, боловсролд хамруулах болсноор эцэг эх нь урам зоригтой болж, хүүхдээ сургахын төлөө мэрийдэг болсон.

“Хотод харааны бэрхшээлтэй хүүхдийн тусгай сургуульд шилжин сурсан” (Сүхбаатар, ...)

### E. Насан туршийн боловсролын танхимыг тохижуулж, багш нарыг чадваржуулсан

Насан туршийн боловсролын болон бага ангийн багш нарын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хандах хандлага, ойлголт өөрчлөгдөж, тэдэнтэй ажиллах ур чадвар дээшилсэн. Насан туршийн боловсролын төв нь 9-49 насны бичиг үсэггүй иргэдэд бичиг үсгийн мэдлэг олгох хөтөлбөр хэрэгжүүлдэг. Харин 6-8 насны хүүхэдтэй ажилладаггүй байсан.

ББНОХ-ын танхимыг шинээр бий болсон Насан туршийн боловсролын (НТБ) төв дээр байгуулсан нь эцэг эхийн бичиг үсгийн боловсрол, амьдрах ухааны болон бусад сургалтуудтай уялдуулах боломжийг олгосон.

Мөн НТБ-ын багш нарыг чадваржуулахад нөлөөлсөн. НТБ-ын багш нар их солигддог, ихэнх нь биеийн тамирын багш нар байдаг. Энэ хөтөлбөрийн үр дүнд эдгээр багш нарыг бага боловсрол эзэмшүүлэх багш болгож хувиргаж чадсан (Өвөрхангай, ТОНЗ).

## 2.3. ТӨСЛИЙН НӨӨЦИЙН АШИГЛАЛТ БУЮУ ТӨСВИЙН ҮР ДҮНТЭЙ БАЙДАЛ

### 2.3.1. Төслийн төсөв, санхүүжилт, зарцуулалтын үр дүнтэй байдал

### A. ГБОСБХ-ийн төсөв, санхүүжилтийн үр дүнтэй байдал

ГБОСБХ-ийн санхүүжилтийн үр дүнтэй байдал буюу үр ашигтай зарцуулсан, бага зардлаар олон хүнд хүрч чадсан эсэхийг оролцогч талууд үнэлэхдээ 81,8% нь маш сайн, 14,5% нь сайн, 3,8% нь хангалттай хэрэгжсэн гэж үнэлсэн нь бага зардлаар олон хүнд үр дүнгээ өгсөн загвар гэж эцэг эхчүүд үзэж байгааг харуулж байна.

**График 9. ГБОСБХ-ийн төсвийн үр дүнтэй байдал, 30 орчим үнэлгээний нэгтгэл**



Нийт Зорилт 1-ийн хэрэгжилтэд 731,731 ам.доллар төсөвлөгдсөн. Нийт 4 аймгийн 30 суманд 45 "Миний номын өргөө"-г тохижуулж, ном тоглоомын багцаар хангасан. Арван ширхэг ном, тоглоомын багцын нийт үнэ 1,2 сая төгрөг байдаг нь орон нутгийн төсөв, хандиваар ном, тоглоомын багцыг баяжуулах, шинээр Миний номын өргөө байгуулах  бүрэн боломжтой хувилбар юм.

### Б. Цэцэрлэгийн хүрэлцээ хангалтгүй байгаа одоогийн нөхцөлд ГБОСБХ нь төсөвт хэмнэлттэй хувилбарт сургалтын хэлбэр юм.

Төрөөс СӨБ-д зарцуулах төсөв жил бүр нэмэгдсээр байгаа ч жил бүр тодорхой тооны цэцэрлэгийн байрны ашиглалтын хугацаа дуусаж, мөн байгаа цэцэрлэг нь 2-5 насны хүн амын өсөлтийг гүйцэж чадахгүй байна. Түүнчлэн 2016 оноос эдийн засгийн нөхцөл байдал хүндэрсэн нь СӨБ-ын хамрагдалтыг нэмэгдүүлэхэд хүндрэлтэй байдал бий болгосон.

**Хүснэгт 22: Боловсролын болон СӨБ-ын төсөв (2012-2016 он, сая төгрөгөөр)**

| | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 |
|---|---|---|---|---|---|
| Боловсролын нийт төсөв | 868,107 | 1,730,651 | 1,917,435 | 1,751,449 | 2,023,644 |
| Улсын төсвөөс | 868,107 | 1,075,180 | 1,169,105 | 989,144 | 1,182,334 |
| Үүнээс СӨБ-д | 164,747 | 194,366 | 223,526 | 243,309 | 268,296 |
| Орон нутгийн төсвөөс | 0.0 | 655,470 | 748,330 | 762,305 | 841,310 |
| Үүнээс СӨБ-д | 0.0 | 194,221 | 223,380 | 243,313 | 268,300 |
| Боловсролын төсөвд СӨБ-ын эзлэх хувь | 18.9% | 22.0% | 23.0% | 27.7% | 26.5% |

*Эх сурвалж:  БСШУСЯ-ны Санхүү, Эдийн Засгийн Хэлтэс*

СӨБ-ын зарлагын бүтцийг авч үзвэл 2015 онд СӨБ-ын байгууллагуудын урсгал зардлын дийлэнх хэсгийн ажилтнуудын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл (65%), үүний дараа хоолны зардал (18%), дулаан цахилгаан ус (10%) эзэлж байна.[20] Харин ГБОСБХ-ийг хэрэгжүүлэхэд улсын төсвөөс нэмэлт хөрөнгө оруулалт, зардал гаргалгүйгээр хэрэгжүүлэх боломжтойгоос гадна хүүхдийн анхны багш болох эцэг эхчүүдийг чадваржуулж, гэр бүлийн орчинг хүүхдэд ээлтэй болгож байгаа юм.

Цэцэрлэгүүдийн анги дүүргэлт хүчин чадлаасаа хэтэрсэн байгаа, шинээр цэцэрлэг барих хөрөнгө санхүүжилт дутмаг байгаа одоогийн нөхцөлд төсвийн хувьд үр дүнтэй  хувилбарт сургалтын шинэ хэлбэрийг санал болгож байгаа нь малчдын хүүхдийг СӨБ-д бүрэн хамруулахад чухал үүрэг гүйцэтгэх юм.

20 Дэлхийн Банк. СӨБ-ийн чанарын судалгаа. 2015

**Хүснэгт 23. Цэцэрлэгийн бүлгийн тоо ба хамрагдаж буй хүүхдийн тоо, 2016–2017**

| Цэцэрлэгт хамрагдаж буй хүүхдийн тоо 2016-2017 | ясли | бага | дунд | ахлах | бэлтгэл | холимог |
|---|---|---|---|---|---|---|
| Хүүхдийн тоо (БСШУСЯ-ны 2016-2017 статистик) | 2,407 | 45,526 | 51,413 | 54,529 | 55,011 | 10,925 |
| Бүлгийн тоо (БСШУСЯ-ны 2016-2017 статистик) | 102 | 1,560 | 1,496 | 1,559 | 1,489 | 431 |
| Одоогийн анги дүүргэлт дундаж | 23.6 | 29.2 | 34.4 | 35.0 | 36.9 | 25.3 |
| Цэцэрлэгийн хүчин чадал* (2-3 настай бүлэг 1:20, 4-5 настай бүлэг 1:25) | 2,040 | 31,200 | 37,400 | 38,975 | 37,225 | 10,775 |
| Хүчин чадлаас хэтэрсэн хүүхдийн тоо (Хүүхдийн тоо – цэцэрлэгийн хүчин чадал) 62,196 | 367 | 14,326 | 14,013 | 15,554 | 17,786 | 150 |
| Нэмэлтээр шаардлагатай байгаа бүлгийн тоо 2,635 | 18 | 716 | 561 | 622 | 711 | 6 |

*Эх сурвалж: Үнэлээчийн тооцоолол*

Дээрх хүснэгтэд хийсэн тооцооллоос харахад одоогийн байгаа цэцэрлэгүүдэд нийт 62,200 орчим хүүхэд хүчин чадлаас хэтэрсэн нөхцөлд хамрагдаж байгааг харж болно. Зөвхөн эдгээр хүүхдүүдийг стандартын дагуу цэцэрлэгт хамруулъя гэвэл 2,635 нэмэлт бүлэг буюу дунджаар 5 бүлэгтэй 527 цэцэрлэг шинээр шаардлагатай байна. Эндээс харахад эцэг эхийн идэвхтэй оролцоотойгоор гэр бүлийн орчинд нь хүүхдийг сургуульд бэлтгэх хөтөлбөр нь төсөв санхүүжилтийн хувьд маш үр дүнтэй хувилбар болж байна.

## B. ХБЦНХ-ийн төсөв санхүүжилтийн үр дүнтэй байдал

Зорилт 2-ы үр дүнтэй байдлыг оролцогч талууд үнэлэхдээ 79,6% нь маш сайн, 15% нь сайн, 5,1% нь боломжийн, 0,3% нь сайжруулах шаардлагатай гэж үнэлсэн нь бага зардлаар олон хүүхдэд үр дүнгээ өгсөн арга гэдгийг харуулж байна.

### График 10. ХБЦНХ–ийн төсвийн үр дүнтэй байдал, 30 сумын үнэлгээний нэгтгэл




Зорилт 2-ын хэрэгжилтэд нийт 629,913 ам.доллар төсөвлөсөн. Үүнээс зөвлөх үйлчилгээнд 16,5 сая төгрөгийг, зорилтот 30 суманд Хүүхэд хөгжлийн танхим тохижуулахад сум бүрийн онцлог хэрэгцээнд тулгуурлан 1,8-аас 3,8 сая төгрөгийг зарцуулсан.

Сайн малчдын хандиваар шинээр Хүүхэд хөгжлийн танхим тохижуулсан (Дорнод), аймгийн зорилтот бус бусад сумд болон бусад аймагт хөтөлбөрийг түгээн дэлгэрүүлсэн зэрэг туршлагаас (Өвөрхангай) харахад ХБЦНХ-ийг ямар ч сургуулийн дотуур байранд хэрэгжүүлэх бүрэн боломжтой юм.

### Г. ББНОХ–ийн төсвийн үр дүнтэй байдал

**Зорилт 3–ын төсвийн үр дүнтэй байдлыг** оролцогч талууд үнэлэхдээ 75% нь маш сайн, 19,4% нь сайн, 5,6% нь боломжийн гэж үнэлсэн нь бага зардлаар олон хүүхдэд үр дүнгээ өгсөн арга гэж олон нийт үзэж байгааг харуулж байна.

### График 11. ББНОХ–ийн төсвийн үр дүнтэй байдал, 30 сумын үнэлгээний нэгтгэл



ББНОХ-ийн хэрэгжилтэд нийт 573,278 ам доллар төсөвлөсөн. Үүнээс зөвлөх үйлчилгээнд 23 сая төгрөг, 30 суманд Бага боловсрол нөхөн олгох танхим тохижуулахад нэг танхим байгуулахад ойролцоогоор 2 сая төгрөг зарцуулсан байна.

Насан туршийн боловсролын төвийг түшиглэн ББНОХ-ийг хэрэгжүүлэхэд багш нарын идэвх оролцоо, аймгийн БСУГ-ын газрын манлайлал л чухал шаардлагатай. Өөрөөр хэлбэл нэмэлт санхүүжилт шаардахгүйгээр хөтөлбөрийг орон нутагт үргэлжлүүлэн хэрэгжүүлэх бүрэн боломжтой.

## 2.4. ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Энэ хэсэгт төслийн хүрээнд туршсан шинэ санаачилга, бий болсон сайн туршлагууд, төсөл дууссаны дараа тогтвортой үргэлжлэх боломжийг үнэлсэн. "Тогтвортой байдал"-ыг үнэлэхдээ (1) төсөл дууссаны дараа орон нутагт үлдэх чадавх бий болсон эсэх (2) энэхүү сайн туршлагыг нутагшуулах боломжтой эсэх гэсэн хоёр шалгуураар үнэлсэн.

### 2.4.1. Зорилт 1-ийн хүрээнд туршсан шинэ санаачилга, сайн туршлагуудын тогтвортой байдал

Зорилт 1-ийн хүрээнд туршсан хүүхдийг эцэг эх нь гэр бүлийн орчинд сургуульд бэлтгэх хөтөлбөр, хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжихэд чиглэсэн Миний номын өргөө, Ном, тоглоомын багцыг эцэг эхчүүд "тогтвортой үлдэх чадавх бий болсон" болон "нутагшуулах боломжтой" эсэх үзүүлэлтээр үнэлэхдээ 62% ба 60% нь маш сайн, 24,5% ба 24,1% нь сайн, 13,7% нь хангалттай хэрэгжсэн гэж, 0% ба 1,4% нь сайжруулах шаардлагатай гэж тус тус үнэлсэн.

**График 12. ГБОСБХ-ийн 1. Тогтвортой чадавх бий болгосон, 2. Нутагшуулах боломж, 30 сумын үнэлгээний нэгтгэл**




### А. СӨБ-ын хүртээмж хангалтгүй байгаа хөдөөгийн малчдын хүүхдүүдийг сургуульд бэлтгэх хувилбарт сургалтын шинэлэг хэлбэр бий болсон

НҮБ-ын Хүүхдийн Сангийн Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаанд (2010) хөдөөгийн малчдын хүүхдүүдийн СӨБ-д хамрагдалт 40 орчим хувьтай

байгааг дурдсан. Аймгийн төв, сумын төвд энэ үзүүлэлт 80 хувьтай байгаа юм. Малчдын хүүхдүүдийг ихэвчлэн зуны улиралд зохион байгуулдаг нүүдлийн гэр цэцэрлэг эсвэл явуулын багш нарын тусламжтайгаар сургуульд бэлтгэж байна. Энэ нь Монгол орны нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг малчдын соёл, зан заншил, нийгэм, эдийн засгийн нөхцөлд нийцүүлсэн СӨБ-ын хувилбар юм. Гэсэн хэдий ч гэр цэцэрлэг нь багийн төвд ойрхон байгаа айлуудыг л хамардаг. Мөн л өглөө хүргэж өгч, орой очиж авах шаардлагатай болдгоос хүүхэд бүр тэгш хамрагдах боломжгүй байдаг.

Сумдын хэлэлцүүлгээр ОБНЗ-ийн олон нийтэд тайлагнасан илтгэлээс харахад төсөл дууссаны дараа бэлтгэгдсэн чиглүүлэгч багш, эцэг эхчүүд, орон нутгийн бусад оролцогч талууд хамтран ГБОСБХ-ийг цаашид үргэлжлүүлэх, түгээн дэлгэрүүлэх бүрэн боломжтой гэж үзэж байсан. Үнэлгээнд оролцогчид "5 настай хүүхэд бүрийг СӨБ-д хамруулах хувилбарт сургалтын нэг хэлбэрээр ашиглах  боломжтой" гэж үзэж байсан.

Орон нутгийн түвшинд "Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусган орон нутгийн дэмжлэгтэйгээр ном, тоглоомын багцаа шинэчлэх, шинээр Миний номын өргөө байгуулах боломжтой" гэж үзсэн. Мөн гэр цэцэрлэгтэй зун хамтарч ажиллан, хөтөлбөр багцуудаа хэрэглүүлэх боломжтой гэж үзсэн.

Мөн Архангай, Дорнод аймаг нь багш бэлтгэх сургуультай учраас төсөл дууссаны дараа зэргэлдээ аймгуудад төслийн үр дүнг түгээн дэлгэрүүлэх стратегийн зорилготой сонгосон. Иймээс эдгээр аймгийн Багшийн сургуулийг түшиглэн хөтөлбөрийг багш бэлтгэх сургалтын хөтөлбөрт тусгах, түгээн дэлгэрүүлэх боломжтой.

### Б. ГБОСБХ нь эцэг эхчүүдийн оролцоотойгоор хүүхдийг гэр бүлийн орчинд нь дэмжлэг үзүүлдэг нь хүүхдийн хөгжил, цаашдын боловсролд эерэгээр нөлөөлж байна

Төсөл хэрэгжихээс өмнө эцэг эхчүүд гэр бүлийнхээ орчинд  хүүхдээ сургуульд бэлтгэх талаар ойлголтгүй, багш нар л юм зааж сургах ёстой гэж үздэг байсан бол ГБОСБХ хэрэгжсэнээр эцэг эхийн мэдлэг, ур чадвар нэмэгдэж, хүүхдийнхээ боловсролд анхаарах болсон. Энэ нь хүүхдийн цаашдын суралцах үйл явцад болон гэр бүлийн хүмүүжил, харилцаанд эерэгээр нөлөөлж байна. Дэлхийн Банкнаас хийсэн СӨБ-ын чанарын судалгаагаар (2015) ГБОСБХ-т хамрагдсан хүүхэд, эцэг эхчүүдийг гэр цэцэрлэгт хамрагдсан хүүхдүүд, тэдний эцэг эхчүүдтэй харьцуулахад эцэг эхийн боловсролын түвшин,  өрхийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал нь нэн эмзэг, доогуур байсан ч бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих, дэмжих орчин бүрдүүлэх тал дээр болон хүүхдийн хөгжлийн ахиц бүх таван ай (танин мэдэхүй, хэл яриа, нийгэм-сэтгэлзүй, гүйцэтгэх чадвар, жижиг булчин) тус бүрээр эрс илүү байсан нь бага насны

хүүхдийн хөгжилд маш үр дүнтэй шинэлэг хувилбар болохыг харуулж байна. БСШУСЯ-наас ч мөн "хувилбарт сургалтын төсвийн хувьд үр ашигтай шинэлэг хэлбэр болгож" хуульчлах талаар судалгааны ажлууд эхлүүлээд байгаа юм.

БСШУСЯ-наас зохих судалгааг хийж, боловсролын бодлогод тусгасны дараа энэ аргыг аймаг, хот суурин газруудад ч ашиглах бүрэн боломжтой. Учир нь ГБОСБХ-т хамрагдсан өрхүүд нь сумаас алслагдсан, эцэг эхийн боловсролын түвшин доогуур, зарим нь бичиг үсэг мэддэггүй, эдийн засгийн хувьд эмзэг өрхүүд байсан ч хүүхдүүдээ гэр бүлийн орчинд сургуульд амжилттай бэлтгэж чадсан байсан (Дэлхийн Банк, 2017). Энэ нь бусад эцэг эхчүүд энэ хөтөлбөрөөр хүүхдээ сургуульд бэлтгэх бүрэн боломжтой гэсэн үг юм. Улмаар бага боловсролын тэгш хамрагдалт, цаашилбал нийгмийн тэгш байдалд нөлөөлөхүйц үр дүнтэй хөтөлбөр юм.

### 2.4.2. Зорилт 2-ын хүрээнд туршсан шинэ санаачилга, сайн туршлагын тогтвортой байдал

ХБЦНХ ба Хүүхэд хөгжлийн танхимын тогтвортой үлдэх чадавх бий болсон эсэх болон нутагшуулах боломжийг үнэлэхдээ оролцогчдын 58% ба 61,9% нь маш сайн, 27,3% ба 20% нь сайн, 13,7% ба 15,5% нь хангалттай хэрэгжсэн гэж, 1-2,6% нь сайжруулах шаардлагатай тус тус үнэлсэн.

**График 13. ХБЦНХ-ийн 1. Тогтвортой чадавх бий болгосон, 2. Нутагшуулах боломж, 30 сумын үнэлгээний нэгтгэл**







### А. ХБЦНХ-ийг үндэслэн дотуур байрын үйл ажиллагаа, орчин нөхцөлийг сайжруулсан.

ХБЦНХ-ийг үндэслэн дотуур байрын хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөр, хүүхэд хөгжлийн үйл ажиллагааг хөгжүүлэх боломжтой. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд их зардал хөрөнгө шаардлагагүй. Зөвхөн аргазүйг түгээн дэлгэрүүлэх сургалт, туршлага солилцох үйл ажиллагааг зохион байгуулахад хангалттай юм. Зарим аймагт дотуур байрын туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор туршлага солилцох зөвлөгөөнийг аймгийн БСУГ-аас зохион байгуулж байгааг тогтмолжуулах боломжтой (Дорнод ТОНЗ).

Төслийн бус аймгууд дотуур байрын болон бага ангийн багш нарт хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөрийн дагуу сургалт зохион байгуулсан. Цаашид түгээн дэлгэрүүлэхийн тулд дотуур байрын багшийн аргазүйн зөвлөмжийн дагуу үндэсний хэмжээнд үе шаттай сургалт зохион байгуулахаар төлөвлөж байна (БСШУСЯ-ны илтгэл, Төслийн хаалтын хэлэлцүүлэг, 2017/05/29).

ХБЦНХ-ийг БСШУСЯ-ны вебсайтад байрлуулсан ба багш бэлтгэх боловсролын байгууллага, дотуур байрын багш бэлтгэх сургалтууд, дотуур байрын орчин нөхцөлийг сайжруулах үүрэг, зорилго бүхий бусад оролцогч талууд, бүлгийг татан оролцуулж хамтран ажиллах боломжтой.

### 2.4.3. Бага боловсрол нөхөн олгох хөтөлбөрийн тогтвортой байдал

ББНОХ-ийн тогтвортой үргэлжлэх чадвар, нутагшуулах боломжийг оролцогч талуудын үнэлгээгээр 65,% ба 62,3% нь маш сайн, 24,5% ба 23,8% нь сайн, 9,6% ба 12% нь хангалттай хэрэгжсэн гэж, 1% нь сайжруулах шаардлага бий гэж үнэлсэн нь өмнөх хоёр хөтөлбөрийн тогтвортой байдлын үнэлгээтэй харьцуулахад арай илүү үнэлсэн байв.

**График 14. ББНОХ–ийн 1. Тогтвортой чадавх бий болгосон, 2. Нутагшуулах боломж, 30 сумын үнэлгээний нэгтгэл**




Цаашид энэ хөтөлбөрийг "бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтад ашиглах бүрэн боломжтой" гэж оролцогч талууд үзэж байна.

ББНОХ нь НТБ-ын төв дээр, НТБ-ын багш нараар дамжин хэрэгжиж байгаа нь шинээр бий болсон энэхүү төвүүдийг чадваржуулах, цаашид тогтвортой үйл ажиллагаа явуулах, сургууль завсардсан хүүхдүүдтэй ажиллах аргазүйд суралцахад нь дэмжлэг болсон. Энэхүү хөтөлбөр нь хөдөөгийн малчдын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг бага боловсролд хамруулах, илрүүлэх талаар туршлага, мэдлэгийг хуримтлуулсан. Мөн НТБ-ын багш нарын ихэнх нь биеийн тамирын багш нар байдаг тул эдгээр багш нарыг бага боловсролын заах аргазүйд сургасан байна.

Багш нар энэ ур чадвараа ашиглан насанд хүрэгчдэд бичиг үсгийн сургалт явуулж, бичиг үсгийн боловсрол доогуур эцэг эхийг давхар амьдрах ухааны сургалтад хамруулж байна.

### 2.4.4. Төслийг хэрэгжүүлэх явцад олон нийтийн оролцоо, талуудын хамтын ажиллагааг идэвхжүүлсэн

Төслийг Японы Хүүхдийг Ивээх Сан (ХИС), өөрийн орон нутаг дахь салбаруудаараа дамжуулан хэрэгжүүлсэн. Төслийн хүрээнд Төслийн удирдах зөвлөл (ТУЗ), Техникийн зөвлөх баг (ТЗБ), зорилтот 4 аймагт Төслийн орон нутгийн зөвлөл (ТОНЗ), зорилтот 30 суманд Олон нийтийн боловсролын зөвлөл (ОНБЗ)-үүд тус тус байгуулагдаж, төслийн хэрэгжилтэд өөр өөрийн үүрэгтэйгээр оролцсон.

### A. Төслийн үндэсний түвшний оролцогч талуудын үүрэг оролцоо

Хүүхдийг Ивээх Сан (ХИС) хэрэгжүүлэгч байгууллагын хувьд төслийн удирдлага, аргазүйгээр хангаж ажилласан. ХИС-гаас Боловсролын хөтөлбөрийн менежер, 2 төслийн ажилтан, хяналт шинжилгээ үнэлгээний мэргэжилтний бүрэлдэхүүнтэй Төслийн баг төслийг удирдан хэрэгжүүлсэн. Төслийн менежер болон багийн гишүүд нь боловсролын салбарт, ялангуяа тэгш хамруулах боловсролын чиглэлээр мэргэшсэн туршлагатай баг байсан. Төслийн баг хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн дагуу төслийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, ахиц, дэвшлийг үнэлэн улирлын болон жилийн тайлангуудад тусгаж, холбогдох талуудад тайлагнадаг. Төслийн баг орон нутгийн онцлог хэрэгцээнд суурилан шаардлагатай өөрчлөлтийг хийж байсан. Тухайлбал, сургууль завсардсан хүүхдүүдийн тоо төслийн үйл ажиллагаа төлөвлөж байсан 2009 оноос хойш эрс багассан нь ББНОХ-ийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд чиглүүлэх шаардлагыг харуулж байсан учраас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан ном, тоглоомын багцыг бэлдэн гаргасан.

Дэлхийн Банкны төслийн багийн ахлагч болон худалдан авалт, санхүүгийн аудит зэрэг тусгайлсан мэргэжилтнүүд Төслийн Удирдах Зөвлөлийн гишүүдтэй хамтран төслийн явцад төслийн багт болон орон нутгийн зөвлөлүүдэд зөвлөн тусалж дэмжин ажилласныг орон нутгийн хэлэлцүүлгүүдэд сайшаан тэмдэглэж байсан. Дэлхийн Банкнаас жилд 2 удаа тодорхой аймаг, сумыг сонгон зөвлөн туслах айлчлалыг тогтмол хийдэг ба энэ үеэр “шалган байцаах” биш “зөвлөн туслах” аргачлал ашиглаж, төслийн хэрэгжилтийн явцыг хамтран хэлэлцэж, цаашид сайжруулах зөвлөмжийг өгч ажилласан нь үр дүнтэй байсан байна. Төслийн явцад тулгарсан худалдан авалт, гэрээт зөвлөхүүдийн ажлыг удирдах,

санхүүгийн удирдлагатай холбоотой хүндрэл бэрхшээлийг хэрхэн шийдэх, сайжруулахыг Дэлхийн Банкнаас зөвлөж ажилласан нь ХИС-гийн төслийн удирдлага, худалдан авах үйл ажиллагаа, санхүүгийн удирдлагыг бэхжүүлсэн.

Төслийн Удирдах Зөвлөл ТУЗ нь төслийн хэрэгжилтийг стратеги удирдлагаар хангах, салбарын болон салбар хоорондын, бусад хандивлагч байгууллагуудын уялдааг хангах, төсөлд оролцогчдын хариуцлагатай байдлыг сайжруулах, төслийн хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй. Зөвлөлийн бүрэлдэхүүнд төсөл хэрэгжүүлэгч болон хамтрагч байгууллагууд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, зорилтот аймгуудын Боловсрол, соёл, урлагийн газрын дарга, бусад холбогдох байгууллагуудын төлөөлөл багтан ажилласан. Шат, шатны боловсролын байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн энэхүү зөвлөлийг БСШУСЯ-ны Сургуулийн өмнөх, бага боловсролын хэлтсийн дарга болон ХИС-гийн Монгол дахь захирал нар хамтран ахалсан.

Харин Техникийн зөвлөх баг (ТЗБ) нь төслийн үйл ажиллагааг төрөөс баримталж буй боловсролын бодлого, үйл ажиллагаатай уялдуулан зохицуулах, мэргэжлийн удирдлага, дэмжлэгээр хангах, төслийн хүрээнд боловсруулан гаргах аливаа бүтээгдэхүүнд техникийн үнэлэлт, дүгнэлт өгөх, төслийн багт техникийн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх чиг үүрэг бүхий 35 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулагдан ажилласан.

### Б. Сумын Олон нийтийн боловсролын зөвлөл нь засаг захиргааны болон боловсролын байгууулагын уялдаа, эцэг эхийн оролцоог хангасан

Төслийн хүрээнд сумын түвшинд Олон нийтийн боловсролын зөвлөл (ОНБЗ) гэсэн шинэ бүтцийг турших хэрэгжүүлсэн. Төслийн баримт бичигт энэхүү бүтцийг туршихаар төлөвлөсөн байсан.

| Статус | Дунд хугацааны үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд | Суурь үзүүлэлт | Эцсийн үзүүлэлт | Хэрэгжилт |
|---|---|---|---|---|
| Хэвээрээ | 30 суманд ОНБЗ байгуулагдаж, олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагааг явуулж байна | 0 | 30 | 30 |

Сумдын ОНБЗ өөр өөрийн сум, багт байгаа төслийн зорилтот хүүхдүүдийг тодорхойлох, тэдний болон эцэг эхийн нөхцөл байдал, хэрэгцээг тодорхойлох, тэдэнд чиглэсэн үйл ажиллагааг өөрсдийн нөөц боломжийг ашиглан сумын хэмжээнд санаачлан хэрэгжүүлэхэд эцэг эх, орон нутгийн иргэд, удирдлагууд болон холбогдох боловсролын байгууллагуудын идэвхтэй оролцоог хангах замаар тэдний санал санаачилгыг дэмжин идэвхжүүлэх, төслийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, үр дүнтэй, тогтвортой хамтын ажиллагааг бий болгох үүрэгтэй оролцсон болно. ОНБЗ нь сум бүрт

сумын онцлогоос хамааран өөр өөр бүтэц бүрэлдэхүүнтэй байгуулагдсан ба сумын ЗДТГ, сургуулийн захирал, менежер, багш, цэцэрлэгийн эрхлэгч, багш нар, эцэг эхийн төлөөллөөс бүрдсэн 304 хүн төслийн хугацаанд ОНБЗ-ийн бүрэлдэхүүнд ажилласан байна. ОНБЗ-ийн гишүүд төслийн гурван зорилт тус бүрийн хүрээнд ажил үүргээ хуваарилан 3 дэд зөвлөлд хуваагдан ажилласан нь илүү оновчтой болсон байна.

Сайн дурын, орон тооны бус ОНБЗ-ийн бүтцийг туршсан хугацаанд орон нутгийн засаг захиргааны байгууллага, үүнд сумын ЗДТГ, багийн засаг дарга нар болон сургууль, цэцэрлэг болон эцэг эхийн төлөөлөл бага насны хүүхдийн хөгжил, боловсролын төлөө хоорондоо хэрхэн уялдаатай хамтран ажиллаж болохыг харуулсан байна. Мөн хамтын ажиллагаа нь сургууль, цэцэрлэгийн удирдлага, багш нар, эцэг эхчүүдэд урам зориг өгсөн.

Төслийн үр шимийг хүртэгчид өмнө нь салангид байсан бүтэц, үйл ажиллагааг эцэг эхчүүдтэй холбож, хүүхдийн боловсролын төлөө түншлэлийг бий болгосон гэж үнэлж байв.

**График 15. Олон нийтийн боловсролын зөвлөл (ОБНЗ)-ийн талаар ойлголт /Өмнө нь салангид байсан бүтцийг эцэг эхчүүдтэй холбож уялдуулж өгсөн гэж үздэг/**



**Зураг 7. ОНБЗ–ийн үйл ажиллагааны хүрээ, Архангай аймгийн Өлзийт сум**




Олон нийтийн оролцоог хангах нь төслийн тогтвортой байдлыг хангахад чухал юм. Цаашид ОНБЗ-ийн үйл ажиллагааг эцэг эхийн зөвлөлийн бүтэцтэй уялдуулан авч үлдэх боломжтой.

### B. Төслийн Орон Нутгийн Зөвлөл (ТОНЗ) нь аймгийн ЗДТГ, БСУГ-ын хамтын ажиллагаа, оролцоог хангаж өгсөн.

Аймгийн ТОНЗ нь тухайн орон нутаг дахь төслийн үйл ажиллагааны хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, салбарын болон орон нутгийн бодлого, бусад хандивлагч байгууллагын үйл ажиллагаатай уялдуулах, төслийн хэрэгжилтийн явцад төсөл хэрэгжүүлэгч болон түншлэгч байгууллагаас дэвшүүлэн тавьсан асуудлыг шийдвэрлэх, төслийн шинэ санаачилга, тэргүүн туршлага, оновчтой санааг түгээн дэлгэрүүлэн цаашид тогтвортой байдлыг хангах, төслийн хэрэгжилтэд хяналт тавих, зөвлөн туслах үүрэгтэй ажилласан. Тус зөвлөл нь аймгийн ЗДТГ, Боловсрол, Соёл, Урлагийн Газрын мэргэжилтнүүд болон бусад холбогдох байгууллагын төлөөллөөс бүрдсэн 7-9 хүний бүрэлдэхүүнтэй ажилласан. ХИС-ийн аймаг дахь салбар нь орон нутгийн зохицуулагчаар ажиллаж, ТОНЗ-той хамтран ажилласан нь ХИС дангаараа хэрэгжүүлснээс илүү тогвортой, үр дүнтэй бүтэц байсан.

ТОНЗ болон БСУГ нь төсөл хэрэгжиж буй зорилтот сумдад гарсан сайн туршлага, аргазүйг бусад сумдад түгээн дэлгэрүүлэхэд чухал үүрэгтэй оролцсон. Цаашид төслийн хүрээнд боловсруулсан аргачлал, сайн туршлагуудыг боловсролын салбарт түгээн дэлгэрүүлэх, нутагшуулахад БСУГ чухал үүрэг гүйцэтгэх юм.

### 2.4.5. Олон нийтийн санаачилгыг дэмжих тэтгэлэгт төсөл

ОБНЗ-ийн үйл ажиллагааг дэмжих чиглэлээр тэтгэлэгт төслүүдийг шалгаруулж хэрэгжүүлсэн нь төслийн зорилтуудыг сумдад хэрэгжүүлэх, ОНБЗ-ийн чадавхийг бэхжүүлэхэд чухал үүрэгтэй байсан. Төсөл хэрэгжих хугацаанд нийт 6 удаагийн санхүүжилтээр 200,338,408 төгрөгийн тэтгэлгийг 138 төсөлд олгож, эдгээр тэтгэлгийн үр шимийг 8648 хүүхэд хүртсэн байна.

| Өөрчлөлт Статус | Дунд хугацааны үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд | Суурь үзүүлэлт | Эцсийн үзүүлэлт | Хэрэгжилт |
|---|---|---|---|---|
| хэвээрээ | 30 ОБНЗ тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдсан байна. | 0 | 30 | 30 |
| Шинээр нэмсэн | Тэтгэлэгт хөтөлбөрийн санхүүжилтээр хэрэгжсэн төслийн тоо | 0 | 100 | 138 |

Тэтгэлэгт төсөл нь богино хугацаатай, тодорхой зорилготой жижиг үйл ажиллагаанд дунджаар 1,8 сая төгрөгийн санхүүжилт өгч байсан нь сайн дурын үндсэн дээр ажиллаж буй ОНБЗ-ийн гишүүдийн идэвх оролцоог нэмэгдүүлэх, орон нутгийн нэн тэргүүний асуудлыг шийдэх хөшүүрэг, урамшуулал болж өгсөн. Тэтгэлгийн хэмжээ хэт их биш байсан нь ОБНЗ-ийн үйл ажиллагааг тэтгэлгээс хараат болгохоос урьдчилан сэргийлж чадсан.

Төслийн эхний үед ОБНЗ нь зөвхөн төслийг хэрэгжүүлэх чиглэлээр ажилладаг байсан бол тэтгэлэгт төсөл хэрэгжүүлэх явцдаа сумын хэмжээнд бага насны

хүүхдийг боловсролд тэгш хамруулах, боловсролын үр дүнг сайжруулахад шаардлагатай байгаа нэн чухал асуудлыг сонгож, тэтгэлэгт төслийн санал боловсруулж байсан. Тухайлбал, ГБОСБХ-ийн тэтгэлгүүд нь гэрийн эргэлт хийх зардлыг олгож байсан бол ХБЦНХ-ийн тэтгэлгүүд нь хүүхдийн авьяас, сонирхол, хоббиг хөгжүүлэх замаар суралцах сонирхлыг нь нэмэгдүүлэхэд тусалсан.

Жишээ нь, Архангай аймгийн Өлзийт сумын ОНБЗ “4,5-р ангийн Математикийн хичээлийн хоцрогдолтой 30 хүүхдэд *Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх нь* тэтгэлэгт төсөл хэрэгжүүлснээр хүүхэд нэг бүрийн чадварт гарааны үнэлгээнээс 10-25%-ийн ахиц гарсан байна”.

“ББНОХ-ийн хүрээнд бичиг үсгийн боловсрол сул 12 эцэг эх, 6 хүүхдэд тэтгэлэгт төслийн хүрээнд Математик, Монгол хэлний багцыг судлуулсан.” (Архангай аймгийн Өлзийт сумын ОНБЗ)

Түүнчлэн ОНБЗ-ийн гишүүд олон нийтийн санаачилгын төслийн санааг боловсруулах, төслийг бичих явцдаа тодорхой мэдлэг, туршлага олж авсан тул Дэлхийн Банкны санхүүжилттэй хэрэгжиж буй Боловсролын чанарын шинэчлэл төслийн хүрээнд зарласан тэтгэлэгт хөтөлбөрт төсөл нь шалгарч үйл ажиллагаагаа үргэлжүүлж байгаа олон сум байв.

## Хүснэгт 24. Олон нийтийн санаачилгыг дэмжих тэтгэлэгт хөтөлбөрийн жагсаалт, ХИС

| аймаг | 2014-2016 | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Үе шат | I | | | | II | | | | III | | | | IV | | | | V | | | | VI | | | | | |
| | Сум | Зорилт | Хүүхдүүд | | | Зорилт | Хүүхдүүд | | | Зорилт | Хүүхдүүд | | | Зорилт | Хүүхдүүд | | | Зорилт | Хүүхдүүд | | | Зорилт | Хүүхдүүд | | | Хэрэгжиж байгаа | |
| | | | эр | эм | Бүгд | | эр | эм | Бүгд | | эр | эм | Бүгд | | эр | эм | Бүгд | | эр | эм | Бүгд | | эр | эм | Бүгд | | |
| Архангай | Жаргалант | | | | | 2 | 30 | 30 | 60 | 2 | 15 | 15 | 30 | 1 | 12 | 18 | 30 | | | | | 3 | 5 | 2 | 7 | ✓ | 127 |
| | Өлзийт | 2 | 11 | 19 | 30 | | | | | 2 | 11 | 19 | 30 | 1 | 19 | 6 | 25 | | | | | 1,2 | 22 | 18 | 40 | ✓ | 125 |
| | Өндөр-Улаан | 2 | 23 | 14 | 37 | 2 | 6 | 13 | 19 | 2 | 16 | 12 | 28 | 1 | 20 | 10 | 30 | 3 | 4 | 1 | 5 | 1.2.3 | 40 | 50 | 90 | ✓ | 209 |
| | | | | | | | | | | | | | | | | | | | | | | 2 | 50 | 0 | 50 | ✓ | 50 |
| | Тариат | | | | | | | | | 2 | 15 | 10 | 25 | 1 | 14 | 11 | 25 | 3 | 14 | 8 | 22 | 2,3 | 10 | 15 | 25 | ✓ | 97 |
| | Хайрхан | 1 | 15 | 13 | 28 | | | | | 2 | 8 | 12 | 20 | 1 | 16 | 12 | 28 | 2 | 16 | 20 | 36 | 2 | 13 | 12 | 25 | ✓ | 137 |
| | Хангай | | | | | 2 | 25 | 11 | 36 | 2 | 25 | 18 | 43 | 1 | 13 | 12 | 25 | | | | | 1 | 16 | 14 | 30 | ✓ | 134 |
| | Хашаат | 1 | 8 | 18 | 26 | | | | | 2 | 29 | 24 | 53 | 1 | 17 | 19 | 36 | | | | | 2 | 81 | 75 | 156 | ✓ | 271 |
| | Хотонд | | | | | 2 | 11 | 13 | 24 | 2 | 18 | 16 | 34 | 1 | 23 | 18 | 41 | | | | | 2,3 | 100 | 94 | 194 | ✓ | 293 |
| | Цэцэрлэг | | | | | 2 | 14 | 10 | 24 | 2 | 15 | 39 | 54 | 1 | 16 | 14 | 30 | | | | | 1.2.3 | 38 | 22 | 60 | ✓ | 168 |
